



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ШУДАРГА ЁС

2025/01 (29)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга:

Л.Түвшинбат, АТГ-ын США-ны дарга, ахлах комиссар

Гишүүд:

Г.Азжаргал, АТГ-ын дэд дарга, эрхэлсэн комиссар

Р.Баярмагнай, АТГ-ын хэлтсийн дарга, доктор (Ph.D), эрхэлсэн комиссар

Ч.Жаргалбаатар, АТГ-ын МШХ-ийн албаны дарга, ахлах комиссар

Б.Баярсайхан, АТГ-ын ХШДШХ-ийн албаны дарга, ахлах комиссар

Д.Цэнд-Аюуш, АТГ-ын УССГХ-ийн ахлах ажилтан, ахлах комиссар

Б.Билэгт, АТГ-ын ТХ-ийн ажилтан, комиссар

Нарийн бичгийн дарга:

Ц.Бадам, АТГ-ын США-ны ахлах ажилтан, ахлах комиссар

©Авлигатай тэмцэх газар, 2025 он

Энэхүү эмхэтгэлд орсон бүтээлийг бүхэлд нь болон хэсэгчлэн ашиглахад зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай Монгол Улсын хуулийн холбогдох заалт үйлчилнэ.

ISSN 2791-3619

Цаасны хэмжээ: B5

Хэвлэлийн хуудас: 18

Хэвлэсэн тоо: 500

Хэвлэлийн газар: Урангар пресс ХХК-ийн хэвлэх үйлдвэр

АГУУЛГА

СУДЛААЧДЫН ИЛТГЭЛ

Эрүүгийн хуулийн 18.6 Зүйлд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд хуулийн зохицуулалтыг сурталчлах, хууль, эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага

Ч.Жаргалбаатар

5

Дижитал инновацын шийдлийг авлигын эсрэг ашиглах боломжийн судалгаа

А.Сүх

23

Монгол улс дахь гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны шинэчлэл, үйл ажиллагаа, чиг хандлага

Х.Батбаяр

35

Авлигатай тэмцэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг, оролцоо

Т.Мөнхтунгалаг

52

**Цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд
хиймэл оюун ухаан ашиглах нь**

Р.Баярмагнай, Б.Батхуяг

65

Авлигын эсрэг сэтгэл зүйн дархлаа бүрдүүлэх асуудалд

П.Дэлгэрмаа

73

**Авлигыг бууруулах зорилгоор бэлэн мөнгөний
гүйлгээг хязгаарлах нь**

Т.Мөнхжаргал

88

**Мөнгө угаах гэмт хэргийн нөхцөл байдал,
тулгамдаж буй асуудал**

Б.Батхуяг

121

**Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжид хууль бусаар
хөрөнгөжих гэмт хэргийг тодорхойлж байсан
түүхэн уламжлал**

О.Отгонтуяа

130



Ч.ЖАРГАЛБААТАР

*Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн
Албаны дарга, ахлах комиссар*

**ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 18.6 ЗҮЙЛД ЗААСАН ГЭМТ
ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ИРГЭДЭД ХУУЛИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫГ СУРТАЛЧЛАХ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН
МЭДЛЭГ, БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ
ШААРДЛАГА**

*Төр баригчид удирдан захирахад нь тусалдаг сайдуудтай,
тэдний туслахууд нь туршлагатай бол ард олон аюулгүй,
харин тэд нь сул, дорой бол ард олон эрсдэлд нэрвэгдэж
байдаг болой. Гуйлгачин улс оронд баян байх нь гутамшигтай
явдал¹.*

Түлхцэр үг. Мөнгө угаах гэмт хэрэг, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, эрх зүйн бүх нийтийн боловсролыг дэмжих, хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх.

Keywords: Money laundering crime, crime prevention, advertising legislation, enhancing citizens' legal knowledge and education, supporting public legal education, ensuring consistent interpretation and application of the law.

Хураангуй. Эрүүгийн хуулийн 18.6 зүйлд хуульчлагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэрэгцээ шаардлагын хүрээнд иргэдэд хуулийн зохицуулалт, нийгмийн хор аюулыг сурталчлан (ойлгуулах), таниулах, одоо

¹ Сүнз. Дайтах урлаг. Орос хэлнээс орчуулсан Ч.Баатар. 2018 он Мон судар ХХК. 17, 55 талд

хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрүүгийн хуулийн “Мөнгө угаах” гэмт хэргийн шинж хөгжлийн чиг хандлагад нийцэх эсэх, хэрэг хянан шийдвэрлэхэд гарч буй хийдлийг илрүүлэх замаар хуулийг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлнэ.

Abstracts: Within the framework of the need to prevent crimes as stipulated in Article 18.6 of the Criminal Code, this involves advertising and explaining legal regulations and societal dangers to citizens, assessing whether the provisions of the current Criminal Code on “Money Laundering” align with evolving trends in the crime, and proposing improvements to the law by identifying gaps in its implementation during case proceedings.

I. Удиртгал.

Хуулийг нэг мөр ойлгож, Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх нь иргэний үүрэг. Иргэн Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, гэмт хэрэг зөрчлийн шинж бүхий үйлдэл хийхээс татгалзахад хуулийн зорилт, хор уршгийг ойлгодог байх шаардлагатай. Хуулийн шаардлага үндэслэгээнд суурилан Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 7 дахь хэсэгт² заасан үндсэн бүрэн эрх, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн³ 14 зүйлийн 7 дахь хэсэгт “Нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ” авах эрхийг хуульчилсан. “Мөнгө угаах” гэх ойлголтын талаар иргэдээс асууж тандан судлахад төрийн өмчийг хөрөнгийг албан тушаалтнууд завшсан, үрэгдүүлсэн, Албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон фактаар буюу “Хөгжлийн банкны, Боловсролын зээлийн сан, Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжүүлэх сангийн хөрөнгийг угаасан буюу дур зорго, хяналтгүй зарцуулалт гэх агуулгаар, Гаалийн улсын байцаагч, Татварын байгууллагын эрх бүхий албан хаагч, Шийдвэр гүйцэтгэгч нарт холбогдох 3 эрүүгийн хэргийн шалтгаан нөхцөлийг судлан үзэхэд аав, ээж, ах, эгч дүү, үеэлүүд, эхнэр, нөхөр хүүхдүүдийнхээ иргэний арилжааны банкны данс карт, цахим данс удирдах нэр нууц үгийг түр хугацаагаар ашиглуулах хүсэлт тавьсан, дансаа ашиглуулсан хүмүүс ямар зорилгоор хэрхэн ашиглах талаар асуугаагүй, ашиглахгүй байгаа

² Монгол улсын Үндсэн хууль: 1992 он. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

³ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль. 1993.05.06 батлагдсан.

дансаа картаа шилжүүлэн өгсөн болох нь тогтоогдсон бол нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд “... Авлигатай тэмцэх газар хэрэг бүрд мөнгө угаах гэсэн давхар зүйлчлэл хийж хүмүүсийн эрх зүйн байдал дордуулдаг гэх шүүмжлэл илэрхийлсэн.

Иргэн, нийтийн албан тушаалтан, бодлого боловсруулах, хууль тогтоох эрх бүхий хүмүүс буюу бүгд мөнгө угаах гэмт хэргийн талаарх нэгдсэн ойлголтгүй байна. Иймд мөнгө угаах гэмт хэргийн хор хөнөөл, эрүүгийн хариуцлагын талаар иргэдэд, нийтийн албан тушаалтан гэж ялгахгүйгээр мэдлэг түгээх шаардлагатай.

Хуулийг хэрэгжүүлэхгүй байх нь хуулийг үл тоомсорлоход хүргэдэг бөгөөд энэ үед гэмт хэрэг өсдөг. Хуулийг нэг мөр хэрэгжүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шилдэг арга. Хууль хүчгүй байснаар ял шийтгэл оноох нь дур зоргод, өршөөл уучлал газар авч ял завшдаг, ойлгомжгүй процесс гэмт этгээдэд давуу байдал олгож дахин гэмт хэрэг үйлдэх урам зориг болж өгдөг⁴. 1955 он Journal of criminal Law and Criminology. Pioneers in Criminology VII Jeremy bentham 1955.

II. бодит байдал

Улсын ерөнхий прокурорын газраас санаачлан Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам сэдэвт Олон улсын эрдэм⁵ шинжилгээний хурлыг Улаанбаатар хотноо 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Хуралд оролцогч нарын бүтээл, дэвшүүлсэн санаанд дүн шинжилгээ хийлээ. Үүнд

Хууль зүй дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган: “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал” сэдэвт бүтээлдээ “... Тухайлбал ахуйн хүрээнд үйлдэгддэг хулгайлах, дээрэмдэх, гэмт хэргийг үйлдэж олсон мөнгө, хөрөнгө гэдгийг мэдсээр байж худалдаж авсан, ашигласан, эзэмшсэн бол мөнгө угаах гэмт хэргээр зүйлчлэгдэж байгаа нь Эрүүгийн хуулийн тусгай ангид

⁴ Батдуламын Мөнх-Эрдэнэ. Гэмт хэрэг судлалын онол. 2021 он. Жереми Бентам: 1747–1832) Английн ёс суртахууны философич, эрх зүйн онолч.

⁵ Улсын ерөнхий прокурорын газраас санаачлан Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл 56 талд

заасан Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг хангаж байгаа ч Мөнгө угаах гэмт хэргийн үндсэн зорилгод нийцэхгүй байна гэж дүгнээд “суурь гэмт хэргийг нэрлэлгүйгээр гэмт хэргийн ангилал буюу оногдуулж болох ялын хэмжээг баримталсан нь Эрүүгийн хуульд заасан бусад олон төрлийн гэмт хэргийг, тухайлбал ахуйн хүрээний, хэргүүд болох хулгай, дээрэм, залилах гэх мэт хэргийн замаар олсон зүйлийг хадгалсан этгээд мөнгө угаах гэмт хэргээр ял шийтгүүлэх нөхцөл бүрдсэн⁶, Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн байгууллагаас Монгол улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хийсэн 2 дахь удаагийн харилцан үнэлгээний тайланд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагааг дүгнэхдээ “Цагдаагийн байгууллагаас мөнгө угаах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа суурь гэмт хэргийн хувьд дийлэнхдээ хулгайлах, залилах гэмт хэрэгтэй холбоотой байна. Бидний үзэж байгаагаар Монгол улсын тухайд мөнгө угаах гэмт хэргийн өндөр эрсдэлтэй байгаль орчны эсрэг гэмт хэрэг, татвараас зайлсхийх гэмт хэрэгт мөнгө угаах үйл ажиллагааг мөрдөн шалгах ажиллагаа хангалтгүй гэжээ⁷, Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгчдийн эцсийн зорилго нь хууль бусаар олсон мөнгөө чөлөөтэй ашиглах явдал байдаг. Ингэж чөлөөтэй ашиглахын тулд санхүүгийн болон хуулийн байгууллагын хараанд өртөлгүй, зохион байгуулалтайгаар мөнгө хөрөнгөө олон шат дамжлагаар хувиргадаг бөгөөд мөнгө угаах үйл ажиллагаа нь тогтсон нэг арга хэлбэрээр илэрдэггүй. Учир нь ФАТФ тодорхойлсноор 3 үе шатыг дамжиж мөнгө угаадаг бөгөөд эдгээр үе шатуудыг хангахгүй бол мөнгө угаах гэмт хэрэг гэж үздэггүй...

Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн: “Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тооцох аргачлал ял оногдуулах асуудал” сэдэвт бүтээлдээ” ...суурь гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус хөрөнгө орлогоо өөрөө эргэлтэд оруулсан, нуун дарагдуулсан буюу хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулахад арифметик аргыг баримтлахаас татгалзах учир холбогдол, хохирол багатай зарим өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг буюу хөрөнгө завших, алдаатай гүйлгээ андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө алдуул мал завших зэрэг гэмт хэргүүдийг суурь гэмт хэргээс хасах санал дэвшүүлсэн,

Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Сургалт судалгааны

⁶ Х.Эрдэм-Ундрах, Х.Мөнхболд, Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн тулгамдсан асуудал” Эрдэм шинжилгээний өгүүлэл. У6, 2020 он_5 дахь тал. “

⁷ Asian/Pacific Group on money Laundering (APG). Anti-money laundering and counter-terrorist financing measures; Mongolia. Mutual Evaluation Report. September 2017.58 pp.

хүрээлэнгийн захирал, доктор дэд профессор Б.Бат-Орших: “Мөнгө угаах гэмт хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудал сэдэвт бүтээлдээ” ...104 прокурор 52 эксперт нийт 152 хүний оролцуулан хийсэн судалгаагаар Эрүүгийн хуульд тусгагдсан мөнгө угаах гэмт хэргийн шинж нь олон улсын гэрээ, конвенцод нийцэхгүй байна гэж 57,1% нь, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхэд 53.5% нь тийм гэж, суурь гэмт хэргийг тодорхой болгох шаардлагатай гэж 84.6% санал өгсөн үр дүнг⁸ танилцуулсан.

Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш БНТУ-ын Кожаэли их сургуулийн докторант Б.Дожсан: “Мөнгө угаах гэмт хэргийн ерөнхий ойлголт, зарим улсын Эрүүгийн хуулийн зохицуулалттай харьцуулан авч үзэх нь сэдэвт бүтээлдээ” бохир мөнгө гэдгийг тодорхойлох, суурь гэмт хэргийг ихэнх улс орон зааж өгсөн байдаг бөгөөд зарим улсад үйлэгдсэн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээ, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөн хөрөнгийн хэмжээг харгалзан олсон орлогыг хууль ёсны санхүүгийн тогтолцоонд нэвтрүүлэх явдлыг өөрийн улсын онцлогт нийцүүлэн хуульчилсан хэм хэмжээнүүдээр тус тус мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэж байна⁹.

Шихихутаг их сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч доктор Б.Мөнх-Эрдэнэ Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт ба хууль ёсны зарчмын хэрэгжилт тулгамдаж буй асуудал¹⁰ сэдэвт бүтээлдээ ... хууль зүйн бодлогын чанар өндөр шалгууртай байх тусам зарчимтай зөрчилдөх хэм хэмжээ багасна. Мөн эсрэгээр эрүүгийн эрх зүйн бодлого нь тодорхойгүй сул байх тусам хууль эрх зүйн тогтолцоо нь ихэвчлэн хувь хүн эсвэл тэдний бүлгийн эрх сонирхлоор тодорхойлогддог, эмх замбараагүй хэм хэмжээнээс бүрдэж хууль ёсны зарчим хуулийн гадна үлддэг. Эрүүгийн хуульд батлагдсан хэд хэдэн өөрчлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлаагүйн улмаас эрүүгийн хууль, хууль ёсны зарчимтай зөрчилдөж байна. ... хууль ёсны зарчим, тэдгээртэй зөрчилдөж буй хэм хэмжээг нэг мөр ойлголтын зөрөөгүй болгох асуудал өнөөдөр чухлаар тавигдаж байгаа бөгөөд тэр дундаа мөнгө угаах гэмт хэргийн жишээн дээр зарчмын хэрэгжилтийг хангах хангах асуудлыг судлан

⁸ Улсын ерөнхий прокурорын газраас санаачлан Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл 146 талд:

⁹ Эмхтгэлийн 164 талд.

¹⁰ Эмхтгэлийн 179-190 талд

Мөнгө угаах гэмт хэргийг оновчтой томьёолж чадаагүй, иргэд данс мэдээллээ ашиглуулан гэмт хэрэгтэн болох эрсдэлийг дагуулж буй тул иргэдийн эрх зүйн мэдлэг ухамсрыг дээшлүүлэх хэрэгцээ байгааг тодорхойлсон,

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн, сургалт судалгааны төвийн Хувийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Г.Болор-Эрдэнэ “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн тулгамдаж буй асуудал¹¹” сэдэвт бүтээлдээ “... өмчлөх эрхийн жижиг гэмт хэргүүд болон зохион байгуулалттай, олон шатлалт гэмт хэргийг ялгаж зүйчлээгүй дээр дурдсан шүүхийн практикаас харагдаж байна, мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлийн хувьд оновчтой эсэх нь эргэлзээтэй... хохирол ихтэй, зохион байгуулалттай гэмт хэргийг хамруулахгүй байвал Монгол улсын Мөнгө угаах тогтолцоо буруу замаар явах, олон улсын эдийн засгийн нөхцөл байдал зэрэгт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм гэж дүгнэжээ.

Хууль зүй дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Сургалт судалгааны хүрээлэнгийн захирал, Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, Шихихутаг их сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн, сургалт судалгааны төвийн Хувийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан, хууль сахиулагч нарын тус тусдаа хийсэн судалгаагаар мөнгө угаах гэмт хэргийн объектив талын шинжийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлж чадаагүй, эрүүгийн хууль хийдэлтэй болохыг тодорхойлжээ. **Хийдэлтэй хуулийг олон нийтэд сурталчлан (ойлгуулах), таниулах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ямар ч боломж бололцоогүй. Хуулийг хийдлийг арилгаад мэдээлэл түгээх шаардлагатай.**

Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт, мөн хуулийн 18.6 зүйл, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүдэд зохион байгуулалттай гэмт бүлэг, бүлэглэл зүйлчлэл хийхээр

- I. Хэрэгт холбогдсон этгээдүүд би хүн алаагүй, хүрээ талаагүй гэж үгүйсгэх,
- II. Иргэд болохоор Монгол улсад Америк, Итали, Мехико, Колумбид хүчирхэгжиж төр засаг, хууль шүүхийн шийдвэрт нөлөөлж байсан зэвсэгт бүлэглэл одоогоор арай байгуулагдаагүй ээ гэж,

¹¹ Эмхэтгэлийн 201-214 талд

Эрүүгийн хуулийн 18.6 зүйлд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд хуулийн зохицуулалтыг сурталчлаж, хууль, эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага

III. Хуульч нар нь манай улсад гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн, тогтвортой нэгдлийг зохион байгуулалттай гэмт бүлгийн бүртгэл, үйл ажиллагааг тодорхойлсон баримтууд шаардах, дүгнэх жишээтэй.

Тэгтэл бидний мэддэг дайн (сэлэм жад, галт зэвсэг барьсан цэргүүд, хүчит техник бүхий армийг төсөөлдөг) хэлбэр дүрсээ өөрчлөөд эдийн засгийн, пуужин, нисгэгчгүй онгоцоор дайтах болсонтой адил зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл хүртэл хэлбэр дүрс, зохион байгуулалтаа өөрчилсөн, байнга гэмт хэрэг үйлдэх бус нэг удаагийн зохион байгуулалт бүхий гэмт үйлдлээр их хэмжээний орлого олох боломж бүрдсэн тул мөнгө угаах гэмт үйлдлийн шинжийг оновчтой тодорхойлох хууль сахиулагч, хуульч, хууль тогтоогч нар **МӨНГӨ УГААХ гэмт хэргийн талаар нэгдсэн ойлголттой болох, хуулийг иргэдэд сурталчлан таниулах шаардлагатай.**

Сэтгэл хөдлөл нэг л зориулалттай. ... халуун зууханд хүрэхэд өвдөх өвдөлт танд дахин хүрэхгүй байхыг заадаг..... Та ямар хүн бх зүйлээ сэтгэл хөдлөлөөрөө шийддэгийг мэдэх үү. Гурван настай хүүхэд бас нохой. Тэд өөр юу хийж чаддаг гээч хивсэн дээр бие засдаг¹².

III. Нэмэлт өөрчлөлт ба үр нөлөө.

Эрүүгийн хуульд оруулсан зарим нэмэлт өөрчлөлт улс төрчдийн хүсэл сонирхолд нийцсэн, шаардлага хүргүүлсэн иргэдийн нүдийг хуурсан, мэдэхгүй хүмүүсийг төөрөгдүүлсэн өөрчлөлт болсон. 2022 оны өвөл иргэд Сүхбаатарын талбайд жагсаал хийж эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг дэх гэмт хэрэгт ялын бодлогыг чангаруулахыг шаардсан. Тухайн шаардлагын дагуу оруулсан гэх өөрчлөлт дунд “Тайлбар: –Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно¹³” гэсэн хэм хэмжээ хуульчлагдсан. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 зүйлийн 4.1.”их хэмжээний хохирол” гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг; ойлгож, 1 нэгжийг мөн хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэг нэгж нь нэг мянган

¹² Марк Мэнсон. Тоомжиргүй амьдрах бяцхан урлаг.41 талд.

¹³ Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл.Үндэслэлгүйгээр хөрөнгөжих, 22.4 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хахууль авах. /Энэ тайлбар 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн.

төгрөгтэй тэнцүү байна” гэж тодорхойлсон. Ойлгомжтой байдлаар тайлбарлая гэвэл Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаа дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “**хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй**” гэж хуульчлаад, (*хууль бусаар олсон хөрөнгийг эзэмших, өмчлөх эрхгүй шүү*) гээд байхад 99,999,999 төгрөг хүртэл хууль бус орлого олж эзэмшиж, өмчлөх боломжийг эрүүгийн хуулиар тогтоож боломгүй.

Ял шийтгэл, хохирол, хор уршиг талаасаа 99.999.999.00 төгрөгийг хахуульд авсан хүнд оногдуулах ял шийтгэл, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэж 99.999.999 төгрөгийг хохирол учруулсан үйлдлийн ялгааг харгалзах ёстой. 50,0 сая төгрөг залилсан хүн 2-8 жилийн хорих ял шийтгэгдэнэ. Хоёр дахин их буюу 99.999.999 төгрөг хууль бусаар олж авсан албан тушаалтан адилхан ял шийтгэл хүлээвэл шударга ёс үнэртэн. $50,000.000 = 99.999.999$ тэнцэх боломжгүй, харин ч итгэл хүлээсэн төрийн албан хаагч олон нийтийн итгэл хөсөрдүүлсэн бол хариуцлага хүндрэх нь зүйн хэрэг. Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна, Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэсэнтэй зөрчилдсөн хууль батлагдсан. Жагсагч нарын шаардлагаас Эрүүгийн хуулийн 22 бүлгийн гэмт хэргүүдийн хохирол хор уршгийг дабел хэмжээгээр өсгөөд өгөөч гэсэн шаардлага байгаагүй. 17.6 дугаар зүйл Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэхэд хохирол шаардахгүй таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх зохицуулалттайг харгалзах.

Харьцуулалт:

ЭХТА-ийн 17.3 дугаар зүйл. Залилах	Хэмжээ	Хорих ял
2.Энэ гэмт хэргийг: 2.1.албан тушаалын байдлаа ашиглаж; 2.2.бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 17.4 дүгээр зүйл. Хөрөнгө завших, 2 дахь хэсэг 2.2 ¹⁴ . 17.1 дүгээр зүйл Хулгайлах. 2 дахь хэсэг 2.3 ¹⁵	50,000.001. төгрөг	2-8 жил
ЭХТА-ийн 22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих		
1.Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	99.999.999. төгрөг	1-5жил
22.4 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хахууль авах.		
2.Энэ гэмт хэргийг хясан боогдуулах аргаар үйлдсэн, эсхүл их хэмжээний хахууль авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	99.999.999. төгрөг	5-12 жил

Хууль боловсруулах шатанд судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчим яагаад хэрэгжээгүй вэ? 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл Эрүүгийн хуульд орсон 20 удаагийн өөрчлөлтөөр хийдэл засагдаагүй вэ? хэнд ашигтай вэ? Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлж “тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ

¹⁴ ЭХТА-ийн 17.4 зүйл 2 дахь хэсэг 2.2 бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол

¹⁵ ЭХТА-ийн 17.1 зүйл. 2 дахь хэсэг 2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж;

хийх¹⁶, үнэлгээний дүнг хэлэлцэх асуудыг хэрэгжүүлэхгүй¹⁷ байна вэ? гэсэн асуултууд урган гарч ирлээ.

Мөнгө угаах гэмт хэргийг шинжийг оновчтой тодорхойлж чадсан улс орнуудын сайн жишгийг судлан өөрийн орны онцлогт нийцүүлэн томъёолох эрүүгийн эрх зүйгээр мэргэшсэн судлаачид хангалттай олон байна. Судлаачдаа гадна олон улсын байгууллагууд, мэргэшсэн шинжээчдийн багаас өгсөн зөвлөмж, гарын авлага, судалгааны бүтээлүүд олон байгаа нь хийдэлгүй хууль батлах боломж байгааг илэрхийлнэ. Сэтгээд хуульчилж чадахгүй бол судлаад, хуулаад хуульчилмаар ...

Үйл явдал болоод өнгөрсний дараа түүнийг ойлгоно гэдэг ойлгож буй хэрэг биш, Тэмцэж буй байж зорилгодоо хүрэх нь зорилгодоо хүрч буй явдал биш, ... Хараахан оршоогүй байгаа ямар нэгэн зүйлийг мэдэж байх чадвар, хараахан үйлдээгүй байгаа зүйлийг мэдрэх чадвар, хараахан үүсээгүй, бий болоогүй зүйлийг олж харах чадвар нь харилцан уялдаа холбоотой хөгжинө. Тэр цагт үл ойлгогдох ямар ч зүйл байхгүй болж бүх зүйл зохих ёсны хариултаа олж аван цаг хугацаандаа ашиг тустайгаар хэрэглэгдэнэ. Дайтах урлаг¹⁸.

IV. Зорилго.

Шударга ёс, шударга байх гэдэг ямар агуулга бүхий ойлголт вэ. Зочин хүлээн авах үед хүмүүжил муутай хүүхэд хүмүүжлийн доголдлоо үйлдлээр илэрхийлэх үед (ярианд оролцох, тавгийг идээнээс шүүрэх бас бус үйлдэл) шударга гар вэ, Түгжрэлд ороод зогсож байхад ёс суртахуунгүй балмад этгээд явган хүний замаар, урсгал сөрж өмнөх машинаа гүйцэж түрүүлэхэд шударга гар вэ? хэмээн хэмжүүр тогтоож үнэлдэг. Хөдөлмөрийн зах зээл дээр Хууль бусаар ашигт малтмал олборлож буй хүмүүс бид хулгай хийгээгүй, хүн алж хүрээ талаагүй, ард түмэн нь баялгаа олборлож шударга хөдөлмөр эрхэлсэн

¹⁶ Хууль тогтоомжийн тухай хууль. 2015 он. Хуулийн 51.3 зүйл. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.

¹⁷ Хууль тогтоомжийн тухай хууль. 2015 он. Хуулийн 51.1 зүйл Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, багц хуулийн төсөл боловсруулахад түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлно.

¹⁸ Дайтах урлаг. Сүнз. Орос хэлнээс орчуулсан Ч.Баатар. 2018 он Мон судар ХХХ

гэнэ, Хахууль өгөөд тендер авсан хүнийг ажилтан нар нь манай энэ захирал шударга гар шүү, хахууль аваад шийдвэр гаргадаг даргыг ажилтан нар манай дарга шударга гар шүү дээ, шууд тул гэж зөвлөсөн тохиолдол бүртгэгддэг.

Хуульч хүний хувьд Үндсэн хуулийн шударга ёс, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ, Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ, Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй, шударга шүүхээр шүүлгэх, Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ: Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх; хуулиар ногдуулсан албан татвар төлөх; эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах, Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно, Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая” хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө, Эрүүгийн хуульд “Шударга ёсны зарчим” тогтоож Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино гэдэг агуулгаар ойлгодог.

“ШУДАРГА” гэх ойлголт яагаад нэг мөр ойлгогдохгүй, өөр өөр хэмжүүрээр тайлбарлагдаад байна вэ. шалтгаан нь **Аливаа зүйлийг мөн чанарыг өөрчлөх, агуулгыг өөрчлөх, хэрэгжилтийг сулруулах аргачлал бололтой. Шударга**

гэсэн агуулгыг шударга гар гэсэн агуулга руу хэлбийлгэхэд урвуу утга илэрхийлж байгаа байдлаас харж болно. Монгол улсын хувьд мөнгө угаах гэмт хэргийн шинж, шалтгаан нөхцөл, үр дагаврыг судлаад, хуулиа баталсан байх. Хэрэгцээ шаардлага хангахгүй бол Гадаад улс орнуудын хүрсэн түвшин, ололт амжилтыг судлаад өөрсдийн онцлогт нийцүүлэн хуульчлах шаардлагатай.

Бидний хувьд мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцоод хуулийг хэрэгжүүлж туршлага хуримтлуулсан, цөөнгүй тохиолдол [кэйс] шийдвэрлэсэн. Одоо хийдэлгүй эрх зүйн орчин бүрдүүлэх цаг нь болсон тул судалгааны үр дүнд суурилсан томъёолол бичиж хууль тогтоогч нартаа танилцуулах, ойлгуулах.

Мөнгө угаах гэмт хэргийн нийгмийн хор аюулыг хүн бүр ойлгох, иргэдэд ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛЫГ олгох, шударга хөдөлмөөр олж авсан хөрөнгө, мөнгийг Үндсэн хууль бусад хуулиар хамгаалдаг, Иргэн хүн Үндсэн хууль бусад хуулийг сахин биелүүлэх үүрэг хүлээж буйг ухамсарлуулах, “суурь гэмт хэрэг” ийн хор хөнөөлийг таниулахгүйгээр үр дүн гарахгүй. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг, мөнгө угаах, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах олон улсын чиг хандлагыг цогц хэлбэрээр сурталчлан таниулах, хууль, эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх шаардлагатай.

Хэл ярианы тусламжтайгаар төсөөлмөл бодит байдал үүсгэх чадвар нь нэг нэгнээ танихгүй асар олон хүн хамтран ажиллах боломжийг бий болгосон. Түүгээр ч үл барам өргөн хүрээтэй хамтын ажиллагаа нь домог яриаг өөрчилж, өөр түүх ярьснаар хүмүүсийн хамтран ажиллах арга замыг өөрчлөх боломжтой. Тодорхой нөхцөл байдалд домог яриа маш хурдан өөрчлөгддөг. Францчууд 1789 онд бараг ганцхан шөнийн дотор хаад дээдэс бол тэнгэр бурхнаас заяасан эрхтэй гэсэн домгийг ард түмэн засгийн эрхийг барина гэсэн өөр домгоор сольсон билээ¹⁹

¹⁹ Yuval Noah Harari. *SAPINES. A BRIEF HISTORY OF HUMANKIND*. Ангил хэлнээс орчуулсан Б.Төмөр, Ч.Баасанжаргал, Т.Ариунсанаа. Монгол орчуулгын эрх ©2017 Монсудар хэвлэлийн газар.

V. Суурь шалтгааныг тодорхойлох.

Манай улсад хязгаарлалт тогтоосон, хориглосон бүхэн болдог. Орон сууцны 1 давхарт хаалга гаргах зөвшөөрлөөр үндсэн барилгаасаа том өргөтгөл, авто замыг өргөтгөх боломжгүй болтол нь тулгаад барилга барих, хүүхэд залуусын цуглах парк, орон сууцны хороолол дундах ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, автомашины зогсоол, үерийн далан дотор, Дархан цаазат Богд Хан уул гээд боломжтой бүх газар барилга барьсан бол байгалийн баялгаа ашиглах тусгай зөвшөөрлөө 18 дугаар зууны жишгээр (АНУ-д газар олгосон туг хатгадаг) анх өргөдөл өгсөн хүнд өгөхөөр хуульчилсан. Бөхчүүд, компанийн хамгаалалтын алба, эрүүгийн хэрэгт ял шийтгэл хүлээж, бусдыг айлгаж ичээдэг хүмүүсийн гар тулаан Ашигт малтмал, Газрын тосны газрын гадаа өрнөж, эрх мэдэлтэй хүмүүс шөнийн цагаар бүртгэлийн дэвтэрт өргөдөл шивж тусгай зөвшөөрлүүд хэвлэгдсэн.

Хууль батлагдахын өмнө Байгалийн баялгаа байгальд ээлтэй аргаар олборлож, зөв зохистой ашиглаад хөгжсөн улс орнуудад очиж туршлага судалсан хэрнэ сайн жишгийн эсрэг агуулга бүхий хууль батлаад хэрэгжүүлсний үр нөлөө. Орд газраа тогтоогоод компани байгуулдаг. Компанийн хувьцааны 30 хувийг төр, 30 хувийг иргэд, үндэсний аж ахуйн нэгждээ дотоодын биржээр, үлдсэн 50 хувийг олон улсын зах зээлд нээлттэй арилжсан бол баялаг хууль бусаар олборлох, НҮҮРСНИЙ гэх тодотгол бүхий хүн төрөлхтнийг цочоосон хэрэг гарахгүй, Баялагаа үндэстэн дамнасан корпорацад ашиглуулаад орлогыг нь бүртгэж, ашиг, татвараа авч чадахгүйд хүртлээ дордохгүй... **Иргэний, хөндлөнгийн хяналт байхгүй бол өмч эзэнгүйдэж авлига, дур зорго хязгааргүй тэлдэг.** Стратегийн ордоо бүрэн тогтоож чадаагүй байхад зарим ордыг ашиглаад нөөц нь дууссан, сүүлийн жилийн төлөвлөгөө хаалтын ажлын тайлан бичигдсэн байх жишээтэй. Газар эзэмшүүлэх шийдвэр, тусгай зөвшөөрлийн ард авлига, ашиг сонирхлын зөрчил, эрх мэдлийн түрэмгийлэл бий.

Богд Хан уулын Богино, Нүхт, Жаргалант, Залаат, Их тэнгэр, Бага тэнгэр, Хадатын аманд тансаг зэрэглэлийн орон сууцны хороолол, хаус баригдаж, ая тухтай орчныг улс төр, эдийн засгийн эрх чөлөөнд хүрсэн хүмүүст бүрдүүлж, тэд тэндээ тухтай амьдарч байхад иргэн хүн тухайн бүс нутагт нэвтрэх, зорчих эрхгүй. Хэвлэлийн эрх чөлөөний хуультай ч сэтгүүлч нар нь Бага тэнгэрийн амны постоор хөөгдөн гарахад хэн ч юу ч хэлж чадаагүй. Нураах ёстой барилга нь ашиглалтад орчихдог. Бодит үйл явдал, өнөөгийн дүр төрөхийг харахаар

Ф.Оссендовский аян замын тэмдэглэлдээ өгсөн “Хүн, Араатан, Бурхад” гэсэн нэрийн агуулга тодорно²⁰. **Барон Унгерн...** “Чингис хааны үр садын оршин суугаа нутаг оронд өөрийнх нь цэргүүдийн авчирч өгсөн эрх чөлөөг цаашдаа хамгаалахаа хэлээд Монголчууд дахин хүчирхэгжиж эрт дээр цагт ивээлд нь нөмрөгдсөн Азийн олон овог аймгууд нэгдэн агуу их Төв азийн улс гүрэн болохыг Чингис хааны өнө мөнхийн амьд зүрх шаардаж буй. ... Баян ядуугийн зай улам холдож ядуурсан хэсэг хардамтгай үзэл бодолд автдаг бол хөрөнгө мөнгө, нэр нөлөө бүхий сэхээтнүүд нь бодит амьдралаас алслагдаж хоосон мөрөөдөлд авчихдаг талаар сургамжилсан.

Улс орны иргэд баян, ядуу гэсэн 2 туйлд хуваагдаж, эрх мэдэл, засгийн эрх чөлөөнд хүрсэн хүн амын цөөнх хэсэг өөрсдийн амьдрах газар орчноо олон нийтээс тусгаарлаад ирвэл юу болдог вэ?

Дэлхийн түүхэнд (Cбrtel de Medellнn²¹) гэх жишээ тодоор бичигдэн үлджээ. Пабло Эскобарын (Pablo Escobar) бүрэн дунд боловсрол, коллежийн боловсрол эзэмших гэж хичээсэн боловч ядуу амьдралаасаа болж хулгай, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэж эхэлсэн. Хотын иргэд нь баян ядуу гэсэн хоёр хэсэгт хуваагдсан тул ядуу иргэдээр ойд хар тамхи тариулах, эд баялагтай ялангуяа өндөр өртөгтэй амьдарч байгаа хүмүүст хэрэглүүлэх замаар хууль бус орлого олох, автомашин болон бусад эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг үйлдэж байгаад гэмт бүлэглэл үүсгэн байгуулж удирдсан. Түүний байгуулсан Колумбын хар тамхины бүлэглэл хууль бус үйл ажиллагаа явуулах үедээ ажил үүргээ гүйцэтгэж буй албан хаагчдад АВЛИГА уу, ТУГАЛГАН сум авах уу²² гэсэн сонголт тулгадаг, өөртэй нь хамтран ажиллахаас татгалзсан бол Рэкет, хүчирхийлэл, дарамт шахалт (заналхийллээр) аллага үйлддэг. Гэмт бүлэглэл нь хүн барьцаалах, хулгайлах, бөмбөг дэлбэлэх, зэргээр террорист үйл ажиллагаа явуулж, Хар тамхины тээвэрлэлт, наймааг Рио-де-Жанейро (Бразил), Буэнос-Айрес (Аргентин), Валпарайсо (Чили), Кубын Гавана, Флорида дахь Панама хот, Испанийн Барселона, Мексик, Америкийн нэгдсэн улс, Калифорниас, Англи улс хүртэл өргөжүүлсэн гэмт этгээд.

²⁰ Ф.Оссендовский. “Хүн, Араатан, Бурхад” анхын хэвлэлт. СГЗ орчуулагч, яруу найрагч Жигжидсүрэнгийн Нэргүйн монгол хэлнээ хөрвүүлсэн. 225 дугаар хуудас

²¹ Цахим эх сурвалж. https://en.wikipedia.org/wiki/Medell%C3%ADn_Cartel

²² https://en.wikipedia.org/wiki/Pablo_Escobar картелийн үйл ажиллагаа ид өрнөж байх үед нийтдээ 3500 орчим хүн, тэр дундаа Меделлин хотын 500 гаруй цагдаа, олон тооны шүүгч, улс төрчдийн амь насанд халдсан. Колумбын шүүх эрх мэдлийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан жагсаалтыг бүхэлд нь цуглуулах боломжгүй юм.

Эррийн хуулийн 18.6 зүйлд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд хуулийн зохицуулалтыг сурталчлах, хууль, эрхзүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага

Төр засгийн кокайнтай хийх тэмцэл, иргэдийн амьжиргаа, амьдрах орчныг сайжруулах бодлого тааруу байгааг ашиглан буяны үйлсэд оролцох, ядуус амьдардаг хорооллуудад боловсролын орчныг бүрдүүлэх зорилготой сургуулиудыг, эрүүл мэндийн дэмжих зорилгоор эмнэлэг, чөлөөт цаг өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн, хөл бөмбөгийн цэнгэлдэх хүрээлэн, сүм хийдүүд, хотод чөлөөтэй зорчих зам, гүүр, орон сууцны цогцолбор хороолол олноор барьсан тул Колумбын ард иргэдийн хувьд “Робин Гуд шиг” хүн гэж хүндлэгдэж 1982 оны Колумбын парламентын сонгуульд оролцож Төлөөлөгчдийн танхимын орлогч гишүүнээр сонгогдсон.

Хууль сахиулагчид баривчлах үед галт зэвсэг ашиглан эсэргүүцэл үзүүлэн амь насаа алдсаны дараа түүний үхэлд эмгэнэл илэрхийлж, оршуулах ёслолд 25,000 гаруй иргэн оролцсон талаар эх сурвалжид тэмдэглэжээ.

Шилдэг эмч нарын нэг Бенжамин Раш архийг хориглохоос илүү зохист хэрэглээнд итгэдэг байв. Раш “Хүний бие болон оюун санаанд галын цогтой сүнснүүдийн нөлөөллийн тухай судалгаа” (1784) зохиолдоо согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх нь бие махбодын болон сэтгэл зүйн эрүүл мэндэд хор хөнөөл учруулдаг гэж үзэж, согтуурах явдлыг өвчин гэж тэмдэглэжээ. Америкчууд 1830 онд долоо хоногт дунджаар 1.7 шил хатуу архи хэрэглэдэг байсан. Америкийн нэгдсэн улсын иргэний дайн дуусаж, тусгаар тогтнолоо олж авсны дараахан улсын өрийг төлөхөд туслах зорилгоор вискинд татвар ногдуулсан боловч татварыг эсэргүүцэн бослого гарсан тул Томас Жефферсоны Ардчилсан Бүгд Найрамдах Нам 1800 онд засгийн эрхэнд гарсны дараа вискиний татварыг цуцалсан. АНУ-ын Конгресс дайны он жилүүдэд үр тариа хэмнэх зорилгоор 1918 оны 11-р сард 1.28% дээш спиртийн агууламжтай согтууруулах ундаа худалдахыг хориглосон, согтууруулах ундааны хэрэглээ нь нялхсын эндэгдэл, элэгний хатуурал, нас баралт, гэмт хэрэг гаралтад нөлөөлж буй байдлыг харгалзан үзээд 1920 онд согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, тээвэрлэх, борлуулахыг хориглосон Волстэдийн хуулийг батлан 1933 он хүртэл хэрэгжүүлсэн.

“Нүглийн татвар” буюу вискинд оногдуулах татвар эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ, согтууруулах ундааны хэрэглээ нийтийн эрүүл мэнд, нийгмийн ёс суртахуун ажилгүйдэл, замбараагүй байдалд тодорхой хэмжээгээр хор хөнөөл учруулж болзошгүй гэсэн эрсдэлийн тооцоолол хийж хууль батлан хэрэгжүүлсэн. Архины хор хөнөөлийн талаарх олон нийтийн

мэдлэгийг дээшлүүлнэ, иргэдийн эрүүл мэндэд эерэг нөлөөтэй, гэмт хэргийн гаралт бууруулах зорилгоор баталсан хуулийн хэрэгжилт бослого, зохион байгуулалттай гэмт хэрэг гарах шалтгаан болсон. Хориглосон, хязгаарлалт тогтоосон хуулиудын цоорхойг олох, архи олж авахын тулд хууль бус арга хэрэглэснээр архи, согтууруулах ундаа түгээх зорилготой хар зах болон гэмт хэргийн бүлэглэлүүд бий болсон ба эмч нар жор бичих нэрээр авлига авч эхэлсэн²³.

Нью-Йоркийн Бруклин хотод цагаач гэр бүлд 1899 оны 1-р сард Аль Капоне төрсөн, 6 дугаар ангиа төгсөөд сургуулиа орхиж, гудамжны нэр хүндтэй гэмт бүлэглэлтэй холбогдож, гишүүнээр элссэн²⁴ тэрээр мөрийтэй тоглоом, биеэ үнэлэлт, хулгайн наймаа эрхэлж, өрсөлдөгчид болон өрсөлдөгч бүлэглэлүүдийн гишүүдийг амь насыг хохироох гэмт хэргүүд үйлдэж 1927 онд ойролцоогоор 100 сая доллароор үнэлэгдсэн хууль бус хөрөнгө, орлоготой болсон²⁵. Өөрийн хууль бусаар олсон хөрөнгийг хууль ёсны болгон харагдуулах зорилгоор үйл ажиллагаа явуулдаггүй хувцас угаалгын газрууд байгуулан бидний мэдэх мөнгө угаах гэмт хэргийн шинжийг олон нийтэд таниулсан. Аль Капоне татвараас зайлсхийсэн хэргээр яллах ажиллагаа амжилттай хэрэгжсэн нь төрийн болон хууль сахиулах байгууллагуудаас хууль бус мөнгө, орлогыг хураах ажилд ач холбогдол өгсөн боловч дээрэмчид татвараа төлж эхэлмэгц татвараас зайлсхийхийн эсрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудыг ашиглах боломжгүй болсон.

Дээрх үйл явдлуудын үр нөлөөг судлан үзэхэд тооцоо судалгаагүй шийдвэр гэмт хэрэгтнийг өдөөдөг, шударга хөдөлмөрөөр бус гэмт хэрэг үйлдэж хөрөнгө орлоготой болдог. Тухайн хөрөнгөө гэмт бүлэглэлийн үйл ажиллагаанд зарцуулдаг тул анхдагч, суурь, үндсэн шалтгаануудыг судлах, өөрийн орны онцлогт нийцсэн хэм хэмжээг тогтоох шаардлагатайг илэрхийлнэ. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгөө угаах бус хууль ёсны харагдуулах үйл явыг мөнгө угаах гэж ойлгоно. Түүнээс байршуулах үе, далдлах үе, буцааж нэгтгэх үе шатууд хэрхэн хийгдсэн. Энэ үе шатуудаар дамжаагүй, өөрөө дансандаа хийгээд зарцуулсан үйлдэл мөнгө угаах гэмт хэргийн шинжгүй гэж дутуу дулимаг байдлаар ойлгосноор хийдэл үүснэ.

²³ Цахим эх сурвалж. https://en.wikipedia.org/wiki/Prohibition_in_the_United_States нэг өдрийн дотор вискиний 475 жор бичсэн нэг эмч бичсэн. 1931 онд 400 эм зүйч, 1000 эмч эмч нар гарын үсэгтэй жорын хуудас худалдсан луйврын хэрэгт баригдсан.

²⁴ <https://www.fbi.gov/history/famous-cases/al-capone>

²⁵ <https://www.britannica.com/biography/Al-Capone>

VI. Дүгнэлт.

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлогын бодит шинж чанар, эх үүсвэр өөрчлөх гэмт үйлдлийн нийгэмд учруулах хор уршгийг иргэдэд таниулах, эрх зүйн мэдлэг, боловсролыг дэмжих, хуулийг нэг мөр ойлгож сахин биелүүлэх, эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл дэх хийдлийг арилгах, суурь гэмт хэрэг, мөнгө угаах гэмт үйлдлийн хор хөнөөлийг таниулах боломжийг энэхүү судалгаагаар эрэл хийлээ.

Авлигатай тэмцэх газарт бүртгэгдсэн хэргүүдэд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгөө “Нас барсан, гадаад улсад ажиллаж амьдарч байгаа, аав ээж, эхнэр нөхөр, ах дүү, үеэлүүд, жолооч туслах нарынхаа баримт бичгийг ашиглан арилжааны банканд данс нээж төвлөрүүлсэн, гадаад улсын банканд хадгалуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө худалдан аваад бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхгүйгээр ашиглах, барилгын салбарт хөрөнгө оруулалт хийсэн тохиолдлууд бүртгэгдэж байна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө биет байдлаараа байж байвал эд мөрийн баримт, хувиргасан, шилжүүлсэн бол Үндсэн хуулийн “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх” эрхтэй зөрчилдөж байгаа тул гэмт хэрэгт тооцогдох учиртай.

Олон улсад “Бохир” мөнгийг үйлчилгээний компанид байршуулж, түүнийгээ хууль ёсны орлогоор давхарлаж, улмаар мөнгөний урсгалд нэгтгэх нь мөнгө угаах гэмт хэргийн нийтлэг хэлбэр гэж тодорхойлдог. **Манай улсын хувьд өөрөө мөнгө угаах, суургүй мөнгө угаах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцоогүйн, хөрөнгийн менежментийн хууль байхгүйн улмаас** олон улсад мөнгө угаах гэмт хэрэгт тооцдог үйлдэлд хариуцлага хүлээлгэдэггүй, хууль бус хөрөнгийг хураан авч чадахгүй нөхцөл байдал үүсдэг. Шүүхийн практикийг судлан үзсэн хүмүүс өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт үйлдсэн хүнд хариуцлага оногдуулсан хэрнэ, эрх мэдэл бүхий хүмүүсийн мөнгө угаасан үйлдэлд хариуцлага тооцсонгүй гэж бухимдах шалтгаан болж байна.

Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлох шаардлагатай байгааг судлаач, хууль сахиулагч, хуульч, бодлого тодорхойлогч нар нэгэн дуугаар баталж суурь гэмт хэргийг нэрлэх шаардлагатай гэж дүгнэжээ. Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгчдийн эцсийн зорилго нь хууль бусаар олсон мөнгөө / Шударгаар хөдөлмөрлөж олоогүй/ чөлөөтэй ашиглах явдал.

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний

болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Эрүүгийн хуулийн зорилгоо удирдлага болгоод суурь гэмт хэргээ нэрлэх бус Хөнгөн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого угаасан бол ял шийтгэл хөнгөн оногдуулах, хүнд гэмт хэрэг үйлдэж хөрөнгө, орлого угаасан, хуулийн этгээд, хуульч, санхүү татварын мэргэжилтэн оролцуулсан, гадаад улсад угаасан үйлдлийг хүндрүүлэн ял шийтгэл оноох хуулийг батлах боломжтой юм.

Төр мөнгөтэй тархигүй, эрдэмтэд мөнгөгүй ухаантай. Төр санхүүжүүлж эрдэмтэд судалбал жинхэнэ хүч гэсэн хэлцийг санаж шударга ёсонд нийцсэн эрүүгийн хуулийг бүтээх шаардлагатай. Эрх зүйн орчин цэгцрэх шаардлагатай²⁶.

Ашигласан эх сурвалж:

Хууль.

- Монгол улсын Үндсэн хууль 1992 он
- Монгол улсын Эрүүгийн хууль 2015 он
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он
- Зөрлийн тухай хууль 2017 он
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль. 1993 он
- Хууль тогтоомжийн тухай хууль. 2015 он
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 2019 он

Ном, гарын авлага.

- Сүнз. Дайтах урлаг. Орос хэлнээс орчуулсан Ч.Баатар. 2018 он Мон судар ХХК.
- Батдуламын Мөнх-Эрдэнэ. Гэмт хэрэг судлалын онол. 2021 он
- Марк Мэнсон. Тоомжиргүй амьдрах бяцхан урлаг.
- Авлигын болон Эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж, шүүхийн практик гарын авлага. 2022 он Д.Эрдэнэбалсүрэн, Б.Батцэрэн, Ч.Хосбаяр, Б.Амарбаясгалан, Б.Батаа, С.Өмирбек.
- Грахам брүүкс. Авлигын кримнологи. Орчуулгын эрх Авлигатай тэмцэх газар
- Жан-Пьер, Анастасия Сотиропоулу, Ларисса Грей, Клайв Скотт,

²⁶ Монгол Улсын 17 дахь Ерөнхий сайд Д.Бямбасүрэн. Ардчилсан хүчний холбооны дэргэдэх “Хөгжил” клубын урилгаар “Эдийн засгийн хөгжлийн гарц” сэдвээр уншсан лекц. Эх сурвалж: <http://www.ord.mn/index.php?newsid=3903>

Эрррийн жуулийн 18.6 зүйлд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд жуулийн зохицуулалтыг сурталчлаж, жууль, эрхзүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага

Кевин М.Стивенсон нарын бүтээл. Хөрөнгө буцаан авах ажиллагааны гарын авлага. StAR-ын ном.

- Эндрью Дорнбьерер. Үндэслэлгүй хөрөнгөжилт. BASEL INSTITUTE on GOVERNANCE.
- Улсын ерөнхий прокурорын газраас санаачлан Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл
- Монгол Улсын 17 дахь Ерөнхий сайд Д.Бямбасүрэн. Ардчилсан хүчний холбооны дэргэдэх “Хөгжил” клубын урилгаар “Эдийн засгийн хөгжлийн гарц” сэдвээр уншсан лекц
- Yuval Noah Harari. *SAPINES. A BRIEF HISTORY OF HUMANKIND.* Ангил хэлнээс орчуулсан Б.Төмөр, Ч.Баасанжаргал, Т.Ариунсанаа. Монгол орчуулгын эрх ©2017 Монсудар хэвлэлийн газар.
- Ф.Оссендовский. “Хүн, Араатан, Бурхад” анхын хэвлэлт. СГЗ орчуулагч, яруу найрагч Жигжидсүрэнгийн Нэргүйн монгол хэлнээ хөрвүүлсэн.

Цахим эх сурвалж.

https://en.wikipedia.org/wiki/Medell%C3%ADn_Cartel

https://en.wikipedia.org/wiki/Pablo_Escobar

<https://www.britannica.com/biography/Al-Capone>



А.СҮХ

*БХЯ-ны харьяа БХЭШХ-ийн Инновац технологи дамжуулалтын
төвийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр*

ДИЖИТАЛ ИННОВАЦЫН ШИЙДЛИЙГ АВЛИГЫН ЭСРЭГ АШИГЛАХ БОЛОМЖИЙН СУДАЛГАА

A study of opportunities for leveraging digital innovations in combating corruption

Хураангуй:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдалд ноцтой саад учруулж буй авлигын асуудлыг бүрэн шийдвэрлэхэд хууль, хяналтын арга хэрэгслүүд хүрэлцээгүй хэвээр байна. Ийм нөхцөлд дижитал инновац нь авлигыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хангах шинэ боломжийг нээж байна. Тухайлбал, блокчейн технологи, хиймэл оюун (AI), нээлттэй өгөгдлийн платформ зэрэг дэвшилтэт шийдлүүдийг авлигын эсрэг ашиглах нь өндөр үр дүнтэй байж болохоор байна.

Энэхүү нийтлэлд дээрх технологиудыг Монгол Улсын нөхцөлд хэрэгжүүлэх боломж, тулгамдаж буй сорилтуудыг дүн шинжилгээний үүднээс судлан үзэх, түүнчлэн Монголын цахим засаглалын өнөөгийн байдал, технологийн дэд бүтэц, нийгмийн хандлага зэрэг хүчин зүйлсэд үндэслэн практик шийдлийн бодлогын зөвлөмж боловсруулахыг зорилоо.

Нийтлэлийн гол зорилго нь Авлигатай тэмцэх газрын хэрэгжүүлж буй “Шударга ёс” хөтөлбөрийг дэмжин, дижитал технологийн шийдлүүдээр дамжуулан шударга, ил тод нийгмийг цогцлоох үйлсэд хувь нэмэр оруулахад оршино.

Түлхүүр үгс: Авлига, дижитал инновац, блокчейн, хиймэл оюун ухаан, нээлттэй өгөгдөл, цахим засаглал,

Abstract

Corruption remains a significant obstacle to the sustainable development of Mongolia's society and economy, and legal and regulatory mechanisms alone are still insufficient to fully resolve this problem. Under these circumstances, digital innovations are opening up new opportunities for detecting and preventing corruption and enhancing transparency. For example, the use of advanced solutions such as blockchain technology, artificial intelligence (AI), and open data platforms demonstrates strong potential in the fight against corruption.

This article aims to analyze the opportunities and challenges associated with implementing these technologies in Mongolia and to develop practical policy recommendations based on an analysis of factors such as the current state of Mongolia's e-governance, technological infrastructure, and societal attitudes.

The main objective of the article is to support the “Justice” program implemented by the Independent Authority Against Corruption of Mongolia and to contribute to the creation of a fair and transparent society through digital technology solutions.

Keywords: Corruption, Digital Innovation, Blockchain, Artificial Intelligence, Open Data, E-Governance

Удиртгал

Авлига нь нийгмийн хөгжил, эдийн засгийн тогтвортой байдал, хувь хүн байгууллага хоорондын итгэлцэлд, заналхийлдэг нийтлэг асуудал юм. Монгол Улсад авлигын түвшин өндөр хэвээр байгаа бөгөөд Transparency International-ийн Авлигын ойлголтын индекс (CPI)-ээр 2024 онд 180 орноос 114 дүгээр байрт жагссан (Transparency International, 2024 он). Авлигатай тэмцэх газар (АТГ) нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт-шалгалт явуулах, олон нийтийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа ч уламжлалт арга барилын хязгаарлагдмал байдал нөлөөлсөөр байна. Хөрөнгө орлогын мэдүүлгийн хяналт, төрийн худалдан авалтын ил тод байдал зэрэгт авлигын эрсдэл өндөр хэвээр байна (АТГ, 2023 он).

Технологийн хурдацтай хөгжил, ялангуяа дижитал инновац нь олон улсад авлигын эсрэг үйл ажиллагаанд шинэ боломжуудыг нээж байна. Блокчейн технологи нь ил тод, хуурамчаар өөрчлөгдөшгүй бүртгэлийн системийг бий болгож, хиймэл оюун (AI) нь их өгөгдөлд дүн шинжилгээ хийж, авлигын сүлжээлэг загварыг илрүүлж, нээлттэй өгөгдлийн платформууд нь ард иргэд, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж байна (OECD, 2022 он). Монгол Улс Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Ухаалаг засаг” төслийн хүрээнд “E-Mongolia”, “Дан” систем, Авлигатай тэмцэх газрын цахим системүүд зэрэг цахим засаглалын санаачилгуудын үндсэн дээр дижитал инновацын технологиудыг нэвтрүүлэн ажиллаж байна. Төрийн худалдан авалтын систем (tender.gov.mn) цахимжиж байгаа боловч мэдээллийн ил тод байдал, хяналтын дутагдалтай холбоотой асуудлууд хэвээр байна. Дижитал инновацын технологи ашигласнаар тендерийн гэрээ байгуулах, санхүүгийн мэдээллийг олон нийтэд нээлттэй, хуурамчаар өөрчлөх боломжгүй болно.

Үндсэн хэсэг

Блокчейн технологи бол мэдээллийг найдвартай, ил тод, хуурамчаар өөрчлөгдөшгүй байдлаар хадгалах боломжтой дижитал бүртгэлийн систем юм. Үндсэн үйл ажиллагаа нь өгөгдлийг “блок” хэлбэрээр, цаг хугацааны дарааллаар хадгалж, криптографийн¹ аргаар хамгаалдаг бөгөөд тэдгээр блокийг гинжин хэлбэрээр холбодог. Төвлөрсөн бус (decentralized) байдлаар ажиллаж, олон зангилаа (nodes) өгөгдлийн хуулбарыг хадгалан, системд оролцогчдын мэдээллийг зөвшилцлийн алгоритмаар баталгаажуулж, найдвартай ажиллагааг хангадаг гэж үздэг.

Төрийн үйл ажиллагаанд блокчейн технологийг нэвтрүүлснээр бүртгэгдсэн мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод болж, иргэд, сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагуудын хяналтыг нэмэгдүүлдэг. Мэдээллийг хуурамчаар өөрчлөх боломжгүй, шилэн байх боломжийг олгодог тул авлигаас үүсэж болзошгүй эрсдэлийг хязгаарладаг. Ухаалаг гэрээний тусламжтайгаар төрийн үйлчилгээ, гэрээний гүйцэтгэл автоматжуулагдсанаар авлигын учруулах эрсдэлийг хязгаарлаж, төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах боломжтой юм.

¹ Криптографи-(cryptography) гэдэг нь мэдээллийг хамгаалах, нууцлах, баталгаажуулах зорилгоор математикийн арга, алгоритмыг ашигладаг шинжлэх ухаан, технологийн салбар юм. Өгөгдлийг зөвхөн зөвшөөрөгдсөн хүн уншиж, ойлгох боломжтой болгохын тулд шифрлэлт, шифрийг тайлах, дижитал гарын үсэг зэрэг аргыг хэрэглэдэг.

Төвлөрсөн бус систем нь байгууллагууд хоорондын хяналтыг сайжруулж, авлигын эрсдэлийг багасгадаг. Уламжлалт мэдээллийн сангууд төвлөрсөн системтэй байдаг бол блокчейн технологи нь төвлөрсөн бус системээр ажиллаж, олон хэрэглэгч дээр хуваарилагдан нэг байгууллага эсвэл хувь хүн мэдээллийг хянах, өөрчлөх боломжийг хязгаарладаг байна.

Бүх төрлийн мэдээллүүд блокуудад хадгалагдаж, блок бүр өмнөх блоктой криптографийн хаш (hash) кодоор холбогдоно. Хэрвээ хэн нэгэн блокийн мэдээллийг өөрчлөхийг оролдвол хаш код таарахгүй болж, өөрчлөлтийн мэдээлэл илэрнэ.

Блокчейн системд оролцогч бүх гишүүдийн мэдээллийг харуулдаг ч хувь хүний мэдээлэл криптографийн аргаар хамгаалагдаж байдаг. Мэдээллийг блокчейнд нэмэхээс өмнө системийн оролцогчид (nodes) зөвшилцөлд хүрэх ёстой. Нэгэнт блокчейнд бүртгэгдсэн мэдээллийг өөрчлөх боломжгүй тул эрсдэлийг бууруулдаг.

Тухайлбал, Блокчейн технологийг Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотын төрийн үйлчилгээнд нэвтрүүлсэн туршилагаас харахад:

2016 онд Шейх Мохаммед бин Рашид Аль Мактумын санаачилгаар Дубайн засаг захиргааны бүх санхүүгийн гүйлгээний 50,0 хувийг блокчэйд шилжүүлэх, төрийн үйлчилгээний ил тод байдлыг нэмэгдүүлж, авлигын эрсдэлийг бууруулах, Засгийн газрын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, цаасан баримт бичгийн хэрэглээг багасгах зорилгоор ухаалаг гэрээ, төвлөрсөн бус бүртгэлийн системийг төр, хувийн хэвшлийн байгууллагууд хамтран нэвтрүүлж, хэрэгжүүлсэн байдаг. Энэ технологи нь үр дүнтэй байсан тул 2020 он гэхэд Дубайн засгийн газар 100 гаруй төрийн үйлчилгээг блокчейн технологид шилжүүлжээ. Үүнд:

- Газрын харилцаа;
- Эрүүл мэндийн бүртгэл;
- Тендерийн гэрээ;
- Бизнесийн лицензийн баталгаажуулалт гэх мэт багтаж байна.

Тендерийн үйл явцад блокчейн нэвтрүүлснээр авлигатай холбоотой гомдол 50,0 хувиар буурчээ. (Dubai Blockchain Strategy-ийн 2020 оны тайлан). Transparency International-ийн Corruption Perceptions Index (CPI) дээр АНЭУ-ын оноо 2016 онд 66/100 байсан бол 2022 онд 67/100 болж сайжирсан байна. 2021 оны байдлаар төрийн үйлчилгээнд блокчейн ашигласнаар жилд 25,1 сая цаасан баримт бичгийн хэрэглээг хэмнэж, 1,5 тэрбум AED төсвийн хэмнэлт гаргасан байна. Төрийн гүйлгээний зардал дунджаар 70,0 хувиар буурч, Блокчейнд суурилсан системүүд санхүүгийн гүйлгээний хугацааг хэмнэж төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлжээ.

- Дубайн Газрын Департамент (Dubai Land Department) 2017 оноос блокчейн ашиглан үл хөдлөх хөрөнгийн гүйлгээ, өмчлөлийн бүртгэлийг хийж эхэлснээр хуурамч бүртгэл, авлигатай холбоотой маргаан 60,0 хувь хүртэл багассан үзүүлэлт харагдаж (албан ёсны тайлан, 2019 он) байна.
- Төрийн тендерийн гэрээг ухаалаг гэрээгээр хянаж, нийлүүлэгчдийн сонгон шалгаруулалтыг ил тод болгосноор тендерийн үйл явц бодитоор явагдаж, хээл хахуулийн гомдол мэдэгдэхүйц буурчээ.
- Эрүүл мэндийн яамны өгөгдлийг блокчейнд хадгалж, эмнэлгийн бүртгэл, эмийн нийлүүлэлтийн хяналтыг сайжруулснаар эм, эмнэлгийн бүтээгдэхүүний хуурамч нийлүүлэлт, авлигатай холбоотой гомдол 40,0 хувиар буурсан (2020 оны тайлан) байна.

Хиймэл оюун (AI) нь том хэмжээний өгөгдөлд дүн шинжилгээ хийж, авлигыг илрүүлэхэд ашиглаж байна. Бразил улсад “Operation Car Wash” хэргийг хиймэл оюунд суурилсан системээр төрийн албан тушаалтнуудын санхүүгийн гүйлгээний хэвийн бус үйлдэлийг илрүүлсэн (World Bank, 2021 он) AI нь хөрөнгө орлогын мэдүүлэг, төсвийн зарцуулалтын хяналт зэрэгт автоматжуулсан хяналтын системийг бий болгодог. Сингапурт хиймэл оюунд суурилсан “Smart Nation” хөтөлбөр нь төрийн үйлчилгээний ил тод байдлыг үлэмж нэмэгдүүлсэн (OECD, 2022 он) зэрэг олон сайн туршлага байна.

Хиймэл оюуныг ашиглан авлигын хэрэг илрүүлсэн туршлагаас үзэхэд, Бразил улсад 2014 онд хэрэгжүүлсэн “Operation Car Wash” ажиллагаа нь Латин Америкийн түүхэн дэх хамгийн том авлигын эсрэг шалгалтыг явуулж, Petrobras (Бразилын төрийн өмчит нефтийн компани) болон улс төрчид, томоохон компаниудын авлигын сүлжээг илрүүлсэн хэрэг юм. Бразилын Сангийн яамны

харьяа Финансын үйл ажиллагааны хяналтын зөвлөл (СОАФ)-ийн хиймэл оюунд суурилсан автоматжуулсан системүүд, өгөгдлийн шинжилгээний технологи хэргийг илрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн жишээ байна:

- Petrobras-ын гүйлгээнээс гэрээний үнийг хэт өсгөж, 1,0-5,0 хувийн дүнтэй хээл хахууль төлсөн хэвийн бус мөнгөн шилжүүлгийн бүдүүвч сүлжээний засвар илэрсэн бөгөөд эдгээр мөнгө нууц дансаар дамждаг байсныг илрүүлсэн;
- Их хэмжээний банкны гүйлгээний өгөгдлийг хурдан шинжилж, гэнэтийн их хэмжээний шилжүүлэг, давтамж өндөртэй жижиг гүйлгээ зэрэг хэвийн бус загварыг тодорхойлж, Petrobras-ын гүйцэтгэх захирал Пауло Роберто Коста болон бусад албан тушаалтнуудын мөнгө угаалтын сүлжээг таслан зогсоосон;
- 2004-2012 оны хооронд Petrobras-ын гэрээнээс 2,3 тэрбум ам.долларын хохирол учирсныг илрүүлж, үүссэн (Petrobras-ын 2014 оны санхүүгийн тайлан) хохирлыг арилгуулсан;
- Банкны менежерүүд хээл хахууль авч, 310,0 сая ам.долларын мөнгө угаалтын сүлжээнд оролцсоныг автоматжуулсан хяналтын системээр илрүүлжээ;
- Бразил улсын Ерөнхийлөгч асан Луис Инасио Лула да Силва, Мишел Темер нар хээл хахуулийн сүлжээнд холбогдсон, тэдний гүйлгээний хэвийн бус хөдөлгөөнийг СОАФ-ийн систем илрүүлсэн зэрэг болно.

Нээлттэй өгөгдлийн платформууд нь төсвийн зарцуулалт, гэрээний мэдээлэл зэргийг олон нийтэд нээлттэй болгож, иргэдийн хяналтыг нэмэгдүүлдэг. Украинд “ProZorro” системээр төрийн худалдан авалтыг нээлттэй болгосноор жилд 1,0 тэрбум ам.долларын хэмнэлт гаргасан (OECD, 2022 он) байна. Иргэд, сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагууд нээлттэй өгөгдлийг ашиглан авлигын хэргийг илрүүлэх боломжтой болж байна.

Украины “ProZorro” системийн ашиглалтыг судлахад, Украинд авлигыг бууруулах, нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор ашиглаж эхэлсэн төрийн худалдан авалтын цахим систем юм байна. “ProZorro” гэдэг нь украин хэлээр “ил тод” гэсэн утгатай бөгөөд төрийн болон орон нутгийн байгууллагуудын тендерийг цахимаар зарлаж, хувийн хэвшлийн оролцогчид өрсөлдөх боломжийг олгодог. Систем нь нээлттэй эхийн (open-

source) технологид суурилсан бөгөөд Open Contracting Data Standard (OCDS)-ыг ашиглан өгөгдлийн ил тод байдлыг хангаж байна.

Гол онцлогийг дурдвал:

- Тендерийн бүх мэдээлэл, санал, үр дүнг олон нийт нээлттэй хянах боломжтой;
- Төвлөрсөн мэдээллийн сан (CDB), олон тооны хувийн цахим платформууд (marketplaces) хоорондоо хамтран ажиллах боломжтой энэ нь хэрэглэгчдэд хялбар, өрсөлдөөнийг бий болгох, нээлтэй ажиллагааг нэмэгдүүлдэг;
- Иргэд, хувийн хэвшил, бизнесийн, төрийн байгууллагуудын тендерийн үйл явцыг хянаж, зөрчлийг мэдээлэх боломжтой;
- 2017-2021 оны хооронд системээр дамжуулан 6,0 тэрбум ам.долларын хэмнэлт гаргасан тооцоо гарсан бөгөөд 2022 оноос хойш дайны ажиллагааны үед ч батлан хамгаалахын худалдан авалтад ашиглагдаж, дроны үнийг 30,0 хувиар бууруулсан судалгааны дүн гарчээ.

Монгол Улсын дижитал инновацын хэрэглээнээс харахад сүүлийн жилүүдэд цахим засаглалын чиглэлээр томоохон ажил, арга хэмжээг хэрэгжүүлсээр байна. “E-Mongolia”, “Дан” систем, төрийн үйлчилгээний цахимжуулалт зэрэг санаачилгууд нь авлигын эсрэг үйл ажиллагаанд дэвшилтэт технологийг ашиглах суурийг тавьсан. Төрийн худалдан авалтын систем (tender.gov.mn) цахимжиж байгаа ч авлига, ашиг сонирхлын эрсдэл өндөр хэвээр байна. 2022 онд Улаанбаатар хотын нийтийн тээврийн тендертэй холбоотой авлигын хэрэг нь дүгнэлтийг бататгаж байна (АТГ, 2022 он). Блокчейнд суурилсан платформ нэвтрүүлснээр гэрээний мэдээлэл, санхүүгийн урсгалыг олон нийтэд нээлттэй, хуурамчаар өөрчлөгдөшгүй болгох боломжийг бүрдүүлэх болсон.

Нээлттэй өгөгдлийн платформуудыг хөгжүүлснээр иргэд, олон нийт төсвийн зарцуулалт, төрийн алба хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хянах боломжтой болно. АТГ-ын “Хөрөнгө орлогын мэдүүлэг” цахим системийг хиймэл оюунд суурилсан дүн шинжилгээний системээр сайжруулснаар хуурамч мэдээллийг илрүүлэх боломж нээгдэнэ. Дижитал платформыг төрийн үйл ажиллагаанд өргөжүүлж, төсвийн зарцуулалтын мэдээллийг хялбаршуулсан визуал интерфейстэй аппликейшнээр иргэдэд хүргэх нь иргэний нийгмийн хяналтыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

“E-Mongolia” платформ нь төрийн үйлчилгээг цахимжуулснаар авлигын боломжийг бууруулсан. Жишээ нь: жолооны үнэмлэхийн үйлчилгээ цахимжсанаас хойш авлигын гомдол 60,0 хувиар буурсан (E-Mongolia, 2024 он) дүн гарчээ. Хөдөө орон нутагт интернэтийн хүртээмж хязгаарлагдмал байгаа нь цахим үйлчилгээний хүртээмжийг хязгаарлаж байна. “E-Mongolia” платформыг өргөжүүлж, хөдөө орон нутгийн иргэдэд зориулсан оффлайн үйлчилгээний цэгүүдийг байгуулах нь хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой юм. Дижитал платформуудыг ашиглан авлигын эсрэг боловсролын кампанит ажлыг төрийн байгууллага, ард иргэдийн дунд өргөжүүлэх нь чухал байна.

Дижитал инновацийг нэвтрүүлэхэд Монголын нөхцөлд тулгарч буй сорилт, бэрхшээлүүд:

Манай улсын хөдөө орон нутагт интернэтийн хүртээмж хязгаарлагдмал байгаа нь 2023 оны байдлаар хүн амын 30,0 хүртэлх хувийг өндөр хурдны интернэтэд холбогдоогүй (ЦХХХЯ, 2023 он) байсан. Энэ нь цахим засаглалын хүртээмжийг хязгаарлаж байгаагийн нэгэн илрэл юм.

Тухайлбал: “E-Mongolia” платформын хэрэглээг Улаанбаатар хотынхтой харьцуулахад хөдөө орон нутагт хязгаарлагдмал байна.

Блокчейн, хиймэл оюун зэрэг технологийн хэрэглээг зохицуулах хууль эрх зүйн орчин Монгол Улсад хангалттай хэмжээнд хөгжөөгүй байна. Монгол Улсын их хурлаар 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хууль батлагдсан боловч өгөгдлийн нууцлалд чиглэгдсэн, нээлттэй өгөгдлийн бодлогыг тодорхой зохицуулаагүй, блокчейн технологийн хэрэглээг зохицуулах тусгай хууль байхгүй талаар ЦХХХЯамнаас 2023 онд мэдээлсэн байдаг.

Монгол Улсын хүн амын 40,0 хүртэлх хувь нь цахим үйлчилгээний хэрэглээг сайн ойлгохгүй, 50-аас дээш настнуудын дунд олон нийтийн дижитал боловсролын түвшин харьцангуй бага байгааг 2023 оны судалгаагаар харагдаж байгаа (ЦХХХЯ, 2023 он) нь нээлттэй платформуудын хэрэглээг хязгаарлагдмал байна.

Авлигын эсрэг үйл ажиллагаанд орчин үеийн технологийн шийдэл нь зарим улс төр, бизнесийн бүлэглэлийн ашиг сонирхолтой зөрчилдөж болзошгүй. Төрийн худалдан авах үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх нь өнөөгийн тогтолцоонд ашиг хүртэгчдийн эсэргүүцлийг дагуулж болохоор байна.

САНАЛ:

- Блокчейнд суурилсан туршилтын төслийг АТГ, ЦХХХЯ хамтран Улаанбаатар хотын нэг томоохон тендерийг блокчейнд бүртгэх туршилтын төслийг эхлүүлэн, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, технологийн хэрэглээний оновчтой байдлыг бий болгох, туршилтын төслийн үр дүнг олон нийтэд сурталчилж, өргөжүүлэх боломжийг судалж үзэх хэрэгтэй байна.
- Хөрөнгө орлогын мэдүүлгийн цахим системд хиймэл оюунд суурилсан дүн шинжилгээний модулийг нэмж, хуурамч мэдээлэл, хэвийн бус гүйлгээг илрүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт, төрийн алба хаагчдын хөрөнгө орлогыг хянахад хиймэл оюуныг ашиглаж АТГ-ын хяналтын чадавхыг нэмэгдүүлэх шаардлагатай.
- Дижитал платформыг өргөжүүлж, төсвийн зарцуулалт, гэрээний мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, иргэдийн хяналтыг дэмжихийн тулд хялбаршуулсан визуал интерфейстэй аппликейшн хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх.
- АТГ-ын “Шударга байдлын судалгаа” зэрэг төслүүдийг дижитал платформ, социал медиа, аппликейшнаар түгээж, залуу үеийн оролцоог нэмэгдүүлэх, авлигын хэргийг мэдээлэх аппликейшн хөгжүүлж иргэдийн идэвхтэй оролцоог дэмжихэд анхаарах зэрэг болно..

ДҮГНЭЛТ

Дижитал инновацын технологи нь авлигын эсрэг үйл ажиллагаанд хувьсал авчирч, мэдээллийн ил тод байдалд иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх замаар авлигатай тэмцэх шинэ боломжуудыг бүрдүүлж байгаа юм. Монгол Улс цахим засаглалын хөгжилд суурилсан төрийн худалдан авалт, хөрөнгө орлогын мэдүүлэг, газрын бүртгэл зэрэг авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх өндөр эрсдэлтэй салбаруудад блокчейн технологийг нэвтрүүлэх бүрэн боломжтой байна.

Нийт иргэдийг тэр тусмаа 50 дээш насны хүмүүст хиймэл оюун, блокчейн цахим сургалтад хамруулах, мэдээллийг нээлттэй түгээх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Гэвч энэхүү шилжилтийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд технологийн дэд бүтэц, хууль эрх зүйн орчин, нийгмийн хандлага, зардал зэрэг олон хүчин зүйлийг даван туулах шаардлагатай. Үүнд төр, хувийн хэвшил болон олон улсын байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа нэн чухал болно.

Авлигатай тэмцэх газрын “Шударга ёс” хөтөлбөрийг блокчейн технологитой уялдуулан хэрэгжүүлснээр Монгол Улс авлигын эсрэг тэмцлийг шинэ шатанд гаргаж, илүү шударга, ил тод, хөгжлийн тогтвортой нийгмийг цогцлоох боломжтой болно.

Эх сурвалж:


1. OECD. (2022). Digital Governance and Anti-Corruption: The Case of ProZorro. Organisation for Economic Co-operation and Development. <https://www.oecd.org/governance/digital-government/>
2. Transparency International. (2024). Corruption Perceptions Index 2024. [Corruption Perceptions Index 2024 - Transparency.org](https://www.transparency.org/en/cpi)
3. The Guardian. (2017). “Operation Car Wash: Is this the biggest corruption scandal in history?” <https://www.theguardian.com/world/2017/jun/01/brazil-operation-car-wash-is-this-the-biggest-corruption-scandal-in-history>
4. Reuters. (2020). “Brazil’s ‘Car Wash’ probe targets Petrobras forex transactions.” <https://www.reuters.com/article/brazil-corruption-petrobras-idUSL1N2HR1J2>
5. Council on Foreign Relations. (2018). “Brazil’s Corruption Fallout.” <https://www.cfr.org/background/brazils-corruption-fallout>
6. World Bank. (2021). Technology and Anti-Corruption: Lessons from Brazil’s Operation Car Wash. <https://www.worldbank.org/en/topic/governance/publication/technology-anti-corruption>
7. Transparency International Ukraine. (2023). “Public Procurement 101: Navigating ProZorro.” <https://ti-ukraine.org/en/blogs/25351/>
8. Open Contracting Partnership. (2016). “ProZorro: How a volunteer project led to nation-wide procurement reform in Ukraine.” <https://www.open-contracting.org/en/2016/07/28/prozorro-volunteer-project-led-nation-wide-procurement-reform-ukraine/>
9. Interoperable Europe Portal. (2024). “E-procurement Prozorro to support Ukrainian economy.” <https://interoperable-europe.ec.europa.eu/en/collection/open-source-observatory-osor/news/e-procurement-prozorro-support-ukrainian-economy>
10. АТГ. (2024). 2024 оны үйл ажиллагааны тайлан. Авлигатай тэмцэх газар.

2024_Tailan.pdf

11. АТГ. (2023). Хөрөнгө орлогын мэдүүлгийн тайлан. Авлигатай тэмцэх газар. [Авлигатай тэмцэх газар.Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа](#)
12. ЦХХХЯ. (2023). Монгол Улсын цахим хөгжлийн тайлан 2023. Цахим хөгжил, харилцаа холбооны яам. [ТАЙЛАН - Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам](#)
13. E-Mongolia. (2024). Annual Report on Digital Public Services. <https://e-mongolia.mn/report/2024>
14. Dubai Blockchain Strategy-ийн албан ёсны тайлан (2016-2021).
15. АНЭУ-ын засгийн газрын мэдээлэл: www.dubai.ae.
16. Transparency International-ийн Corruption Perceptions Index (2016-2022).
17. IBM, ConsenSys-ийн блокчейн хэрэглээний талаарх тайлангууд.
18. Дэлхийн Эдийн Засгийн Форумын (WEF) блокчейн ба засаглалын талаарх судалг

Нэр томьёоны тайлбар

- Авлига: Хууль бус аргаар ашиг хонжоо олох, албан тушаалын байр сууриа урвуулан ашиглах үйлдэл.
- Блокчейн: Гинжин блок, Төвлөрсөн бус, хуурамчаар өөрчлөгдөшгүй мэдээллийн бүртгэлийн технологи.
- Хиймэл оюун ухаан (AI): Компьютерын системийг хүний оюун ухаантай төстэй байдлаар ажиллуулах технологи.
- Нээлттэй өгөгдөл: Олон нийтэд нээлттэй, хүн бүр ашиглаж болох мэдээллийн сан.
- Цахим засаглал: Төрийн үйлчилгээ, бодлогыг цахим технологид суурилан хэрэгжүүлэх тогтолцоо.
- Хаш (hash) функц: Мэдээллийг өвөрмөц код болгон хувиргадаг криптографийн арга.
- Ухаалаг гэрээ (Smart Contract): Автоматаар гүйцэтгэгддэг, программчлагдсан дижитал гэрээ.
- Криптографи: Мэдээллийн аюулгүй байдлыг хангах шифрлэлтийн технологи.



Х.БАТБАЯР

*Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн
Гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах багш,
цагдаагийн хурандаа, магистр*

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЧИГ ХАНДЛАГА

**“Reforms, operations, and directions of the
system to combat crime in mongolia.”**

(Шинжлэх ухааны тойм өгүүлэл)

Хураангуй

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд Монгол Улс дахь гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны байгууллагууд болох цагдаа, прокурор, шүүх, хорих байгууллагын эрх зүйн үндэс, эдгээр байгууллагын шинэчлэлийн үйл явц, хүрсэн үр дүн, гэмт хэрэгтэй тэмцэх, хариу арга хэмжээний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цаашдын чиг хандлагын талаар санал зөвлөмж боловсруулсан. Өгүүлэлд тодорхойлсон дээрх зорилтын хүрээнд хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын албан ёсны статистик үзүүлэлтийг 2006-2023 оны байдлаар түүвэрлэн авч, гэмт хэргийн түвшнийг тодорхойлох олон улсын аргачлалын дагуу 100.000 хүн амд ноогдох үзүүлэлтээр дүн шинжилгээ хийсэн болно. Түүнчлэн цагдаа болон шүүхэд итгэх олон нийтийн хандлагыг тодорхойлохдоо үндэсний болон олон улсын хэмжээнд хийгдсэн судалгааны үр дүнг ашиглаж, судлаачийн зүгээс дүгнэлт хийсэн бол эрх зүйн шинэтгэлийн үйл явцад дүгнэлт хийхдээ баримт бичигт дүн шинжилгээ хийх

арга зүйг ашигласан. Судалгааны үр дүнд Монгол Улсад гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны шинэчлэл зохих төвшинд тасралтгүй хийгдэж байгаа ч гэмт хэрэгтэй тэмцэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ төдийлөн үр нөлөөтэй биш байгааг гэж дүгнэв.

Summary

This scientific article analyzes the legal foundations of the organizations combating crime in Mongolia, including the police, prosecutors, courts, and correctional institutions. It reviews the process of reforms in these institutions, the results achieved, and examines the conditions of crime fighting and response measures. Additionally, it provides recommendations for future directions. Within the scope of the objectives outlined in the article, official statistics from law enforcement and judiciary institutions from 2006 to 2023 were collected and analyzed using an international methodology to determine crime levels, focusing on the indicator per 100,000 population. Moreover, public attitudes toward the police and courts were determined using national and international research findings, with conclusions drawn by the researcher. In the analysis of the legal reform process, a document analysis methodology was applied. The research concluded that although reforms to the crime-fighting system in Mongolia have been ongoing and continuous, the measures for combating crime and ensuring public safety have not been as effective as expected.

Түлхүүр үгс: Гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, Гэмт хэрэг, Шүүх, Прокурор, Цагдаагийн байгууллага, Хорих байгууллага, Эрх зүйн шинэтгэл.

Keywords: Crime-fighting system, Crime, Court, Prosecutor, Police organization, Correctional institution, Legal reform.

1. Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн үндэс

Монгол Улс дахь гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог шинэчлэх эрх зүйн үндсийг 1992 онд баталсан ардчилсан, шинэ үндсэн хуулиар тодорхойлсон. Тус Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал өмнөх социалист тогтолцооны үед үйлчилж байсан үндсэн хуулиудаас зарчим, үзэл баримтлалын хувьд ихээхэн ялгаатай байсан¹. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгтэй тэмцэх, иргэдийн аюулгүй

¹ Ж.Алтансүх, Монгол Улсын эрх зүйн шинэтгэл, Хууль дээдлэх ёс//Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэтгүүл, 2020 12 (77). 237 дахь тал.

тайван амьдрах эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төрийн нөлөөллөөс ангид байлгаж, мэргэшсэн оновчтой тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн суурь зарчмыг тусгаж өгсөн.

Мөн Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2.7-д хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь Засгийн газрын үүрэг гэж тодорхойлсон бол Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлэгт шүүх эрх мэдлийн эрх зүйн үндсийг тодорхойлж, 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно. Мөн зүйлийн 3 дахь хэсэгт Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна, 48 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно”² гэж шүүхийн эрх зүйн үндсийг тогтоожээ.

Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно. Мөн зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно³. Ийнхүү 1992 оны Үндсэн хуульд хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн байгуулах эрх зүйн үндсийг тусгасан нь ардчилал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хамгаалахад чухал ач холбогдолтой зохицуулалт болсон.

² Монгол Улсын Үндсэн хууль//төрийн мэдээлэл, УБ., 1992 №1

³ Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйл 1,2,3 дахь хэсэг.

1. Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын шинэчлэл

А) Цагдаагийн байгууллагын шинэчлэл

Монгол Улсын Их хурал 1993 онд Цагдаагийн байгууллагын тухай хуулийг 8 бүлэг, 53 зүйлтэйгээр баталсан нь Монгол Улсын цагдаагийн байгууллагын хөгжилд түүхэн үүрэг гүйцэтгэсэн хэдий ч хууль үйлчлэх явцад засаж сайжруулах шаардлагатай шүүмжлэлүүд гарч, цагдаагийн байгууллагын эрх зүйн орчныг дахин авч үзэхэд хүргэсэн.

Шүүмжлэлийн гол агуулга цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ардчиллын үнэт зүйл, зарчмуудыг нэвтрүүлэх, нийгмийн хэв журам сахиулахад цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэний хяналтын тогтолцоог бүрдүүлэх зэрэг агуулгын томоохон өөрчлөлтүүдийг хийж чадаагүйгээс өнөөг хүртэл хуучин тогтолцоо, уламжлалт хэв маяг, хүнд суртал хадгалагдсаар байна гэжээ⁴.

Эдгээр шүүмжлэлийг тусгах замаар Цагдаагийн албаны тухай хуулийг шинэчлэн боловсруулж 2013 оны 7 дугаар сарын 05-ний өдөр баталсан. Уг хуулийн үзэл баримтлал нь гэмт хэрэг мөрдөх албыг цагдаагийн байгууллагаас тусад нь байгуулах, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, хөдөлмөрийн харилцааг бие даасан хуулиар зохицуулахаар⁵ заасан хэдий ч холбогдох хууль батлагдаагүй тул дахин засах шаардлага тулгарсан.

Улмаар Монгол Улсын Засгийн газар Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дахин боловсруулж, 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын Их хурлаар баталж, мөн оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Хуулийн үзэл баримтлал нь олон нийтэд түшиглэсэн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогод тулгуурлах, Цагдаагийн байгууллагын тогтолцоог нутаг дэвсгэрийн онцлог, хүн амын нягтаршил нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан дахин шинэчлэх, хүний нөөцийн бодлого, албан хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулах, Цагдаагийн албаны техник хэрэгслийг сайжруулах, алба хаагчдын хувцас, агсамжийг шинэчлэхэд чиглэгдсэн.

⁴ [Enkhbold.B](#) “Criminal Justice System in Mongolia”, 2015, 한국테러학회보 제8권 제4호, 159~186쪽, 전체 28쪽,

⁵ 2008 оноос Цагдаагийн албаны тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж Монгол Улсын Их Хурлын 2013 оны 7 дугаар сарын 05-ний өдрийн нэгдсэн чуулганаар баталсан.

Б) Прокурорын байгууллагын шинэчлэл

Монгол Улсын Их Хурлаас 1993 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Прокурорын байгууллагын тухай хуулийг батлан гаргажээ. Эрх зүйн тогтолцооны шинэчлэл, нийгмийн харилцааны өөрчлөлттэй холбоотойгоор 2002 онд Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэн баталж мөрдүүлсэн бөгөөд 2017 он хүртэлх хугацаанд 8 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ. Шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр, Шүүх эрх мэдлийн байгууллагуудын шинэчлэл, нийгмийн харилцааны хувьсал, өөрчлөлт, эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгддэг гол хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан 2002 онд батлагдан мөрдөгдөж байгаа Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэх, үзэл баримтлал, зохицуулалтыг өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарсан.

Дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн “Прокурорын тухай” хуулийг 2017 онд баталсан. Шинэчлэн батлагдсан хуульд прокурорын байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим, Прокурорын байгууллагын тухай хуульд заасан зарим нэр томъёог оновчтой болгох, Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эрүүгийн хууль тогтоомжийн төслүүдтэй уялдуулах, прокурорын байгууллагын харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг харьцуулан дүгнэж, үйл ажиллагааны хариуцлагатай байдлыг хангах, бусад байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн үндсийг бий болгох, прокурор үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгааг дээшлүүлэх, албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо зэргийг тодорхой зохицуулж өгсөн байна.

В) Шүүхийн шинэчлэл

Монгол Улс 1992 оны шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Үндсэн хуулийн зарчим, агуулгад нийцүүлж шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг эрх зүйт төрийн үзэл баримтлалд нийцүүлж төлөвшүүлэх талаар шинэтгэл хийсэн. 1993 онд Шүүхийн тухай хууль батлагдсанаар өнөөгийн шүүхийн бүтэц зохион байгуулалт бүрэлдэн тогтсон. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал ингэж Үндсэн хуулиар баталгаажсан явдал нь шинэ ардчилсан шүүх оршин тогтнох, хөгжин дэвших суурь болж өгчээ.

“Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр” нь “Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр”; Монгол Улсын Их хурлын 2008 оны 35 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”; мөн Монгол Улсын Их хурлын 2009 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”; Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-т тодорхойлсон зорилтуудад нийцүүлэн батлагдсан шүүх эрх мэдлийн шинэтгэлийн стратегийн гол баримт бичгүүд байсан.

Дээр дурдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийг шүүхэд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх үндсэн чиглэл”⁶, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2014-2020 онд шүүхийн хөгжлийн стратегийг тодорхойлсон 5 дэд хөтөлбөрийг тус тус баталсан. Уг хөтөлбөрт заагдсан шалгуур үзүүлэлтэд тулгуурлан шүүхийн шинэтгэлийг 1) Шүүхийн тогтолцоог шинэчлэх, 2) Шүүхийн бие даасан байдлыг хангах, 3) Шүүгчийн хараат бус байдлыг сайжруулах, 4) Шүүхийн хүний нөөц, сонгон шалгаруулалтыг шударга болгох, 5) Шүүхийн ил тод, нээлттэй байдал зэрэгт анхаарал хандуулсан.

Энэ хүрээнд 2013 онд Монгол Улсын шүүхийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг баталж мөрдсөн.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болох, Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөх, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, томилох журмыг шинэчлэн өөрчлөх шаардлага бий болсон.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн шүүх эрх мэдэлтэй холбоотой хэсэг нь “Шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлж, хараат бус байдлыг хангах” үндсэн чиглэлийн хүрээнд хийгдсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар

⁶ Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 39 дүгээр захирамжаар батлагдсан

баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т:

1. Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахдаа иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг бодитой хангах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүгчийг мэргэшүүлэх, шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулж хүртээмжтэй болгох үндсэн зарчимд нийцүүлэх;

2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан, хараат бус, тогтвортой байдлыг хангах зорилгоор түүний бүрэлдэхүүний тавыг шүүгчид дотроосоо хувь тэнцүүлэн сонгож, бусад таван гишүүнийг бусад институтээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох, гишүүдийг зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллуулах, Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгох журмыг хуулиар тогтоох;

3. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулах зохицуулалтыг хуульчлах зэрэг асуудлыг тусгажээ.

Дээрх нөхцөл байдал, шинэчлэлийн агуулгыг тусгаж, Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг баталж, 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бүх нийтээр даган мөрдөж эхэлсэн бөгөөд тус хууль нь 16 бүлэг, 118 зүйлтэй.

г) Хорих байгууллагын шинэчлэл

1992 оны Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлэн Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийг Монгол Улсын Их хурлаас 1996 онд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэслэл, журмыг шинэчлэн тогтоосон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг 2002 онд тус тус батлан мөрдөж байв.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.10-т “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд бүрэн шилжүүлэх, цагдан хорих байрны нөхцөлийг хүний жам ёсны эрхэд нийцүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд цахим болон теле-камерын хяналтын системийг нэвтрүүлэх, ялтныг хөдөлмөрт бүрэн хамруулах...” гэж тус тус заасан.

Дээр дурдсан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан 2015 онд баталсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд ял, шийтгэлийн төрөл, хэлбэрийг шинээр тодорхойлж, хорих ялыг нээлттэй, хаалттай хорих байгууллагад, өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад тус тус эдлүүлэх, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шийтгэл оногдуулахаар тусгаж, ял, шийтгэл, албадлагын арга хэмжээний төрлийг шинээр тодорхойлсон нь дээр дурдсан ял, шийтгэл оногдуулсан шийдвэрийг гүйцэтгэх, хяналт тавих ажиллагааг шинээр журамлах шаардлагыг бий болгож байсантай холбоотойгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд баталжээ.

2. Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны төлөв байдал

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа: Монгол Улсын хүн амын тоонд харьцуулбал, нэг алба хаагчид улсын хэмжээнд дунджаар 370 (орон нутагт 533, нийслэлд 233) хүн ам ноогдож, нийт 10000 орчим алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий ч гудамж талбай, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг бодитой буурахгүй, нийт гэмт хэргийн 40 орчим хувийг эзэлсээр байна⁷.

Монгол Улсад сүүлийн 14 жилийн байдлаар жилд дунджаар 23287 гэмт хэрэг бүртгэгдэж, үүнээс 12443 буюу 55.0 хувийг нь илрүүлж⁸, 100,000 хүн ам тутамд 847 гэмт хэрэг ноогдож байна. Гэмт хэргийн түвшин 2018 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байсан бол гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 2007, 2017 онд хамгийн доогуур үзүүлэлттэй байжээ. Харин 2022 онд энэ үзүүлэлт 1511, 2023 онд 1565 болж өсөх хандлагатай болжээ.

Харин сүүлийн 3 жилд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, хөдөлгөөн, тархалт, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг “Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”⁹-ын дагуу тодорхойлж, цаашдын

⁷ Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолын хавсралт

⁸ НҮБ-аас гаргасан Эрүүгийн процессын загвар хуульд заасан яллагдагчаар татах этгээд нь тогтоогдож прокурор яллах ажиллагаа явуулснаар (Formal charge) гэмт хэргийг илэрсэнд тооцдог жишиг аргачлалыг олон улсад түгээмэл хэрэглэж байна. Энэ аргачлалыг хэрэглэдэг зарим /Швед, Голлонд, Герман зэрэг/ улсын гэмт хэргийн илрүүлэлт дунджаар 31.6 хувьтай байна.

⁹ Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны А/118 дугаар тушаалаар баталсан

чиг хандлагыг нийгэм, эдийн засаг, эрүүгийн нөхцөл байдалтай уялдуулан авч үзэхэд жилд дунджаар 31 мянга гаруй гэмт хэрэг бүртгэгдэж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 184.8 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирч, 981 хүн нас барж, 10351 хүн бие махбодоороо гэмтэж, эрүүл мэндээрээ хохирч байна¹⁰. Иргэдийн хамгийн ихээр хохирч байгаа гэмт хэргийн төрөлд хулгайлах, залилах, хүний эрүүл мэндэд хохирол учруулах, зам тээврийн осол багтаж байна.

Гэмт хэргийн индексийн гаргадаг Олон Улсын байгууллагын судалгаагаар 2022 онд Монгол Улс дахь иргэдийн аюулгүй байдлын түвшин 37.4 хувь, иргэд гэмт хэрэгт өртөх гэмт хэргийн түвшин 62.5 хувьтай байгаа нь дэлхийн 118 улсаас 16 дугаарт орсон бол 2023 оны байдлаар иргэдийн аюулгүй байдлын түвшин 40.9 хувь, гэмт хэргийн түвшин 59.3 хувьтай болж өмнөх жилтэй харьцуулахад нөхцөл байдал бага зэрэг сайжирч 21 дүгээр байрт оржээ¹¹. Харьцуулсан судалгааны дүнгээс үзэхэд Монголчуудын 71.1 хувь нь ойрын 3 жилийн хугацаанд гэмт хэрэг өснө гэж санаа зовниож байгаа бол эд хөрөнгөө хулгайд алдана, бусдын халдлагад өртөнө гэхээс 64.8 хувь нь түгшиж байна¹².

Шүүн таслах ажиллагаа: Монгол Улсад сүүлийн 13 жилийн дунджаар 100,000 хүн тутамд ноогдох сэжигтний тоо 694 байж, түүнээс 288 буюу нийт сэжигтний 41.4 хувь нь шүүхээр ял шийтгэгдэж байсан. 100,000 хүн тутамд ноогдох хорих ял оногдуулалтын түвшин дунджаар 196 байсан бол 2015 оноос тогтвортой буурч, 2010 онтой харьцуулахад 2 дахин буурсан байна. Харин хорихоос өөр төрлийн ял оногдуулалтын түвшин огцом нэмэгджээ.

2006-2014 оны хооронд 100,000 хүн амд ноогдох хорих ялын түвшинд огцом өөрчлөлт ажиглагдахгүй байгаа нь 2002 онд батлагдсан эрүүгийн хуулийн ялын бодлоготой холбоотой. Хэдийгээр ял шийтгүүлэгчдийн тоо буурч байгаа ч нийт ял шийтгүүлэгчдийн 70 орчим хувь нь хорих ялаар шийтгүүлж байсан нь харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын нэмэлт II протоколд нэгдэн орсонтой¹³ холбогдуулан цаазаар авах ялын төрлийг хасаж, энэ онцгой ялын оронд бүх насаар хорих ялыг ялын төрөлд нэмсэн.

¹⁰ Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын 2020 оны 141дүгээр тогтоолын хавсралт

¹¹ https://www.numbeo.com/crime/rankings_by_country.jsp

¹² <https://www.numbeo.com/crime/comparison.jsp>

¹³ 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар соёрхон баталсан.

Эрүүгийн хуульд заасны дагуу хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхдээ ихэвчлэн хорих ялыг биечлэн эдлүүлэх эсвэл тэнсэх гэсэн хэлбэрээр гүйцэтгэдэг. Сүүлийн 13 жилийн дунджаар жилд 5592 хүнд хорих ял оногдуулснаас 3047 буюу 55.6 хувийг нь тэнссэн, 2545 буюу 45.5 хувийг нь биечлэн эдлүүлэх хэлбэрээр хэрэгжүүлжээ. 2016 оноос шүүхээс тэнсэх арга хэмжээг хэрэглэх хандлага нэмэгдсэн нь хорих ял биечлэн эдлэх явдлыг багасгах, гэмт хэрэг үйлдсэн хүний гэм бурууг өөрөөр нь ухамсарлуулах, хохирол нөхөн төлүүлэх, нийгмээс тусгаарлахгүй байхад анхаарч цаашид “мэргэшсэн гэмт хэрэгтэн” бий болгохгүйн тулд авч байгаа ялын бодлоготой холбоотой. Шүүхээс ял оногдуулахгүйгээр тэнссэний үндсэн дээр түүнд үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын хэрэглэнэ.

Хорих ял эдлүүлэх ажиллагаа: 2015 оны Эрүүгийн хуулийн ялын бодлоготой холбоотойгоор хорих ангийн хүн амд өөрчлөлт гарч байна. Улсын хэмжээнд 2018 оны байдлаар 22 хорих анги байгаагаас хаалттай хорих анги 10, нээлттэй-хаалттай хорих анги 4, нээлттэй хорих анги 7, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага 1 байгууллагад нийт 3500 гаруй хоригдол ял эдэлж байна. Монгол Улсад 100,000 хүн амд ноогдох хоригдлын түвшин 2013 онд 237 байсан нь сүүлийн 13 жилийн хугацаанд дахь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд 2017 онтой харьцуулахад 2.5 дахин өндөр үзүүлэлттэй байжээ. 2009-2013 онд хоригдлын түвшин тогтвортой өссөн бол 2014 оноос буурах хандлага ажиглагдаж 2018 оны байдлаар 100.000 хүн амд ноогдох хоригдлын түвшин 109 болжээ¹⁴. Харин энэ үзүүлэлт 2020 оноос жил дараалан буурах хандлагатай байсан бол 2023 оны байдлаар 112 болж өссөн үзүүлэлттэй байна.

Шинээр баталсан Эрүүгийн хуульд хугацаатай хорих ялын хэмжээг тогтоох, ялын бодлогыг зөөлрүүлэх, ялын олон сонголттой, уян хатан болгох, хорих ялыг эцсийн арга хэмжээ болгон оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлалгүйгээр хорихоос өөр төрлийн ял оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх зэргээр нийгэм, хамт олны дунд хүмүүжүүлэх, дахин нийгэмшүүлэхэд анхаарах ялын бодлого хэрэгжүүлсэн нь хорих ялын түвшнийг бууруулж, хорихоос өөр төрлийн ял оногдуулах бодлогод шууд нөлөөлсөн.¹⁵

¹⁴ Дотоод хэргийн их сургууль, Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, Шүүхийн шийдвэр судлалын төв. “Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, 2003-2018 он”, УБ., 2019

¹⁵ С.Гантулга, Б.Энхболд. Монгол Улсын ялын бодлогын өөрчлөлт (2012-2017). Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл. 2017. №1

2008 оноос эмэгтэй хоригдлын түвшин тогтвортойгоор өссөн үзүүлэлтэй байна. Харин 100,000 хүн амд ноогдох насанд хүрээгүй хоригдлын түвшин 2006, 2009 онуудад 0,1 буюу хамгийн бага үзүүлэлтэй байжээ. Хамгийн өндөр үзүүлэлт нь 2005 онд 3,3 буюу 10 жилийн дунджаас 2,5 дахин өндөр үзүүлэлттэй байжээ. Монгол Улсад 100,000 хүн амд ноогдох шоронгоос суллагдагсдын түвшин дунджаар 114,0 буюу шоронд шинээр нэмэгдэж буй хоригдлын түшингээс 12,1 хувиар доогуур байна. Харин 2006 онд шоронгоос суллагдагсдын түвшин 196,6 буюу шоронд шинээр нэмэгдэж буй хоригдлын түшингээс 183,3 хувь, 2009 онд 176,9 буюу 78 хувиар тус тус өндөр өндөр үзүүлэлттэй байжээ. Бусад жилүүдэд нь шинээр шоронд нэмэгдэж буй хоригдлын түвшин шоронгоос суллагдаж буй хоригдлын түшингээс тогтмол дээгүүр байж иржээ¹⁶.

Эмэгтэйчүүдээс үйлдсэн гэмт хэрэг нь нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин бага боловч эрүүгийн хуульд хорих ял шийтгэхээр заасан хүнд гэмт хэрэг үйлддэг онцлогтой. Хорих ял эдэлж байгаа эмэгтэй ялтнуудын үйлдсэн гэмт хэрэгт дүн шинжилгээ хийж үзэхэд 56,3 хувь нь бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж их хэмжээний хохирол учруулсан, 19,3 хувь нь хүнийг алсан, 5,6 хувь нь хүн худалдаалах болон мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн байна. Тиймээс тэдэнд оногдуулах хорих ялын хугацаа харьцангуй урт байдаг ба нэг жилд шоронгоос суллагдаж буй эмэгтэй ялтны тоо харьцангуй бага байна. тухайлбал сүүлийн 11 жилийн байдлаар жилд дунжаар 29 эмэгтэй ялтан хорих ангиас суллагдсан бол 112 ялтан шинээр нэмэгдэж байна¹⁷. Түүнчлэн насанд хүрээгүй ялтны түвшин харьцангуй доогуур байгаа нь хүүхдэд хорих ял оногдуулахаас аль болох татгалзах, эцэг эх, олон нийтийн хяналтад өгөх арга хэмжээ голчлон хэрэглэдэг болсонтой холбоотой.

2006, 2009 онд хорих ял эдэлж байсан насанд хүрээгүй хоригдолд өршөөл үзүүлж сулласантай холбоотойгоор насанд хүрээгүй хоригдлын түвшин бага байсан бол 2017 онд шинээр батлагдсан Эрүүгийн хуульд заасан өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тусгай журам, ялын бодлого хөнгөрүүлсэн нөхцөл байдалтай холбоотой.

¹⁶ Дотоод хэргийн их сургууль, Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, Шүүхийн шийдвэр судлалын төв. “Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, 2003-2018 он”, УБ., 2018

¹⁷ Дотоод хэргийн их сургууль, Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, Шүүхийн шийдвэр судлалын төв. “Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, 2003-2018 он”, УБ., 2018

2. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагад итгэх олон нийтийн хандлага

Цагдаа, шүүхэд итгэх олон нийтийн хандлага нь төрд итгэх иргэдийн хандлагыг тодорхойлох гол шалгуур болдог. Цагдаа, шүүхийн үйл ажиллагаа хуульд нийцсэн шударга байгаа эсэх, тухайн салбарт хэрэгжүүлж буй шинэчлэл, түүний үр нөлөөнд үнэлгээ өгөх, цаашид хэрэгжүүлэх бодлого боловсруулахад олон нийтийн санаа бодол онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Цагдаад итгэх олон нийтийн хандлага гэж гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, олон нийт, иргэдийн аюулгүй байдлыг хангаж буй байдалд иргэдээс өгч буй үнэлгээ. Цагдаад итгэх олон нийтийн хандлагыг үнэлэхдээ гэмт хэргийн нөхцөл байдал, иргэдийн гэмт хэрэгт хохирох явдал, иргэдийн аюулгүй байдлын түвшин, үйл ажиллагааны ил тод, шуурхай байдал, алба хаагчийн харилцаа-ёс зүйн үзүүлэлтээр тодорхойлдог¹⁸.

Монголчуудын цагдаад итгэх хандлага, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар гадаад, дотоодын байгууллага, судлаачдын хийсэн судалгааны дүнгээс үзвэл иргэдийн цагдаад итгэх хандлага дунд ба түүнээс доогуур түвшинд байна гэж дүгнэжээ¹⁹. Харин Цагдаагийн Ерөнхий Газрын захиалгаар хөндлөнгийн байгууллагуудын хийсэн дүгнэлтээр цагдаад итгэх олон нийтийн хандлага жил бүр нэмэгдэж байгаа талаар дурдсан нь зөрүүтэй үр дүнг харуулж байна.

Нээлттэй нийгэм форум, Дотоод хэргийн их сургуулийн хамтарсан судалгааны баг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг 5 бүлгийн 32 асуултаар үнэлж үзэхэд 3.25 гэсэн үнэлгээ авсан нь цагдаад итгэх олон нийтийн хандлага “**дундаж**” түвшинд байгааг харуулж байна. Судалгаанд оролцогчид алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтөд (2.96) сэтгэл ханамжгүй байжээ²⁰.

¹⁸ Enkhbold. B “Confidence in the police among Mongolian immigrants in South Korea and native Mongolians in Mongolia: A comparative test of conceptual models”, International Journal of Law Crime and Justice, 2017 №3(50)

¹⁹ Максима төв “Цагдаагийн байгууллагын болон цагдаагийн албан хаагчийн талаарх Улаанбаатар хотын иргэдийн санал бодол” судалдгааны тайлан, УБ., 2008, Шинжлэх Ухааны Академийн Философи, социологи эрхийн хүрээлэн “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдал, боловсронгуй болгох чиглэл” социологийн судалгааны тайлан. УБ., 2008, Азийн сан “Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа”, УБ., 2008,

²⁰ Нээлттэй нийгэм Форум, Дотоод хэргийн их сургууль, “Цагдаагийн байгууллага: хэрэглэгчийн үнэлгээ-2017”, УБ.,2018, 107 дахь тал

Хэдийгээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, цагдаад итгэх олон нийтийн хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байгаа ч иргэд, ялангуяа гэмт хэргийн улмаас эрх ашиг нь хөндөгдсөн иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд төдийлөн сэтгэл ханамжгүй байх хандлага ажиглагдсаар байна. Энэхүү хандлага удаан үргэлжлэх нь иргэд гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг цагдаад мэдээлэхгүй байх, улмаар иргэд оршин суугаа нутаг дэвсгэртээ аюулгүй тайван амьдрах итгэлгүй болж, гэмт хэргээс түгших мэдрэмж нэмэгдэх хандлагатай байна.

Шүүхэд итгэх олон нийтийн хандлага гэж шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмж, шүүхийн үйл ажиллагааны ил тод, шударга байдлын талаар иргэдээс өгч буй үнэлэлт. Шүүхэд итгэх хандлагыг шүүхийн үйл ажиллагаа, шударга байдал, шүүхийн хараат бус байдал, шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийн байдал зэрэг үзүүлэлтээр хэмждэг.

Шүүхийн шинэтгэлийн үйл явц эхлэхээс өмнө 2008 онд нээлттэй нийгэм форумаас хийсэн хөндлөнгийн судалгааны дүнгээр шүүхэд итгэх итгэл 23.0 хувь, 2010 онд Сант марал судалгааны төвийн хийсэн судалгаагаар энэ үзүүлэлт 15.0 хувьтай болж буурч, 2015 онд 40 хувьтай болж тогтвортой өсөх хандлага ажиглагдаж байна.

Шүүхэд итгэх иргэдийн итгэл нэмэгдэж байгаа нь шүүхийн шинэтгэлийн бодлого, үйл ажиллагаа тодорхой болж, эрчимтэй хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой бөгөөд судалгаанд оролцсон хоёр хүн тутмын бараг нэг нь шүүх аливаа хэрэг маргааныг зөвхөн хуульд захирагдан үнэн зөв, шударгаар шийдэж байна гэсэн итгэлтэй болсон гэж дүгнэжээ²¹.

Шүүхээр үйлчлүүлсэн болон шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэдийн 60.6 хувь нь өнөөдөр шүүх хэрэг маргааныг хуульд нийцүүлэн шударгаар шийдвэрлэж байна гэдэгт **итгэдэг** гэж хариулсан ба энэ үзүүлэлт шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн хувьд бүүр өндөр 81.4 хувь нь шүүхийн үйл ажиллагаа шударга болно гэдэгт итгэж байна. Харин шүүхээр үйлчлүүлээгүй иргэд шүүх хэрэг маргааныг шударга ар шийдвэрлэдэг гэдэгт итгэдэггүй 39.8 хариулжээ. Судалгаанд оролцогчдын 32.5 хувь шүүгчийн мэдлэг, чадварт эргэлздэг гээд цаашид шүүгчид сайн хүнийг томилох (45 хувь), шүүгч, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх (40 хувь) шаардлагатай гэснээс үзэхэд манай

²¹ Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн. “Шүүхэд итгэх иргэдийн итгэл”, санал асуулгын судалгааны тайлан. УБ., 2015

улс мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоог сайжруулах шаардлагатай байна. Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн судалгааг Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс бусад хөндлөнгийн байгууллагаар хийлгэх нь олон талын ач холбогдолтой бөгөөд 2015 оноос хойш энэхүү судалгааг шүүхийн захиргааны байгууллага өөрсдөө гүйцэтгэж байгааг анхаарах нь зүйтэй. Учир нь авлигад хамгийн хамгийн их автсан салбарын эхний 5-т шүүхийн байгууллага 4.01 үнэлгээтэй²² орсон байгаа нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл шүүхийн авлига их байх тусам иргэдийн шүүхэд итгэх хандлага буурдаг.

Дүгнэлт, зөвлөмж

Монгол Улсад гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны шинэчлэл Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан тасралтгүй хийгдэж байгаа ч гэмт хэрэгтэй тэмцэх, иргэдийн аюулгүй орчинд амьдрах баталгаа бүрдээгүй байгаа ба үүнтэй холбоотойгоор хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагад итгэх олон нийтийн хандлага төдийлөн сайн биш байна.

Тиймээс гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны үйл ажиллагааг үр нөлөөтэй болгох, олон нийтийн итгэлийг хүлээх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авах шаардлагатай.

1. Цагдаа, прокурор, шүүх, хорих байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн үр нөлөөнд тогтмол дүн шинжилгээ хийж, иргэдийн аюулгүй байдлыг хангах, байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн нэмэлт өөрчлөлтийг тогтмол хийж байх;
2. Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, шүүхийн шийдвэр биелүүлэх, ял эдлүүлэх ажиллагааг олон нийтэд түшиглэсэн онол арга зүйд тулгуурлан явуулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
3. Прокурорын байгууллагын нэгдмэл төвлөрсөн удирдлагын тогтолцоог өөрчлөх, прокурорын мэргэжлийн, хараат бус байдлыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд хяналтын чиг үүргээ сонгодог агуулгаар нь хэрэгжүүлэх, мөрдөн шалгах зарим ажиллагааны зөвшөөрлийг шүүхэд шилжүүлэх;

²² Азийн сан “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа”, УБ, 2018, 52 дахь тал

4. Гэмт хэргийн статистикийн тогтолцоог боловсронгуй болгож, гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны нэгдсэн сан бүрдүүлэх;
5. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд техник технологи, хиймэл оюун ухааны ололтыг ашиглах, инновацыг нэвтрүүлэх;
6. Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагад итгэх олон нийтийн хандлагыг нэмэгдүүлэх, түүнийг үнэлэх арга зүйг боловсруулж тодорхой хугацаанд судалгааг явуулж хэвших зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

Нэг. Монгол Улсын хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль//Төрийн мэдээлэл, УБ., 1992 №1
- Цагдаагийн албаны тухай хууль// Төрийн мэдээлэл, УБ., 2017 №8
- Тагнуулын байгууллагын тухай хууль// Төрийн мэдээлэл, УБ., 1999 №35
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль// Төрийн мэдээлэл, УБ., 2017 №23
- Авлигатай тэмцэх тухай хууль// Төрийн мэдээлэл, УБ., 2006 №35
- Шүүхийн шинжилгээний тухай хууль// Төрийн мэдээлэл, УБ., 2010 №2
- Монгол Улсын шүүхийн тухай хууль// Төрийн мэдээлэл, УБ., 2012 №11
- Прокурорын байгууллагын тухай хууль// Төрийн мэдээлэл, УБ., 2017 №24
- Эрүүгийн хууль// Төрийн мэдээлэл, Уб., 2016 №7
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль//Төрийн мэдээлэл, УБ., 2015
- Цагдаагийнбайгууллагынхөгжлийнхөтөлбөр, Засгийнгазрын2020оны141 дүгээр тогтоолын хавсралт
- Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал-Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны А/118 дугаар тушаал

Хоёр. Сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл

- С.Жанцан, Монгол Улсын шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо, УБ., 2003

Гурав. Судалгааны материал, эмхэтгэл, өгүүлэл

- Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: хэрэгжилт, чиг хандлага, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2018
- Enkhbold.B “Criminal Justice System in Mongolia”, 2015, 한국테러학회보 제8권 제4호 , 159~186쪽, 전체 28쪽,
- Ж.Алтансүх,. Монгол Улсын эрх зүйн шинэтгэл, Хууль дээдлэх ёс// Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэтгүүл, 2020 12 (77)
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 39 дүгээр захирамжаар батлагдсан
- Дотоод хэргийн их сургууль, Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, Шүүхийн шийдвэр судлалын төв. “Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, 2003-2018 он”, УБ., 2019
- С.Гантулга, Б.Энхболд. Монгол Улсын ялын бодлогын өөрчлөлт (2012-2017). Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл. 2017. №1
- Enkhbold. B “Confidence in the police among Mongolian immigrants in South Korea and native Mongolians in Mongolia: A comparative test of conceptual models”, International Journal of Law Crime and Justice, 2017 №3(50)
- Максима төв “Цагдаагийн байгууллагын болон цагдаагийн албан хаагчийн талаарх Улаанбаатар хотын иргэдийн санал бодол” судалгааны тайлан, УБ., 2008,
- Шинжлэх Ухааны Академийн Философи, социологи эрхийн хүрээлэн “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдал, боловсронгуй болгох чиглэл” социологийн судалгааны тайлан. УБ., 2008,
- Азийн сан “Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа”, УБ., 2008,

- Нээлттэй нийгэм Форум, Дотоод хэргийн их сургууль, “Цагдаагийн байгууллага: хэрэглэгчийн үнэлгээ-2017”, УБ.,2018
- Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн. “Шүүхэд итгэх иргэдийн итгэл”, санал асуулгын судалгааны тайлан. УБ., 2015
- Азийн сан “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа”, УБ.,2018, 52 дахь тал

Дөрөв. Цахим хуудас

https://www.numbeo.com/crime/rankings_by_country.jsp

<https://www.1212.mn/>



Т.МӨНХТУНГАЛАГ

Докторант, Авлигатай тэмцэх газрын Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах ахлах ажилтан, ахлах комиссар

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХЭД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Role an participation of the mass media in anti-corruption activities

Хураангуй: Авлига нь аливаа улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг бөгөөд энэхүү хорт үзэгдэлтэй тэмцэхэд хэвлэл мэдээлэл онцгой үүрэг гүйцэтгэх боломжтой. Уг өгүүлэлд авлига гэж юу болох, түүний хэлбэр, шалтгаан нөхцөлийн талаар товч дурдсан бөгөөд авлигатай тэмцэхэд, тэр дундаа авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигыг үл тэвчих үзлийг нийгэмд төлөвшүүлэхэд хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүрэг, боломжийн талаар хөндөв.

Summary: Corruption has a negative impact on the economic and social development of any country and the public media tools play a specific role in combating this toxic phenomenon. In this publication, I briefly described on what is the corruption, on its forms and causes and I discussed on roles and opportunities of the mass media in combating against the corruption, including preventing from corruption crimes and on how to develop an attitude of zero tolerance in the society against the corruption.

Түлхүүр үгс: Авлига, хэвлэл мэдээлэл, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигыг үл тэвчих үзэл, хандлага.

Keywords: Corruption, media, prevention of corruption crimes, public education against corruption, zero tolerance for corruption.

Оршил. Хүйтэн дайн дууссанаар дэлхийн улс орнууд даяаршлын эрин зуунтай золгох цаг үед “Авлига” гэх сөрөг үзэгдэл яригдах болов. “Нийгмийн хорт хавдар” гэж нийтээрээ хүлээн зөвшөөрсөн авлига нь тухайн улс орны тогтвортой хөгжилд заналхийлж, ардчиллын төлөвшилд саад учруулж, нийгмийн шударга ёсыг боомилдог. Хууль дээдлэх ёсыг алдагдуулан, зах зээлийн жам ёсны хөгжлийг гажуудуулж, улмаар улс үндэсний аюулгүй байдалд ноцтой аюул учруулдаг авлигатай тэмцэхийн тулд Монгол Улсын төр, засгаас багагүй хүчин чармайлт гаргасаар байгаа хэдий ч дорвитой ахиц өөрчлөлт харагдахгүй байна.

Авлигыг үүсгэгч нөхцөл, шалтгааныг төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай холбон авч үздэг боловч нөгөө талд иргэдийн эрх зүйн мэдлэг, ойлголт муу байгаа нь авлигын гэмт хэрэг, зөрчил нэмэгдсээр буйн бодит нөхцөл, шалтгаан болдог. Авлигыг бууруулахад хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоо өндөр түвшинд байдгийг авлигатай тэмцэх чиглэлээр ажилладаг судлаачид цохон тэмдэглэсэн. Тэр дундаа иргэд, олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хэвлэл мэдээллийн манлайлал хамгийн түрүүнд тавигдах шаардлагатай. Тиймээс уг өгүүллээр авлигатай тэмцэхэд хэвлэл мэдээллийн үүрэг, оролцооны өнөөгийн нөхцөл байдал, цаашид анхаарах зарим асуудлыг хөндөж байна.

Олон улсын авлигатай тэмцэх байгууллагууд авлигыг илрүүлэхэд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн голлох үүрэг гүйцэтгэх талаар олон удаагийн зөвлөмждөө дурдсаар байна. Боловсронгүй эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь төрийн байгууллагууд, цаашлаад улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг доройтуулж болзошгүй нарийн зохион байгуулалттай, том хэмжээний авлигын хэргүүдийг илрүүлж чадна (ЕАБХАБ, 2016). Хэдий тийм боловч авлигатай тэмцэхэд дан ганц эрэн сурвалжлах сэтгүүл зүйгээр хязгаарлалгүй хэвлэл мэдээллийн байгууллагууд бүхэлдээ нийтлэг байдлаар, ялангуяа авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд авлигын хор аюулыг ухуулан таниулах чиглэлээр нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх, авлигыг үл тэвчих уур амьсгалыг бүрдүүлэхэд анхаарч ажиллах цаг үеийн шаардлага бий болоод байна.

Юуны өмнө авлига гэж юу болох, авлигын илрэх хэлбэрүүд, нийгэмд учруулах хор хөнөөлийн талаар товч дурдах шаардлагатай. Я.Цэвэлийн

“Монгол хэлний тайлбар толь бичиг”-т “авлига” гэдэг үгийг нэгдүгээрт, эдэд шунах, ёсон бус аргаар юмыг олзолж авах, хоёрдугаарт, хээл хахууль гэсэн утгаар тайлбарласан байна (Я.Цэвэл, 1966). Харин авлига буюу “corruption” гэдэг үг нь “corruptio” гэсэн латин үгнээс гаралтай, ихэвчлэн эрх мэдэлтэй хүний гаргадаг шударга бус үйлдэл, ёс суртахуунгүй зан чанар, хууль бус үйлдлийг хэлнэ гэж англи хэл зүйн толь бичигт мөн тайлбарлажээ (Longman Group, 1995).

Авлига нь нийгэм дэх шударга бус үйлдэл, шан харамж, ёс суртахууны доголдол зэрэг үйлдлийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт болох нь судлаачдын тодорхойлолтод тусгагджээ. Тухайлбал, өөрт ноогдсон эрх мэдлийг хувийн зорилгод ашиглах явдлыг авлига гэнэ (ТИ, 2002). Авлига нь төрийн албан хаагч өөрт олгогдсон эрх мэдлийг урвуулан ашиглаж, өөрөө ашиг олох, өөрийн дотнын хүмүүсийг зүй бусаар хууль зөрчин баяжуулах, хууль бусаар мөнгө төгрөг, эд бараа, эзэмшлийн бусад эрхийг шууд олж аваад хариуд нь бусад давуу эрх олгох байдлаар илэрнэ (Нээлттэй нийгэм форум, 2006).

Манай улсын Авлигын эсрэг хуульд “Авлига гэж... албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ” (УИХ, 2006) хэмээн тодорхойлсон юм. Дээрх бүх тодорхойлолтоос харахад нийгэм дэх сөрөг үзэгдлийн нэг болох авлига нь нийтийн ашиг сонирхлыг худалдсанаар хувийн ашиг сонирхлыг хангах зүй бус үзэгдэл гэж тодорхойлогдохоор байна.

Авлига юунаас эхэлдэг вэ, ямар шалтгаанаар бий болдог вэ, ямар нөхцөлд үүсдэг вэ гэдэг талаар эрдэмтэн судлаачид янз бүрийн онол дэвшүүлжээ. Харьцуулсан авлига судлаачдын анхдагчдын нэг Майкл Жонстон “Авлигын синдром” бүтээлдээ “Авлигын сонирхол дэврэхээс өмнө, “Транспэрэнси интернэшнл” байгууллага авлигын төсөөллийн индекс тооцдог болохоос урьтаж, авлигатай тэмцэх байгууллага байгуулахаас наана, 1980-аад онд хүйтэн дайны дараа авлигын синдром үүссэн юм” (Майкл Жонстон, 2021) гэж онцолжээ. Үүнийг дэлгэрүүлэн авч үзвэл өмчийг нийтийн ба хувийн хэмээх ангилалд хуваах болсон цаг үеэс “төсвийн мөнгийг хувьдаа ашиг унагах зорилгоор буруугаар ашиглах, завших” гэдэг ойлголт бий болсон. Өөрөөр хэлбэл, энэ цаг үеэс авлига гэх үзэгдэл, түүнийг дагасан ойлголт, тодорхойлолтууд үүссэн. Гэхдээ танил талдаа давуу байдал үзүүлэх, тал тохой

татах зэрэг харилцаа, хандлага хүн төрөлхтний түүхийн аль ч цаг үед байжээ.

Судлаач Д.Зүмбэрэллхам авлигын шалтгаан, нөхцөлийг олон улсын түвшинд даяарчлал, социалист систем задран унасны дараах социалист орнуудад явагдсан хувьчлал, улсын баялгийг хуваах ажиллагаатай холбон авч үзсэн байна. Монгол Улсад ч мөн өмч хөрөнгөний төлөөх өрсөлдөөн, богино хугацаанд хөлжин хөрөнгөжих, ил далд бүхий л аргыг ашиглан өмчтэй болох өрсөлдөөнд хүмүүс авлигыг ашиглаж эхэлсэн гэж дүгнэжээ (Д.Зүмбэрэллхам, 2007). Зарим тодорхойгүй эх сурвалжийн бичсэнээр, 1994 оны 12 дугаар сард болсон Америк тивийн удирдагчдын дээд хэмжээний анхны уулзалтаар хүйтэн дайны дараах дэлхий нийтийн сэтгэл түгшээсэн, анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай асуудлаар авлигыг нэрлэсэн бөгөөд энэ нь олон улсын түвшинд авлигатай тэмцэх хамгийн эхний дуу хоолой, хүсэл зоригийн илэрхийлэл байсан гэж үздэг.

Монгол Улсын Их Хурал 2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталснаар Монгол Улсад анх удаа авлигатай тэмцэх тусгай байгууллага болох Авлигатай тэмцэх газар байгуулагдаж, 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх чиг үүрэг нь тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа бөгөөд Авлигатай тэмцэх газар ч мөн энэхүү чиглэлийг баримтлан ажиллаж байна. “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” гэж авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээний цогцолборыг хэлдэг (УИХ, 2006) бол “олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа” гэж олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах арга хэмжээний цогцолбор (УИХ, 2006) хэмээн ойлгоно.

Авлигатай хийх тэмцлийн тэргүүн эгнээнд авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх чиг үүргийг авч үздэг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн бодлоготой нарийн нягт холбоотой юм. Аливаа төрлийн гэмт хэргийг нэгэнт үйлдэгдсэний дараа хор уршгийг арилгах тухай ярих биш харин үйлдэгдэхээс өмнө, хор уршиг учруулахгүй байхад анхаарах нь хууль зүйн нэгэн зорилго байдаг билээ.


Авлигатай тэмцэх газар нь авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх үндсэн

бүтцэд Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс ажилладаг. Түүнчлэн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжилтийг иргэд, олон нийтэд тайлагнах, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах чиг үүрэгтэй Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан Тамгын хэлтсийн харьяанд ажилладаг. Энэ үүднээс Авлигатай тэмцэх газраас дараах 2 төрлийн мэдээлэл, сурталчилгааг олон нийтэд хүргэдэг. Үүнд:

1. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл;
2. Авлигын хор аюулыг ухуулан таниулах мэдээлэл сурталчилгаа (соён гэгээрүүлэх агуулга бүхий).

Авлигатай тэмцэх газраас хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлсэн талаарх үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэхдээ “Нэг цонх”-ны зарчмыг баримталдаг. “Нэг цонх” нь тус газрын www.iaac.mn албан ёсны цахим хуудас нь уг албан ёсны цахим хуудсаар дамжуулан мэдээ, мэдээллийг нийтэд түгээдэг. Ингэснээр мэдээллийн хариуцлагатай, албан ёсны эх сурвалжийг хамгаалж буй явдал.

Авлигатай тэмцэх газрын албан ёсны вэб сайт дээрх олон нийтэд хүргэсэн мэдээллүүдэд тоон болон чанарын шинжилгээ хийж, дүгнэлт хийж үзэв (Авлигатай тэмцэх газар, 2022). 2021 оны 1 дүгээр сарын 4-ний өдрөөс 2022 оны 1 дүгээр сарын 10-ныг өдрийг хүртэлх нэг жилийн хугацаанд Авлигатай тэмцэх газрын албан ёсны цахим хуудсанд нийтлэгдсэн 462 мэдээнд агуулгын шинжилгээ хийхэд 15 төрлийн утга агуулга бүхий мэдээг 950 удаагийн давталттайгаар олон нийтэд хүргэсэн байна. (Зураг №1)



Зураг №1. АТГ-аас олон нийтэд өгсөн мэдээллийн агуулга

*Авлигатай тэмцэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн
үүргэ, оролцоо*

Авлигатай тэмцэх газрын албан ёсны вэб хуудсанд нийтлэгдсэн мэдээллийн 20 хувь нь соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн агуулга бүхий мэдээлэл байсан бол 80 орчим хувь нь байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан, хэрэгжилтийг тайлагнасан агуулга бүхий мэдээлэл байна. Авлигатай тэмцэх газрын хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийн хэрэгжилтийг тайлагнасан мэдээ, мэдээлэл илт давамгайлж байгаа бөгөөд харин авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэх, арилгах чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа хангалтгүй байна.



Зураг №2. АТГ-аас олон нийтэд өгсөн мэдээллийн агуулгын шинжилгээ

Авлигатай тэмцэх газрын цахим хуудаснаас олон нийтэд хүргэж буй мэдээллийн 21.0 хувь нь байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг тайлагнасан агуулгатай байна. 14.8 хувь нь гомдол шийдвэрлэсэн статистик, 14.0 хувь нь үйл ажиллагаагаа танилцуулсан, 12.9 хувь нь гадаад болон дотоодын байгууллагатай хамтарч ажилласан, 11.2 хувь нь ХАСХОМ

шалгасан талаар, 10.9 хувь нь авлигын талаарх гадаад дотоод мэдээлэл, 2.9 хувь нь судалгаа шинжилгээ хийсэн тухай, 2.6 хувь нь төрийн байгууллага цахимжиж байгаа, 2.4 хувь нь хэрэг илрүүлж хохирол нөхөн төлүүлсэн, 2.1 хувь нь тодорхой нэг зөрчил шийдвэрлэсэн, 1.7 хувь нь мэдээлэгчийг хамгаалах хуулийн төслийн хэлэлцүүлэг, 1.3 хувь нь төр, засгийн тогтоол шийдвэр, 1.2 хувь нь 110 дугаарын танилцуулга, 1.0 хувь нь иргэний хамтын ажиллагааг сайжруулах зэрэг агуулга бүхий мэдээлэл эзэлж байна. (Зураг №2) Эндээс харахад авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх агуулга бүхий мэдээлэл 7.8 хувьтай байгаа нь чамлалттай байна.

Авлигатай тэмцэхэд хэвлэл мэдээллийн үүрэг. Дэлхийн аль ч улсад үндэсний шударга ёсны тогтолцоо бий. Энэхүү тогтолцоонд хэд хэдэн багана байх бөгөөд тэдгээр багануудын нэгд бие даасан чөлөөт хэвлэл мэдээллийг зүй ёсоор оруулдаг. Өөрөөр хэлбэл тунгалаг, ил тод, хариуцлагатай нийгмийг төлөвшүүлж чадах хамгийн хүчирхэг хоёр системийн нэг нь хараат бус шүүх засаглал, нөгөө нь бие даасан чөлөөт хэвлэл мэдээлэл гэдгийг бүрэн хүлээн зөвшөөрсөн. Чөлөөт хэвлэл мэдээлэл нь хараат бус шүүх засаглалын нэгэн адил улстөрчдийн өмнө хариуцлага хүлээх ёсгүй хоёр эрх мэдлийн нэг юм. Хоёул нийгмийн амьдралд коррупцитай тэмцэх хүчирхэг зэвсэг юм (Поуп, Авилгалын эсрэг сурвалж бичиг, 2003).

Авлигатай тэмцэх нь тухайн улсын дан ганц авлигатай тэмцэх байгууллагын ажил үүрэг мэтээр нийгмийн буруу ойлголт түгээмэл бий. Олон улсын авлигатай тэмцэх чиглэлээр мэргэшсэн судлаачид авлигатай тэмцэх нь бүх нийтийн оролцоо байх ёстой гэж үздэг. Тухайлбал, судлаач Б.Мөнгөнсүх “Хамгийн гол нь авлигатай тэмцэх нь зөвхөн АТГ-ын хийх ажил гэж бид үзэх нь буруу. Авлига бол нийгмийн өвчлөл. Авлига гэхээр л гэмт хэрэг, илрүүлсэн байдалд нь бид илүү анхаарал хандуулаад байж магадгүй. Үнэндээ нийгмийн бүх түвшинд ихээхэн хор хөнөөл учруулдаг, тэгш бус байдал бий болгодог, шударга ёсыг үгүй хийдэг өвчлөл. Хор хөнөөлийг нь зөвхөн насанд хүрэгчид хүртээд байгаа юм биш. Бяцхан хүүхдүүдээс авхуулаад өтгөс буурлууд хүртэл улс даяараа авлига, тэгш бус байдлын золиос болж байна. Тиймээс нийгмээрээ, бүхэлдээ шударга бус байдлын эсрэг өөр өөрсдийнхөө чадах зүйлийг хийж, дуу хоолойгоо хүргэх шаардлагатай” (Өнөөдөр, 2002) гэжээ.

Өнөө цагт хэвлэл мэдээллийн хэрэгслээр авлигын асуудлаар мэдээ, сурвалжилга бэлтгэн түгээхдээ авлига, албан тушаал, хээл хахуулийн гэмт

хэрэгт холбогдон шалгагдаж байгаа болон шүүхээр ял шийтгэгдсэн талаарх мэдээлэл давамгайлж байна.

Авлигыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрхэн мэдээлж байгаад шинжлэхээр “Өнөөдөр” сонинд 2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд гарсан хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаатай холбогдох мэдээ, сурвалжилгад дүн шинжилгээ хийв. 2022 оны эхний хагас жилд “Өнөөдөр” сонины нийт 104 дугаар хэвлэгдсэн байна. Үндэсний өдөр тутмын статустай “Өнөөдөр” сонин нь долоо хоногт 5 дугаар хэвлүүлдэг бөгөөд 8-16 нүүрээр хэвлэгддэг байна. Сонины редакцад Эрх зүй, экологийн мэдээллийн алба ажилладаг тул энэ чиглэлээр манай улсын хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны талаар мэдээ, сурвалжилга бэлтгэн “Хууль эрх зүй” сэдэвт төрөлжсөн нүүр гаргадаг. 2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд “Хууль эрх зүй” сэдэвт нийт 22 нүүр бэлтгэн хэвлүүлжээ. Дээр дурдсан хугацаанд тус сонинд тухайн сэдвээр нийт 347 мэдээлэл нийтлэгджээ.

Цэрэг, цагдаа, тагнуул, шүүх, Авлигатай тэмцэх газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг манай улсын хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой тэдгээр 347 мэдээ, нийтлэлийн 112 нь Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл байна. Мэдээллүүдийг ангилж үзвэл

- Авлигатай тэмцэх газраас явуулж буй мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой мэдээллүүд 96
- Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой мэдээллүүд 16 байна.

Тухайлбал, “НЭМГ-ын дарга Б.Бямбадоржийг АТГ-ынхан шалгаж эхэлсэн гэв үү”, “Эрдэнэт үйлдвэр”-ийн дахиад нэг орлогчийг яллагдагчаар татжээ”, “Хөгжлийн банкны захирал асан Н.Мөнхбат, Б.Батбаяр нар их наядаас дээш хэмжээний зээл олгожээ”, “АТҮТ-ийн хэлтсийн дарга К.Айдосыг гурван мэргэжилтний хамт шалгаж эхэллээ” гэх зэрэг гарчигтай мэдээллүүд давамгайлж байв. Энэ нь тухайн нэр бүхий албан тушаалтныг Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгаж байгаа талаарх мэдээлэл юм.

Харин албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой 16 мэдээлэл нь хуулийн хугацаа сануулсан утга агуулга бүхий нэг өгүүлбэр бүхий товч мэдээ байна. Нэг мэдээг жишээ болгон авъя.

Нэг өгцлбэрээр

Нийтийн албан тушаалтнууд ХАСХОМ-ээ шинэчлэн бүртгүүлэх ажил энэ сарын 1-нээс хоёрдугаар сарын 15-ныг дуустал явагдахтай холбоотойгоор АТГ-аас төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, салбар нэгжийн эрх бүхий албан тушаалтан, мэдүүлэг гаргагч нарт зөвлөмж өгчээ.

2022.01.04.№ 002 (7304)

Манай улсад яг одоогийн байдлаар Хөгжлийн банкны зээл олголтын хэрэг явдал олон нийтийн анхаарлын төвд байгаа. Энэ хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 2.9 их наяд төгрөгөөр тооцогдож байгаа бөгөөд одоогоор Хөгжлийн банкны эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох 25 эрүүгийн хэрэгт Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Сэтгүүлчдийн зүгээс мөрдөн шалгах хэргийн явц, таслан сэргийлэх арга хэмжээ, уг хэрэгт холбогдон шалгагдаж буй хүмүүсийн талаар зэрэгт голчлон төвлөрч мэдээллээ бэлтгэн түгээж байна. Хэрвээ авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн оролцоо өргөн хүрээнд бодит утгаараа хийгдэж байсан бол Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилготой төрийн өмчит Хөгжлийн банкнаас хэдэн их наядын чанаргүй зээл олгогдохгүй байв. Чанаргүй зээл олголтын цаана албан тушаал ашиглалтын, албан тушаалтны зүй бус үйлдэл байгаа нь тодорхой. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлд төвлөрч ажилладаг хэвлэл мэдээллийн тусламжтайгаар тэрхүү зүй бус үйлдлийг тухайн үед илчлэн мэдээлэх боломжтой байв.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын нэр бүхий удирдах албан тушаалтны хахууль авч байгааг Авлигатай тэмцэх газрын мөрдөгчид үйлдэл дээр нь илрүүлж, түүний албан өрөөнөөс болон оймс зэрэг зарим хувцаснаас валют, бэлэн мөнгө гарган хураан авсан хэрэг нийгэмд дуулиан дэгдээсэн билээ. Албан тушаалтан Б нь мэргэжлийн хяналтын байгууллагаас экспорт, импортын гэрчилгээ хүссэн бизнес эрхлэгчдийг хясан боогдуулах замаар хахууль авдаг байсан нь мөрдөн байцаалтын явцад тогтоогдож, улмаар шүүхээр шийдвэрлэгдсэн. “Оймсны хэрэг” гэгдэх энэ хэргийн талаар манай сэтгүүлчид хангалттай түвшинд мэдээ, сурвалжилга бэлтгэн хүргэсэн. Ингэхдээ тухайн албан тушаалтныг хэн болох талаас субьектив хандлагаар

голчлон мэдээлсэн. Үндсэндээ дуулиан хөөж сурвалжлан мэдээлсэн билээ. Харин яагаад ийм хэрэг гарах болсон нөхцөл шалтгааныг сэтгүүлчид хөндөөгүй. Юуны учир хахууль нэхсэн, яагаад бизнес эрхлэгчдийг хясан боогдуулсан, хахуулийн гэмт хэрэг үйлдэхэд хүргэж байгаа эрх зүйн орчин ямар байв, тухайн байгууллагын удирдлагын дотоод хяналт ямар түвшинд байсан бэ зэрэг асуудлаар анхаарлаа хандуулсангүй. Бид хэрэг явдлын мөн чанарт нь чиглэн анхаарлаа хандуулахгүй бол үйл явдал нь эзэн биеэ солиод дараа дахин давтагдана гэдгийг авлигын гэмт хэргийн статистик харуулж байна.

Авлигын гэмт хэргийн талаар мэдээлэхдээ дуулиан шуугиан үүсгэх, хандалт авах агуулгаар бус авлига гэх нийгмийн хорт үзэгдлийн хүрээг хумих, бага дээр нь таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг илрүүлэх, төрийн үйл ажиллагааг ил тод болгох чиглэлээр иргэний нийгмийн төлөөлөл, мэргэжлийн байгууллагууд, зорилтот бүлгүүдтэй хамтран авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийн бодлогоо чиглүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Сэтгүүлчид өөрийн мэдээлэх үүрэг, зарчмын дагуу нийгэмд дуулиан үүсгэж буй гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэхийг шууд буруутгах аргагүй. Гэвч үүнд анхаарах асуудал бас бий. Сэтгүүлчид авлигын үйлдэлд холбогдон шалгагдаж байгаа субъектийн талаар мэдээлэхдээ мөрдөн байцаалтын нууцад хамаарах асуудалтай хэт хутгалдаж болзошгүй байна. Энэ нь тухайн хүнийг гэм буруутай мэтээр нийгэмд ойлголт төрүүлэх эрсдэлтэй. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” хэмээн заасан бөгөөд шүүхээс өмнөх шатанд гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаа этгээдийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр буруутган мэдээлэх нь хүний эрхийг зөрчиж, эрх зүйт ёсыг хөсөрдүүлж байгаагийн нэгэн бодит жишээ болдог. Энэ нь эргээд сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйг зөрчихөд хүргэж болзошгүй.

Монгол Улсын Их Хурал 2016 онд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталснаар манай улс авлигатай тэмцэх стратеги, арга хэрэгслээ нарийвчлан тодорхойлсон. Уг хөтөлбөр нь төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх зорилготой. Хөтөлбөрийн дээрх зорилгыг хэрэгжүүлэхээр 11 зорилт дэвшүүлсэн бөгөөд эдгээр зорилтуудын

нэгд “иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх” гэж тусгасан нь хэвлэл мэдээллийн салбарт бүрэн хамаатай заалт юм.

Австрали улс төрийн захиргааны болон яам, тамгын газруудын үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэл хүрч байх боломжоор хангах, Засгийн газар болон төрийн байгууллагаас олон нийтэд өгч буй мэдээлэл нь баталгаатай байх шаардлагатайг Мэдээллийн эрх чөлөөний тухай хуульдаа тусгаж өгчээ. Гана улсын сэтгүүлчид “Шударга ёсны төлөөх мөнгө” (Cash for Justice), “Худалдах гэрээ” (Contracts for Sale) зэрэг эрэн сурвалжлах баримтат кинонууд хийсэн бөгөөд үүндээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь авлигыг илчлэхэд хэрхэн туслах боломжтой, бас хэрхэн хариуцлага тооцож, шинэчлэл хийх талаар шахалт үзүүлж болохыг өгүүлсэн байна.

Дүгнэлт. Авлига нь улс оронд аюул занал учруулж байгаа бодит үзэгдэл тул нийгмийн энэ өвчинтэй бүх нийтээрээ тэмцэх шаардлагатай. Авлигатай тэмцэх бүх нийтийн оролцоог нийгэмд төвлөрүүлэн зангидах, манлайлан чиглүүлэх гол хүч нь хэвлэл мэдээлэл юм. Хэвлэл мэдээлэл нь иргэний нийгмийн нэг хэсэг болдог. Энэ зарчмын дагуу төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, олон нийтэд мэдээлэл хүргэх чиг үүргээрээ дамжуулан авлигатай тэмцэх томоохон хүч болж чадна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь авлигыг илчлэх, олон нийтийг хяналтыг нэмэгдүүлэх, шүгэл үлээх, нийгмийн сэтгэл зүйг бүрдүүлэх, анхаарлыг хандуулах зэрэг авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хамгийн чухал үүрэг гүйцэтгэж чадна. Түүнчлэн иргэдэд авлигын нийгэмд учруулах хор хөнөөлийн талаар мэдээлэл өгч, авлигын эсрэг боловсрол олгож, авлигыг жигших үзэл санааг олон нийтэд төлөвшүүлэх нөөц, боломж бүрэн бий.

Хэвлэл мэдээлэл нь олон нийтийн санаа бодол, үйл ажиллагаанд хүчтэй нөлөө үзүүлдэг цорын ганц хэрэгсэл мөн тул төрийн байгууллага, албан тушаалтны авлигатай тэмцэх хууль тогтоомжоор хүлээсэн нийтлэг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд нь хяналт тавьж, Авлигатай тэмцэх газрын явуулж байгаа авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон иргэд, олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах ажилд байнгын нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр хэвлэл мэдээлэл өргөн оролцоотой ажиллах. Авлига үүсгэх шалтгаан, нөхцөлийн нэг нь төрийн байгууллага, албан тушаалтны батлан гаргасан шийдвэрүүд нь ил тод биш, сонирхогч бүлгүүдийн эрх ашигт нийцээгүй, хувийн ашиг сонирхлоо шургуулсан, хамаарал бүхий этгээддээ давуу байдал олгож байгаа нь түгээмэл. Хууль бус шийдвэр нэгэнт гарсны дараа түүнийг залруулахын тулд нийгэм даяараа шуугих биш харин хууль бус шийдвэр анхнаас нь гаргуулахгүйн төлөө иргэд, иргэний нийгмийн төлөөллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан төрийн байгууллага, албан тушаалтанд дуу хоолойгоо хүргэж, бодит хяналтаа тавьж байх нь зүйтэй.

Авлигын шалтгаан, нөхцөлийг илрүүлэн сурвалжлах, арилгах. Үйлдэгдсэн авлигын гэмт хэргийн мөрөөр сэтгүүлчид дуулиан шуугиан үүсгэн нийтэд мэдээлэхээс илүүтэй тухайн төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж, авлигын гэмт хэрэг гарахуйц шалтгаан, нөхцөлийг сурвалжлан илрүүлж, улмаар бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр өргөн хүрээнд ажиллах ёстой.

Авлигыг үл тэвчих үзэл, хандлага төлөвшүүлэх чиглэлд хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх. Авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах ажилд олон нийтийг оролцуулах, редакцууд нийтлэлийн бодлогоо авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгаанд чиглүүлэх, “Авлигын эсрэг боловсрол олгох хөтөлбөр”-ийг хэвлэл мэдээллийн байгууллагууд хамтран үе шаттайгаар зохион байгуулж, зөв мэдлэг, бодит мэдээлэл бүхий иргэдийг бий болгох шаардлагатай байна.


Эшлэл:

1. “Авлигатай тэмцэх гарын авлага”. 2016. 180-р тал
2. Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь”. 1966. 16-р тал
3. Longman Dictionary of Contemporary English, Long man Group Ltd, England, 1995, p.306
4. http://www.transparency.org/news_room/faq/corruption_faq
5. Нээлттэй нийгэм форум, “Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь”. 2006. 1-р тал

6. Майкл Жонстон. “Авлигын синдром” 2021, орч
7. Д.Зүмбэрэлхам. “Авлигын гэмт явдал: сургалтын гарын авлага”. 2007, 18-19 дэх тал
8. Жереми Поуп “Авлигын эсрэг сурвалж бичиг”. 2003. 174-р тал
9. Авлигын эсрэг хуулийн 3-р зүйлийн 3.1.6 дахь заалт, 2006 он
10. Авлигын эсрэг хуулийн 3-р зүйлийн 3.1.5 дахь заалт, 2006 он
11. Авлигатай тэмцэх газрын Олон нийттэй харилцах бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд хийсэн судалгаа, 2022 он
12. “Б.Мөнгөнсүх: Авлигын синдром бидний амьдралыг ч, ардчиллыг ч үгүй хийж байна” ярилцлага. “Өнөөдөр” сонин. 2022 он


Ашигласан эх сурвалж:

1. Longman Group. (1995). *Longman Dictionary of Contemporary English*. England, 306.
2. TI. (2002). *Transparency International*. <http://www.transparency.org>: http://www.transparency.org/news_room/faq/corruption_faq.
3. Авлигатай тэмцэх газар. (2022). *Олон нийттэй харилцах бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд хийсэн судалгаа*. Улаанбаатар, 5-6.
4. Д.Зүмбэрэлхам. (2007). *Авлигын гэмт явдал*. Улаанбаатар, 6.
5. ЕАБХАБ. (2016). *Авлигатай тэмцэх гарын авлага*. Улаанбаатар, 180.
6. Майкл Жонстон. (2021). *Авлигын синдром*. Улаанбаатар,
7. Нээлттэй нийгэм форум. (2006). *Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар, 1.
8. Өнөөдөр, С. (2002). Авлигын синдром бидний амьдралыг ч, ардчиллыг ч үгүй хийж байна. (Б.Мөнгөнсүх)
9. Поуп, Ж. (2003). *Авилгалын эсрэг сурвалж бичиг*. Улаанбаатар, 174-186.
10. УИХ. (2006). *Авлигын эсрэг хууль*. Улаанбаатар, 26-29.
11. Я.Цэвэл. (1966). *Монгол хэлний тайлбар толь бичиг*. Улаанбаатар, 16.



Р.БАЯРМАГНАЙ

*Авлигатай тэмцэх газрын
Хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар,
Хууль зүйн шинжлэх ухааны доктор,
профессор*



Б.БАТХУЯГ

*Авлигатай тэмцэх газрын
мөрдөгч, комиссар, хууль зүйн
докторант*

ЦАХИМ ХЭРЭГСЭЛ АШИГЛАН ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРГИЙГ ИЛРҮҮЛЭХЭД ХИЙМЭЛ ОЮУН УХААН АШИГЛАХ НЬ

“Application of Artificial Intelligence in the Detection of Cybercrime”

Хураангуй: Монгол Улсад цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд хиймэл оюун ухааныг ашиглах онолын болон арга зүйн үндэслэл, практик арга зам, хүртээмжтэй шийдлүүдийг судалж, шинжлэх, боловсруулах оролдлого өнөөдрийг хүртэл хийгдээгүй байна. Иймд уг судалгааны зорилго нь хиймэл оюун ухааныг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглаж буй гадаад улсын туршлагыг судалж, тэдгээрт дүн шинжилгээ хийхэд оршино.

Abstract: To date, no significant efforts have been made in Mongolia to study, analyze, or develop the theoretical and methodological foundations, practical approaches, or accessible solutions for applying artificial intelligence in the detection of crimes committed using digital tools. Therefore, the aim of this study is to examine and critically analyze the experiences of foreign countries that have employed artificial intelligence in combating crime.

Түлхүүр үг: Гэмт хэрэг, цахим, хиймэл оюун ухаан, туршлага.

Keywords: Crime, electronic, artificial intelligence, experience.

Нэг: Кибер гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, эрх зүйн зохицуулалтын талаар.

Монгол Улсын Үндсэн хууль (1992 он)-ийн 19 дүгээр зүйлд: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн адлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тунхагласан бол, мөн хуулийн 38 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэгт: “...Засгийн Газар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж чиг үүргээ тодорхойлсон юм. Харин мөн хуулийн 2 дугаар бүлгийн 14-19 дүгээр зүйлд бөгөөд 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт: “Иргэн нь халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална¹” гэж иргэний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан.

Орчин үеийн улс төр, нийгэм-эдийн засгийн хөгжлийн явцад баримтлах хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах, хууль зүйн баталгааг бүрдүүлэх асуудал нь Монгол төрийн томоохон зорилт, асар их хариуцлагатай үүрэг мөн.

Үндсэн хуулийн дээрх заалтуудыг нийгмийн шинэ орчинд хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангахын тулд нийгмийн бүхий л салбарт үйл ажиллагааны арга барилаа үндсээр нь өөрчлөх, шинэчлэлийг хийх хэрэгцээг бий болгосон билээ.

Үндсэн хуульд эрхэм зорилгоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх гэж тодорхойлсон нь ихээхэн алсын хараатайн дээр дэлхий нийтийн хөгжлийн чиг баримжааг үндсээр нь өөрчилсөн шинэ нийгэм буюу кибер орчинд хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангахад чиглэсэн Монгол төрийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтээр тодорхойлогдож байна.

Үүнд уялдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” баримт бичгийг баталж, Монгол Улсын алсын хараа, эрхэм зорилго, зорилт, зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон юм.

Энэхүү баримт бичигт хиймэл оюун ухааныг нийгмийн бүхий л салбарт нэвтрүүлэх чиглэлээр дараах зорилтыг дэвшүүлж, үйл ажиллагааг хэд хэдэн үе шаттай хэрэгжүүлэхээр тусгасан. Тухайлбал,

¹ Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл. Уб., 1992. №01


*Цахим хэрэгсэл ашиглан рйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд
хиймэл оюун ухаан ашиглаж нь*

Зорилт 2.4. Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлнэ.

II үе шат буюу 2031-2040 онд үндэсний шинжлэх ухаан, инновацыг дэлхийн зах зээлд гаргах тогтолцоог бүрдүүлэх үе хэмээн тооцоолж, нано, био, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг шинжлэх ухаан, инновацын тэргүүлэх чиглэлд оруулах хөрөнгө, нөөц болон бусад дэмжлэгийг нэмэгдүүлж, ногоон, цахим эдийн засаг, оюуны үйлдвэрлэлийн бүс нутгийн жишигт хүргэх², III үе шат буюу 2041-2050 онд нано, био, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг тэргүүлэх чиглэл, ногоон, цахим эдийн засаг, оюуны үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг дэлхийн жишигт хүргэх, олон улсад өрсөлдөх чадвартай шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлэх үе хэмээн тодорхойлжээ.

Хүн төрөлхтний технологийн дэвшил нь олон салбарт шинэ боломжуудыг нээж, амьдралыг хөнгөвчилж байна. Түүний нэгэн тод жишээ нь хиймэл оюун ухаан юм. Хиймэл оюун ухаан нь зөвхөн бизнес, эрүүл мэнд, боловсрол зэрэг салбарт төдийгүй гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Хууль сахиулах байгууллагууд хиймэл оюун ухааныг ашиглан гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагааг хөнгөвчлөх, хурдасгахад ихээхэн ач холбогдолтой ажээ.



² Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Уб., 2020. №52

Цагдаагийн байгууллагын хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг 37,514 бүртгэгдсэн байна. Үүнийг он тус бүрээр нь авч үзвэл 2020 онд 1,795, 2021 онд 4,825, 2022 онд 8,563, 2023 онд 9,270, 2024 онд 13,061 буюу 40,8 хувиар тус тус өссөн байна³. Цахим орчинд 2024 онд үйлдэгдсэн 13,061 хэргийн 10,892 буюу 83.4 хувь нь цахим орчинд үйлдэгдсэн залилах гэмт хэрэг эзэлж байна.

Системийн динамик загварт тулгуурласан судалгаагаар Монгол Улсад 2040 он хүртэл 10,000 хүнд ноогдох гэмт хэргийн тоо мөн үеэс 1.2 дахин буюу 117 болж өсөх төлөвтэй байна. Уг судалгаагаар нийт гэмт хэрэг 1.7 дахин, хулгайлах, цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн залилах, мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг 8 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 13 хувиар тус тус өсөх төлөвтэй гэсэн тооцоолол гарсан⁴.

Иймд цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй гэмт хэрэг өсөх хандлагатай байгаа тул гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэхэд хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэхэд хиймэл оюун ухааныг ашиглаж буй гадаад улсын туршлага

Хиймэл оюун ухааныг гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд ашиглаж буй гадаад улсын тэргүүн туршлагад дүн шинжилгээ хийхэд дараах туршлагыг нэвтрүүлсэн байна.Үүнд:

Нэг: Банк, санхүүгийн байгууллагууд хиймэл оюун ухааныг ашиглан гүйлгээний хэв маяг, хэрэглэгчийн зан төлөвийг шинжилж, залилах үйлдлийг илрүүлдэг. Машин сургалтын загварууд нь хэвийн гүйлгээний хэв маягийг суралцаж, тэдгээрээс хазайсан үйлдлийг автоматаар тодорхойлдог. Жишээлбэл, хэрэглэгчийн данснаас гэнэт их хэмжээний мөнгө гадаад улсад шилжсэн тохиолдолд систем анхааруулга өгч, банк арга хэмжээ авах боломжтой. Тухайлбал: Банкнууд хиймэл оюун ухааныг ашиглан АТМ-ын залилах болон скиммер төхөөрөмжийг илрүүлж байна⁵. Хиймэл оюун ухаан нь АТМ-ын үйл ажиллагааг хянаж, хэвийн бус зан төлөвийг тодорхойлдог бөгөөд

³ Тайван. С. Үндэстэн дамнасан аюул заналхийллийн эсрэг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб., 2025. 50 дахь тал

⁴ Мөн номын 51 дэх тал

⁵ <https://www.pymnts.com/news/security-and-risk/2018/ai-machine-learning-atm-fraud-detection/>

*Цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд
хиймэл оюун ухаан ашиглаж нь*

2018 онд нэгэн банкны хиймэл оюун ухаанд суурилсан систем нь тодорхой АТМ дээр гүйлгээний хэв маяг хэвийн бус байгааг илрүүлсэн. Мөрдөн байцаалтын явцад уг АТМ-д скиммер төхөөрөмж суурилуулж, үйлчлүүлэгчдийн картын мэдээллийг хулгайлж байсан гэмт хэрэгтнүүдийг баривчилсан байна.

Хоёр: Цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй залилах, мөрийтэй тоглоом зохион байгуулах, мөнгө угаах зэрэг гэмт хэргийг илрүүлэхэд хиймэл оюун ухааны технологи ашиглагдаж байна. AI системүүд гүйлгээний өгөгдлийг судалж нэгтгэн, хэвийн бус үйл ажиллагааг илрүүлдэг. Энэ нь санхүүгийн системийн аюулгүй байдлыг хангаж, хууль бус үйл ажиллагааг бууруулахад чухал үүрэгтэй. Тухайлбал: Америкийн нэгдсэн улсын HSBC банк хиймэл оюун ухаанд суурилсан системийг ашиглан гүйлгээний хэв маяг, үйлчлүүлэгчдийн зан төлөвийг судалж, нэгтгэн, хэвийн бус үйл ажиллагааг тодорхойлдог. 2018 онд тус систем нь их хэмжээний мөнгийг олон жижиг гүйлгээнд хувааж гадаад данс руу шилжүүлж байсан схемийг илрүүлсэн. Мөрдөн байцаалтын явцад энэ нь мөнгө угаах гэмт хэрэг болох нь тогтоогдож, сэжигтнүүдийг баривчилсан⁶. Энэ нь санхүүгийн системийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Мөн санхүүгийн байгууллагууд хиймэл оюун ухаан ашиглан мөнгө угаах нарийн төвөгтэй схемийг илрүүлж байна. Жишээлбэл, Standard Chartered банк хиймэл оюун ухаанд суурилсан системийг ашиглан гүйлгээний сүлжээ, холбоотой данснуудад дүн шинжилгээ хийж, хууль бус үйл ажиллагааг тодорхойлсон. Жишээ дурдвал 2019 онд тус банкны систем нь мөнгө угаах сүлжээг илрүүлж, мөрдөн байцаалтын явцад олон улсын гэмт хэргийн бүлгийг баривчилсан. Энэ нь санхүүгийн системийн аюулгүй байдлыг хангахад томоохон хувь нэмэр оруулсан.

Гурав: Хиймэл оюун ухаан нь онлайн орчинд хүүхдийн бэлгийн мөлжлөгийн материалыг илрүүлэх, устгахад ашиглагдаж байна. AI системүүд зураг, видео, текстийг судалж, хууль бус контентыг автоматаар илрүүлдэг. Microsoft-ын “Project Artemis” технологи нь хүүхдийн бэлгийн мөлжлөгийн зургийг илрүүлж, хууль сахиулах байгууллагуудад мэдээлдэг байна. Тухайлбал: Их Британийн Үндэсний гэмт хэргийн агентлаг (NCA) нь интернэт орчинд тархаж буй хүүхдийн бэлгийн хүчирхийллийн материалыг илрүүлэх, устгах

⁶ <https://www2.deloitte.com/uk/en/pages/financial-services/articles/ai-and-fight-against-financial-crime.html>

зорилгоор хиймэл оюун ухааны технологийг ашиглаж байна⁷. Тус агентлаг нь Image Analyzer гэх хиймэл оюун ухаанд суурилсан программ хангамжийг ашиглан сая сая зургийг автоматаар судлан, дүн шинжилгээ хийж, хууль бус контентыг илрүүлдэг байна.

Энэ технологи нь зураг дахь объектуудыг таних, насны ангилал хийх, зургийн мета өгөгдлийг шинжлэх замаар ажилладаг. Ингэснээр мөрдөгчид зөвхөн сэжигтэй зургуудад анхаарлаа төвлөрүүлж, ажлын үр дүнг дээшлүүлдэг. Үүний үр дүнд хэд хэдэн хохирогчийг аварч, гэмт хэрэгтнүүдийг баривчилсан юм.

Дээрх гадаад улсын туршлагаас дүгнэхэд хиймэл оюун ухаан нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн аюулгүй байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулж байна. Технологийн хөгжил нь хууль сахиулах байгууллагуудад шинэ боломжуудыг нээж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагааг хурдасгах, гэмт хэрэгтнүүдийг барихад тусалдаг. Гэсэн хэдий ч хиймэл оюун ухааныг ашиглахдаа хувийн нууц, ёс зүй, хүний эрхийг хамгаалах асуудлуудыг анхаарах шаардлагатай.

Дээрх жишээнүүдээс үзэхэд хиймэл оюун ухаан нь гэмт хэрэг тэмцэх ажилд дэмжлэг үзүүлэн дэлхий даяар өргөн ашиглагдаж, үр дүнтэй болох нь нотлогдож байна. Хиймэл оюун ухаан нь өгөгдлийн шинжилгээ, урьдчилсан таамаглал, бодит цагийн хяналт зэрэг олон арга замаар хууль сахиулах байгууллагуудад дэмжлэг үзүүлдэг. Гэсэн хэдий ч технологийг ашиглахдаа ёс зүй, хувийн нууц, хүний эрхийг хамгаалах асуудлыг анхаарч, хариуцлагатай хэрэгжүүлэх нь чухал юм.

ДҮГНЭЛТ:

Хиймэл оюун ухааныг хөдөлмөрийн бүтээмж болон үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах, хүний танин мэдэхүйн чадавхыг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийг бий болгох чиглэлд илүү хөгжүүлэн ашиглаж байгаагаас үзэхэд, өдгөө хиймэл оюун ухаан оролцоогүй, хүрээгүй нийгмийн салбар байхгүй болжээ гэж дүгнэж болохоор байна. Ийнхүү тоон технологи дундаас ач холбогдол, хэрэглээний өндөр үр ашигтай, ирээдүйтэй технологи нь “Хиймэл оюун ухаан (AI)” гэж дүгнэж байна.

⁷ <https://www.bbc.com/news/technology-39687605>

*Цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд
хиймэл оюун ухаан ашиглаж нь*

Дэлхийн зарим улс оронд хиймэл оюун ухаан хөгжүүлэх үндэсний стратеги, хөтөлбөр боловсруулан энэхүү харилцааг зохицуулах эрх зүйн актыг батлан мөрдөж эхэлсэн байх бөгөөд олон улсад хиймэл оюун ухааны шийдлийг шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах үйл ажиллагаанд амжилттай ашиглаж эхэлсэн нь гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг шинэ түвшинд гаргасан төдийгүй үйл ажиллагааны онцлогт тохируулан хөгжүүлснээр мэдээлэл боловсруулах, шинжлэх, урьдчилан таамаглах, сэргийлэх зэрэг шинэ боломжуудыг нээжээ.

Бид энэхүү судалгааны ажлаар хиймэл оюун ухааныг цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд ашиглах боломж, үр дагавар, тэр дундаа гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан таамаглах, мөрдөн шалгах ажиллагаанд хиймэл оюун ухааныг ашиглаж буй өнөөгийн байдал, чиг хандлага, арга хэрэгсэл зэргийг тоймлон гаргахыг оролдлоо.

Манай улсын тухайд хиймэл оюун ухаан хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж үндэсний стратеги, хөтөлбөр боловсруулан зорилго, зорилтоо үе шат нэг бүрээр тодорхойлохын зэрэгцээ хиймэл оюун ухаан ашиглахтай холбоотойгоор эрх зүйн акт шинээр батлан гаргах, зарим эрх зүйн актад нэмэлт өөрчлөлт оруулах зэргээр идэвх санаачилгатай ажиллаж зарим нэг үр дүнд хүрч байна. Тухайлбал, цахим засаг хөтөлбөрийг дурдаж болно.

Харин шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын үндсэн чиг үүргийн нэг болох гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллагаанд хиймэл оюун ухаан ашиглах талаар багагүй ярьж эхэлсэн ч энэ талаарх ажил, үйлчилгээ судалгаа, туршилтын шатанд буюу эхлэлийн төдий байна.

Ашигласан материал:

1. Монгол Улсын Үндсэн хууль//Төрийн мэдээлэл.Уб.,1992.№01,
2. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Уб., 2020. №52,
3. Тайван. С. Үндэстэн дамнасан аюул заналхийллийн эсрэг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб., 2025,
4. <https://www.bbc.com/news/uk-51237665>,

5. <https://www.nytimes.com/2018/06/29/technology/facial-recognition-annapolis-shooting.html>,
6. <https://www.govtech.com/public-safety/Predictive-Policing-in-Santa-Cruz-Helps-Reduce-Crime.html>,
7. <https://www.theguardian.com/technology/2016/feb/03/predictive-policing-algorithm-software-predicts-crime>,
8. <https://www.pymnts.com/news/security-and-risk/2018/ai-machine-learning-atm-fraud-detection/>,
9. <https://techcrunch.com/2017/04/06/ic-realtime-uses-ai-to-make-surveillance-cameras-smarter/>,
10. <https://www.theguardian.com/uk/2011/aug/10/police-facial-recognition-software-rioters>,
11. <https://www.reuters.com/article/us-usa-trafficking-ai-idUSKCN1LD0FH>,
12. <https://www2.deloitte.com/uk/en/pages/financial-services/articles/ai-and-fight-against-financial-crime.html>,
13. <https://www.sciencedaily.com/releases/2018/08/180830102047.htm>,
14. <https://www.bbc.com/news/technology-39687605>,
15. <https://www.nationalgeographic.com/animals/article/ai-artificial-intelligence-helps-fight-poaching>.



П.ДЭЛГЭРМАА

*БХЭШХ-ийн Бодлогын дүн шинжилгээний төвийн
эрдэм шинжилгээний ахлах ажилтан, магистр*

АВЛИГЫН ЭСРЭГ СЭТГЭЛ ЗҮЙН ДАРХЛАА БҮРДҮҮЛЭХ АСУУДАЛД

On the issues of forming psychological immunity against corruption

Хураангуй

Энэхүү нийтлэлд Монгол улс дахь авлигатай холбоотой нөхцөл байдлыг авч үзсэн бөгөөд авлигын зан үйлийг сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс судлахыг оролдсон. Сэтгэл зүйн шинж чанарууд нь хувь хүний ёс суртахууны шинж чанарыг төлөвшүүлэхэд оролцож, түүний зан үйлийн гол сэдлийг тодорхойлдог. Хувь хүний авлигын зан үйлийн ёс суртахууны болон сэтгэл зүйн талыг судалсны дараа түүний нийгэмд харш зан үйлд нөлөөлж буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлон, иргэд олон нийтийн авлигын эсрэг боловсролыг дээшлүүлж, ашиг сонирхлын зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Түлхүүр үгс: авлигын зан үйл, хэрэгцээ, сонирхол, сэдэл төрүүлэх хүчин зүйл, иргэний нийгэм, ил тод байдал, тогтвортой хөгжил.

Abstract

This article examines the situation related to corruption in Mongolia and attempts to study corrupt behavior from the perspective of psychological science.

Psychological characteristics are involved in the formation of the moral character of an individual and determine the main motives for his behavior. After studying the moral and psychological aspects of an individual's corrupt behavior, it is possible to identify the causes and conditions influencing his antisocial behavior, improve public anti-corruption education, and prevent conflicts of interest and corruption.

Keywords: corrupt behavior, needs, interests, motivating factors, civil society, transparency, sustainable development.

Удиртгал

Авлига нь төр, нийгмийн хөгжилд саад учруулж буй нийгэм, эдийн засгийн хамгийн хурц асуудлуудын нэг хэвээр байна. Улс төрийн тогтолцооны өөрчлөлт, эдийн засгийн шинэчлэл, даяаршлын нөхцөлд авлигын үйл ажиллагаа нь түүнийг судлах, даван туулах цогц арга барилыг шаарддаг шинэ хэлбэр, арга барилтай болж байна.

Монгол улсад авлигатай тэмцэх өнөөгийн тулгамдсан асуудлыг хэд хэдэн үндсэн чиглэлээр авч үзэж болно. Нэгдүгээрт, авлигатай тэмцэх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин сүүлийн жилүүдэд нэлээд бэхэжсэн ч хэрэгжилтийн асуудал, хууль тогтоомжоор тогтоосон хэм хэмжээ, бодит практик хоорондын зөрүүтэй тулгарч байна. Хоёрдугаарт, авлига төрийн удирдлага, бизнесийн бүхий л салбарт нэвтэрч, улмаар тэгш бус байдлыг бий болгож, иргэдийн төрийн байгууллагад итгэх итгэл буурч байна. Гуравдугаарт, авлига нь улс орны эдийн засгийн хөгжилд шууд нөлөөлж, бизнесийн эрсдэлийг нэмэгдүүлж, төрийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэхэд саад учруулж байна. Дөрөвдүгээрт, авлигын зан үйл нь хувь хүний хууль зүйн хариуцлагын ухамсрыг үгүй хийж, ёс суртахууны доройтолд оруулж байна.

Үндсэн хэсэг

“Авлига гэдэг нь авлигын эсрэг хуульд заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг ойлгоно” хэмээн Авлигын эсрэг хуулийн 3.1.1-д заасан байна.¹

¹ Авлигын эсрэг хууль. 2006

Авлига нь хууль дээдлэх зарчмыг зөрчиж, төрийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэлийг алдагдуулж, эдийн засгийн тогтолцоог тогтворгүй болгож, нийгмийн хөгжлийг бүхэлд нь саатуулдаг байна.


Дэлхий дахинд авлигын түвшин түгшүүртэй өндөр хэвээр байгааг мөн түүнийг бууруулах хүчин чармайлт суларч байгааг Авлигын Төсөөллийн Индекс /АТИ/ 2024 нь харуулсан байна. Тус судалгаагаар нийт улс орнуудын гуравны хоёр нь 50-иас доош оноо авсан нь дэлхий даяар авлигын түвшин ноцтой байгааг илчилж буй юм.²

Авлигын индексийг хэмжихдээ улсын төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж байгаа эсэх, төрийн нийтийн албан хаагч албан тушаалаа урвуулан ашиглаж байгаа эсэх, төр засаг нь авлигын эсрэг үр дүнтэй тэмцэж, шударга байдлыг төрийн салбарт хэрэгжүүлж байгаа эсэх, авлигын хэрэгт холбогдсон төрийн албан тушаалтанд хариуцлага тооцож байгаа эсэх, авлигыг мэдээлсэн шүгэл үлээгч, сэтгүүлч нарыг хамгаалсан хууль, эрх зүйн орчин гэх мэтчилэн асуудлыг хамааруулдаг аж.

Монгол улсын хувьд “Транспэрэнси Интэрнэшнл Монгол” ТББ-аас “Авлигын төсөөллийн индекс 2024”-ийн онцлох үзүүлэлтийн талаар сүүлийн гурван жил дараалан үнэлэгдсэн 33 оноогоо дахин авч 180 улсаас 114 дүгээр байрт жагслаа. Манай улсыг үнэлдэг 8 байгууллагын нэг болох Ардчиллын олон талт байдлыг үнэлдэг Varieties of Democracy байгууллагаас манай улсад 2024 онд түүхэндээ байгаагүй хамгийн муу үнэлгээ өглөө” хэмээн мэдээлсэн.

Авлигын төсөөллийн индексээр Монгол Улсын оноо 2018 оноос хойш огт ахисангүй

— Авлигын төсөөллийн индексийн оноо, 100-аас



² <https://www.transparency.org/en/cpi/2024>

Олон улсын байгууллагаас гаргадаг индексээрээ Монгол улс дараалан ижил үнэлгээ авч түвшин ахихгүй байгаа нь авлигатай тэмцэх ажил урагшлахгүй байгаа төдийгүй шинээр баталсан Авлигатай тэмцэх хөтөлбөрийг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байгаа юм.

Төр засаг авлигыг бууруулах, шударга ёсыг бэхжүүлэх зорилгоор дараах бодлогын баримт бичгүүдэд тодорхой зорилт, арга хэмжээг тусгасан байна. Тухайлбал “Алсын хараа-2050” болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023–2030)— авлигатай тэмцэхийг нийгмийн үндсэн зорилтын нэг гэж тодорхойлсон байна. Гол агуулга нь:

- Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох,
- Авлигаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх,
- Иргэд, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх,
- Авлигын эсрэг боловсрол, соён гэгээрэл, шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх,
- Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

2021–2050 он хүртэлх хугацаанд авлигыг таслан зогсоох, шударга нийгмийг бүрэн төлөвшүүлэх зорилтыг шат дараатайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.³

Монгол улсад авлигын эсрэг хууль тогтоомж, стратеги, хөтөлбөр батлагдсан ч асуудал хурцаар тавигдсан хэвээр л байна. Энэ нь одоо байгаа хяналтын механизмын үр дүн хангалтгүй, ил тод, хариуцлага багатай, авлигын олон үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байгаагаар ихээхэн холбоотой.

Монгол улсад авлигын тархалтын шалтгаанууд:

Авлига бол олон шалтгаантай, нарийн төвөгтэй, олон талт үзэгдэл юм. Түүний тархалтад нөлөөлж буй гол хүчин зүйлсийг авч үзье.

1. Ил тод, нээлттэй байдал дутмаг. Төрийн байгууллага, бүтцэд ил тод байдал ихэвчлэн дутагдаж байна. Шийдвэр гаргах ил тод бус механизм нь хүчирхийлэлд өртөх боломжийг бий болгодог.
2. Хуулийн тогтолцоо сул. Шүүхийн хараат бус байдал хангалтгүй байгаа нөхцөлд авлигатай үр дүнтэй тэмцэх боломжгүй юм. Transparency International-ийн үнэлгээгээр, Монгол Улсад авлигын хэргүүдийн 76%

³ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол

нь прокуророор хэрэгсэхгүй болгогдож байна.⁴ Хууль сахиулах үйл ажиллагааны урьдчилан таамаглах боломжгүй байдал, түүнчлэн шүүх ажиллагаанд төрөөс хөндлөнгөөс оролцох тохиолдол гардаг нь хууль, шударга ёсонд итгэх итгэлийг сулруулж байна.

3. Хувийн харилцаа холбоо давамгайлах. Хүмүүс шийдвэр гаргахдаа бодитой шалгуур тавихаас илүүтэй танил тал, нутаг нэгтнээ илүүд үздэг. Энэ нь хууль бус үйлдлүүд нийтлэг болж, ердийн үзэгдэл мэтээр хүлээн зөвшөөрсөн нийгэм соёлын хэм хэмжээг бий болгодог.
4. Бага цалин, амьжиргааны түвшин. Төрийн албан хаагчдын орлогын түвшин доогуур байгаа нь тэднийг хээл хахуулийн саналд илүү өртөмтгий болгодог. Lehman Law Mongolia-ийн мэдээлснээр, бага цалин, хангалтгүй нөөц нь төрийн албан хаагчдыг авлига авахад хүргэдэг.⁵ Өндөр түвшний ядуурал, нийгмийн тэгш бус байдал нь хүмүүсийг санхүүгийн байдлаа сайжруулахын тулд авлигын схемд оролцоход түлхэц болно.
5. Өрсөлдөөн хангалтгүй. Төрийн худалдан авалт, тендерийн ил тод бус тогтолцоо нь авлигад автагдах боломжийг бүрдүүлдэг. GAN Integrity-ийн тайланд дурдсанаар, Монгол Улсад төрийн худалдан авалтын салбарт авлигын эрсдэл өндөр байна.⁶ Эрүүл өрсөлдөөн байхгүй тохиолдолд ашиг олоход чиглэсэн арга хэрэгсэл үргэлж байх болно.
6. Улс төрийн тогтворгүй байдал. Тогтворгүй байдал, эрх мэдлийн өөрчлөлт, улс төрийн хямрал зэрэг нь авлигын өсөлтөд нөлөөлдөг.
7. Үр дүнгүй сөрөг арга хэмжээ. Хэдийгээр авлигын эсрэг хууль, хөтөлбөрүүд байдаг ч хэрэгжилт нь үр дүнгүй байна. Хууль хяналтын байгууллагуудын хариу арга хэмжээ удаашралтай, зарим тохиолдолд авлигатай тэмцэх үүрэгтэй төрийн байгууллагууд өөрсдөө авлигын схемд оролцож байгаа нь энэ тэмцлийн үр дүнтэй эсэхэд эргэлзээ төрүүлдэг.
8. Системийн ерөнхий сэтгэл ханамжгүй байдал. Иргэд бүх шатанд авлига байгааг хараад төр засаг, сонгуулийн үйл явцад итгэх итгэл алдарч байгаа нь авлигатай тэмцэх олон нийтийн хяналт, иргэдийн идэвхийг бууруулж байна. Авлигатай тэмцэх ажилд олон нийтийг оролцуулахгүй

⁴ Tamir Ch., Dolgion A. Assessing Horizontal Accountability in Mongolia: Weak Judiciary Combatting Corruption Scandals. Asia Democracy Research Network Year Eight. EAI 2023

⁵ https://lehmanlaw.mn/blog/mongolia-to-take-action-to-address-corruption/?utm_source=chatgpt.com

⁶ <https://www.ganintegrity.com/country-profiles/mongolia/>

бол асуудал улам хурцадна.

9. Гадны хүчин зүйлийн нөлөөлөл. Даяаршил, олон улсын харилцаа тухайлбал, гадаадын банк, оффшор компаниар дамжуулан мөнгө угаах боломжтой байгаа нь авлигатай тэмцэхэд нэмэлт бэрхшээл үүсгэж байна.
10. Технологийн хөгжил. Нэг талаас, шинэ технологи нь үйл явцын ил тод байдлыг сайжруулж, авлигын түвшинг бууруулах боломжтой (жишээлбэл, цахим тендер шалгаруулалт, нээлттэй мэдээллийн систем). Нөгөөтгээгүүр, кибер гэмт хэрэг, санхүүгийн бусад нарийн төвөгтэй заль мэх гэх мэт өндөр технологийн авлигын схемүүд бас түгээмэл болж, тэдэнтэй тэмцэх шинэ арга барилыг шаардаж байна.

Монгол Улсад авлигын тархалт нь зөвхөн хууль эрх зүйн сул тогтолцооны үр дүн биш бөгөөд сэтгэл зүйн түвшинд гүн суурьтай, нийгмийн ухамсар, соёлын үнэт зүйлсийн хандлагатай нягт уялдаатай байна. Ёс суртахууны доройтол туйлдаа тулсны нэгэн тод илрэл нь Монгол Улсын салбар бүрд үүрлэсэн хулгай, авлигал. Ёс суртахуунд багтаан ойлгодог хувь хүний ёс зүй, гэр бүлийн ёс зүй, нийгмийн ёс зүй бүгд доройтон унасан. Монгол хүний мөн чанар, хүний мөс, жудаг, нэр төрөө хичээх ёс, итгэлийг даах хүнлэг сэтгэл, шударга байдал, хариуцлага гэж алга. Бид өнөөдөр улсаараа шахуу зөвхөн мөнгөний төлөө үл ойлголцол, соёлгүй байдал, шударга бус зүйлсийг хийсээр байна.

Авлига нь нийгмийн бүхий л хүрээнд сөрөг нөлөө үзүүлдэг, хууль ёсны үндсийг үгүй хийдэг, сэтгэл зүйн гүн гүнзгий нөхцөлтэй сөрөг үзэгдэл юм. Түүнтэй үр дүнтэй тэмцэхийн тулд зөвхөн хууль зүйн төдийгүй хувь хүний сэтгэл зүй, ёс суртахууны хандлага, нийгмийн үнэт зүйлсийн талаарх ойлголтыг авч үзэх нь зүйтэй.

Авлига (эсвэл хээл хахууль) авах сэтгэл зүй нь олон хүчин зүйлсийн нийлбэр дүнд бий болдог бөгөөд хувь хүний зан төлөв, соёлын орчин, ёс суртахууны үнэлэмж, эдийн засгийн нөхцөл байдал зэрэгтэй шууд холбоотой байдаг.

Тиймээс хувь хүний авлигад автсан зан үйлийг тайлбарлахад сэтгэл судлалын шинжлэх ухаанд энэ үзэгдлийн илрэх хөдөлгөгч хүч, түлхэц юу болохыг олж мэдэх нь хамгийн чухал асуудал юм. Миний бодлоор авлига хээл

хахуулийн гол хөдөлгөгч хүч нь “хялбар мөнгө”, “шунал”, “хурдан баяжих”, өөрөөр хэлбэл хэрэгцээгээ түргэн шуурхай хангах сэдэл юм.

Авлига нь зөвхөн үр дагаврын хувьд хууль эрх зүй, эдийн засгийн асуудал боловч эхэндээ цэвэр сэтгэл зүйн шинж чанартай байдаг.⁷ Авлигын сэтгэл зүйн бүрэлдэхүүн хэсгүүдийн ач холбогдол нь эхлээд “толгойд”, хүмүүсийн ухамсарт бүрэлдэж, улмаар зан үйлийг тодорхойлж, хууль бус үйлдлээр илэрдэг.

Авлигын сэтгэл зүйн шалтгаан:

1. Ашиг хонжооны хандлага давамгайлах

Хувь хүн богино хугацааны ашиг хонжоог нэгдүгээрт тавьж, ёс суртахууны эргэлзээг өөрт ашигтай байдлаар зөвтгөдөг. Энэ сэтгэлгээ нь “өнөөдөр ашиг олж чадвал маргаашийн үр дагавар хамаагүй” гэх урамшлын хуурамч хандлагыг бий болгодог. Сэтгэл зүйн утгаараа энэ нь “Өөртөө төвлөрсөн хандлага” (self-interest bias) болон богино хугацааны сэтгэлгээтэй холбоотой. Хувь хүн ёс суртахууны үнэлгээг хойш тавьж, шууд хүртэх боломжтой ашгийн төлөө шийдвэр гаргах нь рациональ сонголтын онолын хүрээнд тайлбарлагддаг.

2. Эрсдэл бага, баригдах магадлал сул гэсэн төсөөлөл

Төрийн хяналт сул, хариуцлагын тогтолцоо бүрхэг үед хувь хүмүүс “баригдахгүй” гэсэн буруу ойлголтоор удирдуулдаг. Энэ нь авлигыг “аюулгүй” үйлдэл мэтээр дүгнэхэд хүргэдэг.⁸ Хүлээлтийн онолын дагуу хүмүүс аливаа үйлдлийн үр дүнгийн магадлалаар шийдвэр гаргадаг. Эрсдэл багатай, шийтгэл хүлээхгүй гэх төсөөлөл нь авлигыг өдөөх нэг шалтгаан болдог. Монгол Улсын авлигын талаарх олон нийтийн судалгаанд оролцогчдын 48% нь “авлигын хэргүүд шийдвэрлэгддэггүй, хариуцлага тооцдоггүй”⁹ хэмээн мэдэгдсэн нь хариуцлагын механизмд итгэх итгэл сул байгааг харуулж байгаа юм.

3. Нийгмийн хүлээлт ба хандлага

Авлигыг “амьдралын хэв маяг”, “зайлшгүй гарц” гэж хүлээн зөвшөөрдөг нийгмийн сэтгэл зүйн орчин нь хувь хүний ёс суртахууны хариуцлагыг

⁷ Решетников, М.М. Психология коррупции: утопия и антиутопия. СПб. 2008. 128с

⁸ Sullivan, J.L., et al. The Psychology of Corruption: Explaining Individual Attitudes Toward Corruption. 2006

⁹ Public Perception Survey on Corruption in Mongolia. UNDP Mongolia. 2021

бүдгэрүүлдэг. Өөрөөр хэлбэл авлига нь нийгэмд “хэвийн” үзэгдэл мэт түгээмэл болсон бол хувь хүн ёс суртахууны шүүлтээр бус, нийгмийн хүлээлтээр шийдвэр гаргах магадлал өндөр болдог. Үүнийг Америкийн сэтгэл судлаач Алберт Бандурагийн “хүмүүс бусдын зан үйлийг ажиглаж, түүнээс суралцдаг” гэсэн нийгмийн суралцах онолын дагуу тайлбарлаж болно. Хүмүүсийн авлигыг зөвшөөрөх эсвэл эсэргүүцэх хандлага нь тухайн нийгмийн “соёлын норм”-оос ихээхэн хамаардаг¹⁰ байна.

4. Боловсролын сул суурь ба ёс суртахууны ухамсар дутмаг

Ёс суртахууны хөгжлийн онол нь ёс зүйн шийдвэр гаргалт нь боловсрол, орчин, нийгмийн нөлөөгөөр хөгждөг болохыг нотолдог. Ёс суртахууны боловсрол нь системтэй биш байснаас шалтгаалж, ёс зүй, шударга ёс, хариуцлага зэрэг үнэт зүйлс багаас нь төлөвшөөгүй хүний ёс суртахууны суурьгүй боловсрол нь авлигыг зөвтгөх сэтгэл зүйд хүргэдэг.¹¹

5. Дотоод зөвтгөл ба сэтгэл зүйн хамгаалалт

Судлаач А.Төгсбилэг “Авлигыг зөвтгөх сэтгэл зүйн механизм” нь авлигыг улам хэвийн үзэгдэл мэт хүлээн зөвшөөрөх хандлагад хүргэдэг¹² болохыг онцолсон.

“Цалин багатай учраас би авах эрхтэй”, “тогтолцоо нь өөрөө шударга биш” гэх мэт дотоод зөвтгөл нь ёс суртахууны хариуцлагыг үл хэрэгсэх, өөрийгөө зөвтгөх механизм болдог. “Бүгд л авлига авч, өгч байна” гэх нийтлэг үзэл нь хувь хүнийг ёс суртахууны шүүлтээс ангид байлгаж, авлигыг ердийн зүйл мэт хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг. Өөрөөр хэлбэл сэтгэл зүйн хамгаалалтын механизм нь хувь хүний ёс суртахууны зөрчлийг өөрт ашигтайгаар зөвтгөхөд хүргэдэг. Үүнийг “cognitive dissonance” буюу сэтгэл зүйн зөрчилдөөний онолоор тайлбарладаг.¹³

Дээрх авлигын зан үйлийг бий болгодог сэтгэл зүйн шалтгаанууд манай улсын ард иргэдийн ухамсарт нөлөөлж, “Би-хандлага” давамгайлсан, ёс

¹⁰ Banuri, S., & Eckel, C. Experiments in culture and corruption. Behavioural Foundations of Public Policy. Princeton University Press. 2012

¹¹ Akdemir, T., & Yesilyurt, S. The role of ethics education in the fight against corruption. Global Journal of Transformative Education. 2023

¹² А.Төгсбилэг “Авлигын сэтгэл зүйн нөхцөл, хамгаалалтын механизм.” Сэтгэл судлалын эрдэм шинжилгээний бичиг. №15.2020

¹³ Festinger, L. A Theory of Cognitive Dissonance. Stanford University Press. 1957

суртахуунгүй, шударга бус үйлдлүүд газар авч, олон нийтийн санаа бодол авлигад дасах үзэгдэл ихэссээр байна.

Сүүлийн жилүүдэд оюутан залуусын дунд авлигын талаарх ойлголт, хүлээлт¹⁴, үнэт зүйлсийн судалгаа¹⁵ эрчимтэй явагдаж байна. Судалгаагаар тэд “авлигыг ихэнхдээ амьдралын арга, харилцааны “зохицуулалт” гэж харж байна” гэж дүгнэснийг ч бид анхаарах ёстой.

Авлигатай тэмцэхэд хууль эрх зүй, байгууллагын арга хэмжээнээс гадна ёс суртахуун, сэтгэл зүйн арга хэмжээ чухал нөлөөтэй. Учир нь авлигын уг шалтгаан зөвхөн системийн сул тал биш, харин хувь хүний үнэт зүйл, ухамсар, сэтгэл зүйн орчинтой холбоотой байдаг. Мөн авлигын үзэгдэл нь ёс суртахууны доройтлыг гэрчилж байдаг тул хүний өөрийн үйл хэргийн ёс суртахууны ухамсартай салшгүй холбоотой юм.

Авлигын нийгэм, сэтгэл зүйн үндсийг тодорхойлж, түүнийг арилгах арга замыг эрэлхийлэх нь түүний тархалтыг эсэргүүцэх үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Авлигатай тэмцэхэд ёс суртахуун, сэтгэл зүйн арга хэмжээг хэрэгжүүлэх нь олон улсын хэмжээнд үр дүнтэй туршлагаар батлагдсан байдаг.

Гадаад орнуудын авлигын эсрэг ёс суртахуун, сэтгэл зүйн арга хэмжээний жишээ ба үр дүнгийн хүснэгт

Улс	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
Сингапур	Албан хаагчдын ёс зүйн тогтолцоо, тогтмол сургалт, хатуу хяналт	Авлигын индексээр дэлхийн эхний 5 байранд тогтмол ордог
Гүрж	Төрийн албаны цогц шинэчлэл, ёс суртахууны сургалт, үйлчилгээний ил тод байдал	Авлигыг зөвтгөх хандлага 60%-аас 12% болж буурсан
Эстони	Цахим засаглал, иргэдийн мэдээллийн аюулгүй байдал, сэтгэл зүйн дэмжлэг	Авлигын индексээр дэлхийд 13-р байр (2024)
Швед	Ёс зүйн боловсролыг бага наснаас олгох, албан хаагчидтай нээлттэй харилцаа	Иргэдийн төрд итгэх итгэл өндөр байдаг
Норвег	Байгууллагын ил тод байдал, сэтгэл зүйн урамшуулал	Нийгмийн итгэлцэл өндөр, авлигын түвшин маш бага

¹⁴ Китова, Д.В. Молодежь и коррупция: психолого-социальный анализ. 2019

¹⁵ С.Түвшинзаяа. Монголчуудын үндэсний үнэт зүйлийн судалгааны тайлан. СЭЗДС. 2015

Мөн олон улсад авлигын эсрэг ёс суртахуун, сэтгэл зүйн арга хэмжээний хүрээнд ашигладаг үр дүнтэй аргууд байна. Үүнд:

- Ёс зүйн боловсрол ба үнэт зүйлсийн төлөвшүүлэлт

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC) нь их, дээд сургуулиудад зориулсан “Integrity & Ethics” сургалтын модулиудыг боловсруулсан. Эдгээр нь ёс зүйн суурь ойлголт, нийгмийн хариуцлага, ёс зүйн удирдлага, мэргэжлийн ёс зүй зэрэг сэдвийг хамардаг. Модулиудыг улс орнуудын соёл, нөхцөл байдалд тохируулан хэрэглэх боломжтой бөгөөд боловсролын байгууллагууд болон төрийн албан хаагчдад зориулсан сургалтад өргөн ашигладаг.¹⁶

- Ёс зүйн удирдлага ба байгууллагын соёл

Олон улсын стандарт болох ISO 37001 нь авлигын эсрэг удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд чиглэсэн бөгөөд байгууллагын дотоод соёлыг ёс зүйд суурилсан, ил тод байдлыг дэмжсэн байдлаар төлөвшүүлэхийг зорьдог. Энэхүү стандарт нь авлигын эрсдэлийг тодорхойлох, хяналт тавих, ажилтнуудыг сургах зэрэг арга хэмжээг агуулдаг.¹⁷

- Сэтгэл зүйн нөлөөлөл ба зан үйлийн өөрчлөлт

OECD-ийн “Anti-Corruption Ethics and Compliance Handbook for Business” гарын авлага нь байгууллагын ёс зүйн хөтөлбөрүүдийг хэрхэн хэрэгжүүлэх талаар практик зөвлөмжүүдийг өгдөг. Энд авлигын эсрэг соёлыг төлөвшүүлэх, ажилтнуудын зан үйлийг өөрчлөх, сэтгэл зүйн нөлөөллийг ашиглах зэрэг арга хэмжээг онцолсон.¹⁸

- Иргэдийн оролцоо ба ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх

НҮБ-ын “Introduction to Anti-Corruption” онлайн сургалт нь авлигын талаарх ойлголт, түүний үр дагавар, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар иргэдэд мэдлэг олгох зорилготой. Энэхүү сургалт нь иргэдийн ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, авлигатай тэмцэхэд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлдэг.¹⁹

Монгол Улсад авлигын эсрэг ёс суртахуун, сэтгэл зүйн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд олон түвшинд, олон талт арга хэмжээг зэрэг авч

¹⁶ https://www.unodc.org/e4j/tertiary/integrity-ethics.html?utm_source=chatgpt.com

¹⁷ https://en.wikipedia.org/wiki/ISO_37001?utm_source=chatgpt.com

¹⁸ https://www.oecd.org/en/publications/2013/01/anti-corruption-ethics-and-compliance-handbook-for-business_8a954f49.html?utm_source=chatgpt.com

¹⁹ https://www.unsdglearn.org/courses/introduction-to-anti-corruption/?utm_source=chatgpt.com

үзэх шаардлагатай. Байгууллага, иргэн бүрийн оролцоог хамарсан дараах арга замуудыг санал болгож байна.

1. Ёс суртахууны боловсролыг багаас нь олгох

- Сургуулийн хөтөлбөрт шударга ёс, хариуцлага, үнэнч байдал, нийтийн эрх ашгийг дээдлэх сэтгэлгээг суулгах хичээл, сургалт, клубийн үйл ажиллагааг явуулах.

- Сэтгэл хөдлөл, шийдвэр гаргалтад нөлөөлдөг “moral emotions” (жишээ: ичгүүр, урам зориг, өрөвдөх сэтгэл)-ийг хөгжүүлэх хичээл, сургалтыг түлхүү оруулах. Энэ нь авлигын талаар “ухааралтай хандлага” төлөвшүүлнэ.

- Зан төлөв төлөвшүүлэх хөтөлбөр боловсруулж, багш, эцэг эхчүүдэд зориулсан сургалт зохион байгуулах.

-Шударга байдлыг эрхэмлэдэг залуу манлайлагчдыг дэмжих, тэднийг олон нийтийн өмнө хэвлэл мэдээллээр таниулж, эерэг нөлөө үзүүлэх байдлаар идэвхтэй ажиллуулах

2. Авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлэх, нийгмийн хандлагыг өөрчлөх кампанит ажил

-“Авлигыг мэдээлэх нь зориг, эх оронч байдал” гэдгийг ойлгуулах “Авлигад үгүй гэж хэлье” уриан дор тогтмол олон нийтийн ухуулах ажил зохион байгуулах (Залуус, бизнес эрхлэгчид, төрийн байгууллагад тус тусад нь чиглэсэн байдлаар).

-Авлигын эсрэг соёлын наадам, постер/эсээ/видео уралдаан өрнүүлэх (олон нийтийг хамарсан, урамшуулалтай хэлбэрээр).

-“Хүмүүс шударга байдлыг эрхэмлэдэг” гэсэн мессежийг олон нийтэд хүргэснээр нийтийн хандлагыг өөрчлөх сэтгэл зүйн нөлөөтэй. (Жишээ: “Ихэнх иргэд шударга нийгмийг дэмждэг” гэх мэт эерэг жишээг нийтэд түгээх)

-Төрийн үйлчилгээний орчинд шударга байдлыг сануулах, эерэг сэтгэл зүйн орчин бүрдүүлэх (жишээ: “Авлигагүй үйлчлүүлээрэй” гэсэн мэдэгдэл бүхий бичиглэл, дүрс бүхий орчин).

- “Moral reminder” буюу ёс суртахууны сануулга тогтмол өгөх — иргэд, ажилтнууд аливаа шийдвэр гаргахын өмнө ёс зүйн талаарх богино мэдэгдэл унших буюу бичгээр батлах жишиг тогтоох.

3. Урамшуулал, шийтгэлийн хос механизм

- Шагнал, урамшуулал нь зөвхөн материаллаг бус, сэтгэл хөдлөлд чиглэсэн байх хэрэгтэй. Жишээ нь, “Олон нийтийн өмнө талархал илэрхийлэх”, “Үндэсний бахархал” зэрэг нөлөө бүхий, эерэг сэтгэл хөдлөл үүсгэх урамшуулал олгодог байх

- Ёс суртахууны хариуцлагын тогтолцоонд өөрийн үйлдлийн үр дагаварт хариуцлага хүлээх ухамсрыг төлөвшүүлэх сургалт, зөвлөгөөг байгууллагуудад тогтмол явуулах

- Ёс зүйтэй ажилтныг шагнах үнэлгээний тогтолцоо бий болгох (жишээ: “Шударга албан хаагч” зэрэглэлийн цол, нэмэлт цалин).

- Ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд сахилгын хариуцлага (шалгалт, ажлаас чөлөөлөх, олон нийтэд мэдээлэх) тодорхой байх.

- Авлигын дарамтад орсон иргэд, төрийн албан хаагчдад зориулсан зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ (нууцлалтай сэтгэл зүйч, зөвлөгч).

4. Бүлгийн нөлөөлөл, “хамт олны ухамсар”-ыг дэмжих

Байгууллагын хамт олноороо хамтарсан ёс зүйн кейс судалгаа, шийдвэрийн симуляци хийх нь хамтын ухамсрыг бэхжүүлдэг. Авлигын эсрэг дуу хоолойгоо илэрхийлэхэд сэтгэл зүйн аюулгүй, айдасгүй орчныг бүрдүүлэхэд анхаарах

5. Сэтгэл зүйн дасгал, сургалт

- Сэтгэл зүйн хариуцлага, итгэлцэл, ичгүүрийн мэдрэмжийг нэмэгдүүлэх талаарх сургалт, нөлөөллийн контент хөгжүүлэх.

- Хувь хүний ёс суртахууны мэдрэмжийг сэргээх, уруу таталтыг даван туулах сэтгэл зүйн тэсвэр тэвчээрийг төлөвшүүлэх сургалт

Сэтгэл зүйн судалгаа, оношилгоо

- Авлигад автах зан төлөв, сэтгэл зүйн үндсийн талаар судалгаа хийх

- Иргэдийн шударга ёсонд итгэх итгэлийн түвшин тогтоох судалгааг тогтмол хийх

Эдгээр арга хэмжээнүүд нь хувь хүний ухамсар, сэтгэл хөдлөл, зан үйлийг олон талаас нь дэмжих сэтгэл зүйн хандлагад тулгуурласан бөгөөд авлигатай тэмцэх урт хугацааны, тогтвортой, бүтээлч үндэс суурийг бүрдүүлнэ. Мөн ёс

суртахуун, сэтгэл зүйн арга хэмжээг хэрэгжүүлснээр хүмүүсийн ухамсар, хандлага өөрчлөгдөж, авлигын эсрэг сэтгэл зүйн дархлаатай, ёс суртахуунтай иргэний нийгэм бүрэлдэх болно. Үүнд:

Ёс суртахууны төлөвшил: Ёс суртахууны үнэт зүйлсэд суурилсан хүмүүжил нь хүнийг аливаа ёс бус үйлдэлд автах магадлалыг бууруулдаг.

- Хувийн хариуцлагын ухамсар: Нийгмийн өмнө хүлээх ёс суртахуун болон хууль зүйн хариуцлагыг ухамсарласан хүн авлигад татагдах магадлал бага байдаг.
- Бие даасан, шүүмжлэлтэй сэтгэлгээ: Сэтгэл зүйн хувьд бие даасан, олон ургалч үзэлтэй, ёс суртахууны шүүлт хийх чадвартай хүмүүс авлигын дарамтад “үгүй” гэж хэлэх илүү чадвартай болдог.
- Эерэг нийгмийн орчин ба авлигыг үл тэвчих хандлага: Хэрэв олон нийт авлигыг үл тэвчих хандлагатай бол авлигачдын сэтгэл зүйн зөвтгөлийг багасгах нийгмийн хориг үүснэ.

ДҮГНЭЛТ

Орчин үеийн авлига нь нийгмийн бүх байгууллагад нэвтэрч, түүний хил хязгаарыг байнга тэлж, улсын тогтвортой хөгжилд ноцтой аюул учруулж байна. Манай улсын хууль тогтоох салбарт хийгдэж буй шинэчлэл, эрүүгийн хариуцлагыг чангатгах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр авлигын эсрэг суртал ухуулга зэрэг нь энэ салбарт дорвитой өөрчлөлт авчрахгүй байсаар байна.

Авлига бол хууль зүйн төдийгүй сэтгэл зүйн, ёс суртахууны хямралын илрэл юм. Түүнтэй тэмцэхийн тулд хүний дотоод ухамсар, сэтгэл зүйн тогтвортой байдлыг дэмжих нь нэн чухал. Авлигыг **сэтгэл зүйн түвшинд даван туулахуйц ухамсарт хандлага** төлөвшүүлэх нь хамгийн урт хугацаанд, тогтвортой үр дүнд хүргэх болно. Энэ нь боловсрол, соёл, зан үйл, ёс суртахуун, итгэл үнэмшил дээр тулгуурладаг тул төр, боловсролын байгууллага, иргэний нийгмийн хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай. Хүүхэд залуучуудад авлигын хор уршгийг ойлгуулах, ёс суртахуунд суурилсан боловсрол олгох нь “Авлигын эсрэг сэтгэл зүйн дархлаа”-г хөгжүүлэх үндэс болно.

Ашигласан ном, эх сурвалж:

1. Авлигын эсрэг хууль. 2006
2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол
3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023–2030). Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дугаар тогтоол
4. С.Түвшинзаяа. Монголчуудын үндэсний үнэт зүйлийн судалгааны тайлан. СЭЗДС. 2015
5. Гаврина. Е.А. Психология коррупции: Теоретические и прикладные аспекты. 2018.
6. Китова. Д.В. Молодежь и коррупция: психолого-социальный анализ. 2019.
7. Сулдина. А.Н. Этическая и психологическая оценка коррупционного поведения. Вестник ПНИПУ. 2022.
8. Решетников. М.М. Психология коррупции: утопия и антиутопия. СПб. 2008.128с
9. Public Perception Survey on Corruption in Mongolia. UNDP Mongolia. 2021
10. Banuri, S., & Eckel, C. Experiments in culture and corruption. Behavioural Foundations of Public Policy. Princeton University Press. 2012
11. Akdemir, T., & Yesilyurt, S. The role of ethics education in the fight against corruption. Global Journal of Transformative Education. 2023
12. Sullivan. J.L., et al. The Psychology of Corruption: Explaining Individual Attitudes Toward Corruption. 2006.
13. Tamir Ch., Dolgion A. Assessing Horizontal Accountability in Mongolia: Weak Judiciary Combatting Corruption Scandals. Asia Democracy Research Network Year Eight. EAI 2023
14. OECD. Integrity for Good Governance in Eastern Europe and Central Asia. 2018
15. Jon S.T. Quah. Singapore’s Success in Combating Corruption: Lessons for

- Policy Makers. Asian Education and Development Studies, 2017.Vol. 6 No. 3, p.263–274
16. Transparency International. Corruption Perceptions Index 2024.
<https://www.transparency.org/en/cpi/2024>
17. https://www.unsdglearn.org/courses/introduction-to-anti-corruption/?utm_source=chatgpt.com
18. https://www.unodc.org/e4j/tertiary/integrity-ethics.html?utm_source=chatgpt.com
19. https://www.oecd.org/en/publications/2013/01/anti-corruption-ethics-and-compliance-handbook-for-business_8a954f49.html?utm_source=chatgpt.com
20. https://en.wikipedia.org/wiki/ISO_37001?utm_source=chatgpt.com
21. https://lehmanlaw.mn/blog/mongolia-to-take-action-to-address-corruption/?utm_source=chatgpt.com
22. <https://www.ganintegrity.com/country-profiles/mongolia/>

Нэр томъёоны тайлбар:

- “Би-хандлага”- (“би төвтэй хандлага”, англиар egocentric attitude) гэдэг нь өөрийн ашиг сонирхол, хэрэгцээ, үзэл бодлыг нэн тэргүүнд тавьж, бусдын байр суурь, нийгмийн нийтлэг эрх ашгийг үл ойшоох хандлага юм.
- **UNODC – Нэгдсэн үндэсний байгууллагын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газар** (*United Nations Office on Drugs and Crime*)
- ISO 37001- Олон улсын стандартын байгууллагаас гаргасан Авлигын эсрэг удирдлагын тогтолцооны олон улсын стандарт
- OECD- Францад байрлалтай Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (*Organisation for Economic Co-operation and Development*)



Т.МӨНХЖАРГАЛ

*Монголбанк, СМА,
Үйл ажиллагааны хэлтэс, шинжээч*

АВЛИГЫГ БУУРУУЛАХ ЗОРИЛГООР БЭЛЭН МӨНГӨНИЙ ГҮЙЛГЭЭГ ХЯЗГААРЛАХ НЬ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Авлигын асуудал нь хөгжиж буй орнууд төдийгүй хөгжилтэй улс орнуудын гол асуудал хэвээр байсаар байна. Дэлхийн улс орнууд авлигыг бууруулахад төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлсээр байна. Эдгээр арга хэмжээний нэг нь бэлэн мөнгөний хэрэглээг зохицуулах замаар авлигыг бууруулах боломж юм. Олон улсад хийгдсэн судалгаануудын үр дүнгээр бэлэн мөнгөний хэрэглээ нь авлигатай хамааралтай гэдгийг баталсан төдийгүй бэлэн мөнгөний хэрэглээг бууруулах замаар авлигыг бууруулах бодлогыг хэрэгжүүлж байна.

Энэхүү судалгааны гол зорилго нь Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны хүрээнд эдийн засгийн гэмт хэрэг түүнчлэн авлигын гэмт хэргийг бууруулах зорилгоор бэлэн мөнгөний хэрэглээг зохицуулах бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай эсэхэд хариулах зорилгоор гадаад улс орнуудын эрх зүйн зохицуулалтын туршлага болон дата мэдээлэлд үндэслэн тоон болон чанарын судалгааг хийлээ. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн хэдийгээр статистик аргачлалаар судлаачийн хүссэн үр дүнд хүрээгүй боловч бусад үр дүнд үндэслэн Монгол Улсад бэлэн мөнгөний хэрэглээг хязгаарлах шаардлагатай гэж үзэв. Ингэхдээ бэлэн мөнгөний гүйлгээг тухайн төлбөрийн төрлөөр, салбараар, харилцагчаар, босго мөнгөн дүнг тодорхойлох зэрэг хэлбэрээр хязгаарлаж авлигыг бууруулахад нөлөөлж болохыг харуулж байна.

Corruption remains a critical issue not only in developing countries but also in developed nations. In response, governments around the world continue to implement various measures to combat corruption. One such measure is the regulation of cash usage as a means to reduce corruption.

Empirical studies conducted internationally have demonstrated a correlation between cash usage and levels of corruption. These findings support the implementation of policies aimed at reducing cash transactions as a means of combating corruption.

The primary objective of this study is to examine whether it is necessary for Mongolia to implement policies regulating cash usage as part of its anti-money laundering and counter-terrorism financing framework, with the broader aim of reducing economic and corruption-related crimes. The research is based on both quantitative and qualitative analyses, drawing on international legal frameworks and data from various countries.

Although the statistical methods employed did not fully yield the anticipated results, other findings from the study suggest that limiting the use of cash in Mongolia is indeed warranted. Specifically, the research indicates that imposing restrictions on cash transactions—based on the type of payment, industry sector, type of customer, and monetary thresholds—could contribute to reducing corruption.

Түлхүүр үг: Бэлэн мөнгөний гүйлгээ, Авлига

Keywords: Cash transactions, Corruption

УДИРТГАЛ ХЭСЭГ

Авлига гэдэг ойлголт дэлхий дахинд танигдсан цагаас хойш төдий л их хугацаа өнгөрөөгүй боловч 2000 жилийн өмнө Энэтхэгийн ерөнхий сайд Кайтиля /Kautilya/ өөрийн бичсэн *Arthashastra* гэх номдоо авлигатай ижил төстэй зүйлийн талаар бичиж байжээ. Мөн алдарт Шекспир өөрийн зохиолын гол дүрийн жүжигчинд авлига өгдөг байсан аж¹. Эдгээрээс харахад авлига гэдэг ойлголт түгэн дэлгэрэхээс өмнө авлигатай ижил агуулга бүхий үйлдэл эрт дээр үед бий болсон байна.

¹ <https://www.imf.org/external/pubs/ft/wp/wp9863.pdf>

Монгол Улсад авлигын асуудал хамгийн чухал сэдэв болсон гэхэд хилсдэхгүй. Монгол Улсын Их Хурал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцыг 2005 онд соёрхон баталсан нь авлигын эсрэг тэмцлийн хүсэл зоригийн томоохон илэрхийлэл болсон байна. Үүнээс улбаалан 2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын Их Хурал Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталж, 2006 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн даган мөрдөж эхэлжээ. Уг хуулийн дагуу Монгол Улсад анх удаа авлигатай тэмцэх тусгай байгууллага-Авлигатай тэмцэх газар байгуулагдан 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. Харин одоо цагт авлига болон түүний хор хохирол нь илүү нүдэнд харагдаж, гарт баригдахуйц болж байгаатай холбоотойгоор олон улсын судлаачид авлигын үүсэх шалтгаан нөхцөл, түүнийг бууруулах арга замын талаар судалсаар байна.

Одоог хүртэл хийгдсэн судалгаанууд нь авлигын шалтгаан, үр дагавар, түүнтэй тэмцэх арга зам гэх мэт чиглэлд хийгдсээр байна. Эдгээрээс сүүлийн үед авлигын эсрэг тэмцэх арга зам дотроос дижиталчлалтай холбон тайлбарлаж байгаа судалгаанууд элбэг байна. Гэсэн хэдий ч авлигыг бууруулахад дижитал төлбөр тооцоо нь ямар үүрэгтэй талаарх хийсэн судалгаа нь цөөн байна. Үүний нэг судалгаа болох Setor, Senyo, & Addo (2021) нар нь дижитал төлбөрийн системийн гүйлгээ нь авлигыг бууруулдаг уу ? гэх асуултад хариулахын тулд хөгжиж буй орнуудыг сонгон судалгаа хийж үзэхэд үр дүн нь дижитал гүйлгээ нь авлигыг бууруулдаг нь батлагдсан байна. Үүнтэй адилаар бэлэн мөнгөний хэрэглээг бууруулах нь авлигыг бууруулж, нийгэмд эерэг үр дүн авчрах талаар нарийн аргачлалыг бий болгосон байна. Мөн зарим судлаачид (Alaeddin et al. 2019) авлигыг бууруулахад бэлэн мөнгөгүй нийгмийн гүйцэтгэх үүргийг ойлгох зорилгоор судалгаа хийж үзэхэд энэхүү судалгааны үр дүн нь авлигыг таслан зогсооход туслах гол хүчин зүйлс бол бэлэн мөнгийг бууруулах арга мөн бөгөөд энэ талаар цаашид судлах шинэ сэдвүүдийг санал болгосон байна. Бэлэн мөнгөний хэрэглээний цаашдын хандлага нь дэлхийн хүн амын тал хувьд хүртэл буурч байгаа талаар (Khiaonarong & Humphrey, 2023) судалсан байна. Үүнд бэлэн мөнгөний хэрэглээ буурч байгаа нь дижитал гүйлгээний хэрэглээ өсөж байгаатай салшгүй холбоотой гэсэн байна. Энэхүү бэлэн мөнгөний хэрэглээ буурах нь авлигад хэрхэн нөлөөлөх талаар судалгаанууд мөн адил хийгдсэн байна. Өөрөөр хэлбэл бэлэн мөнгийг халж дижитал гүйлгээний хэрэглээг нэмэгдүүлэх нь авлигыг бууруулахад ач холбогдолтой байна.

Гэсэн хэдий ч бэлэн мөнгөгүй нийгмийг бий болгохын дутагдалтай тал нь хувийн нууцад халдах, интернэтийн системийн доголдох зэргээс үүдэлтэй асуудал байж болох тухай дурдсан (Hidayah, Waspada, Sari 2023) судалгаа ч мөн хийгдсэн байна. Дээрх үр дүнг илүү нарийвчлан энэхүү хандлага нь төрийн байгууллагуудад мөн адил нөлөөтэй эсэхэд судалгаа хийж үзсэн байна. Тухайлбал, энэхүү судалгаа нь бэлэн мөнгийг багасгах бодлогыг хэрэгжүүлэх замаар залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратегийг тодорхойлох зорилготой юм (Ridwan et al., 2022) гэжээ. Дээрх судалгаанаас ялгаатай нь бэлэн мөнгөний хэрэглээний хязгаарлалт нь зөвхөн “жигжиг” авлигыг бууруулна гэж дүгнэсэн Ayolaa.T (2013) нь Нигери Улсын хувьд бэлэн мөнгөний гүйлгээг багасгах бодлогын авлигад хэрхэн нөлөөлж буйг судалсан байна.

Дээрх олон улсад хийгдсэн судалгаанаас гадна Монгол Улсын авлигыг бууруулах зорилгоор шалтгаан, нөхцөл байдлыг судалсан дотоод, гадаадын байгууллагаас хамтарч үнэлгээ хийсэн үнэлгээний тайланд бэлэн мөнгийг хязгаарлах шаардлагын талаар дурдсан байна. Азийн сангаас гаргасан Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа 2017²-нд дээд төвшний авлигын төрлүүдээс “Албан тушаал” горилох, “Бэлэн мөнгөний” хээл хахуулийн хэлбэрийг хамгийн түгээмэл байна гэж үзсэн байна. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын хуульд авлига өгсөн болон авсан хүнийг ялгалгүй гэм буруутайд тооцдог тул “Бэлэн мөнгө” өгч байгаа тал нь үүнийхээ хариуд “Албан тушаал”-д томилогдож, хамгийн их мөнгө өгсөн хүнд “Албан тушаал” олддог үзэгдэл болон ойлголт хэвийн гэж хэлэх төвшинд байгаа тухай дурджээ. Мөн Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний Байгууллагын Конвенцын V бүлэг (хөрөнгө буцаан олгох)-ийн хэрэгжилтийн нөхцөл байдлын үнэлгээ³-нд зарим улс оронд бэлэн мөнгөний гүйлгээг хязгаарлаагүй талаар дурдаад Монгол Улсын хувьд дараах төлбөр тооцоог бэлэн бусаар, зөвхөн банкаар дамжуулан хийхийг хуульчлах хэрэгтэй гэж үзсэн байна.

Монгол Улсад гарч буй авлигатай холбоотой гэмт хэрэгт их хэмжээний бэлэн мөнгө хураагдах маш олон тохиолдол гарч байна. Тухайлбал, УБТЗ-ын албан тушаалтан С.Батдөлд татвар төлөхөөс зайлсхийсэн, мөнгө угаасан байж болзошгүй хоёр үндэслэлээр хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн бөгөөд түүнийг

² Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг ... (n.d.-g). https://asiafoundation.org/wp-content/uploads/2018/09/speak-survey_2018_mn.pdf

³ UNDP. (n.d.-e). <https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/so/b6d6f1d45cda9494c04abbb32d3b5300517f5bb3e64e378524fda98e2ca1a902.pdf>

цагдан саатуулах үеэр гэрээс нь 7,3 тэрбум төгрөг⁴ хураан авсан. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, УИХ-ын гишүүн асан Д.Хаянхярвааг баривчлах үед 315 мянган ам.доллар хураан авч⁵ улсын орлого болгосон. МХЕГ-ын албан тушаалтан, хэлтсийн дарга Н.Баярсайханы гэрээс 230,8 сая төгрөг, 152,177 ам.доллар, 70 мянган юань⁶ хураан авч байсан. Нийслэлийн Прокурорын газрын ерөнхий прокурор Ш.Нямдоржийг баривчлах үеэр 200 орчим сая төгрөг хураан авсан⁷. Эдгээр гэмт хэрэг үйлдэгчдийг баривчлах үед орон гэрээс нь их хэмжээний бэлэн мөнгө илэрсэн байгаа нь гэмт хэрэг үйлдэж олсон, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглаж олсон мөнгийг бэлнээр байршуулдаг байж болзошгүй харагдаж байна. Өөрөөр хэлбэл бэлэн мөнгө нь тухайн гэмт хэргийг илрүүлж буй хууль сахиулах байгууллагын мөрдөн шалгалтад хүндрэл бэрхшээл үүсгэдэг нь гэмт хэрэгтнүүдийн бэлэн мөнгийг хэрэглэх сэдэл болж байдаг.

Иймд бэлэн мөнгөний хэрэглээг бууруулснаар i) эдийн засгийн гэмт хэргийн илрүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах хугацаа буурах, ii) татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийг илрүүлэх, татвар ногдох орлогын хэмжээг үнэн зөв тогтоох, iii) бэлэн мөнгөний гүйлгээг бууруулснаар санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг зардлыг бууруулах болон харилцагч талд үйлчилгээ авах тааламжит нөхцөл бүрдэнэ гэх мэт ач холбогдолтой.

Авлигыг бууруулах зорилгоор бэлэн мөнгөний хэрэглээг хязгаарлах талаар олон төрлийн судалгаанууд хийгдсэн бөгөөд түүнчлэн эерэг нөлөөтэй болохыг баталсан судалгаанууд ч мөн адил хийгдсэн байна. Гэсэн хэдий ч дээрх төрлийн судалгаа нь Монгол Улсын хувьд хийгдээгүй байгаа тул авлигыг бууруулах зорилгоор бэлэн мөнгөний хэрэглээг хязгаарлах тогтолцоог бий болгох шаардлагатай юу? гэх асуултад хариулахын тулд зарим төрлийн тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн энэхүү судалгааг хийж гүйцэтгэн, судалгааны үр дүнд үндэслэн санал гаргахыг зорилоо.

⁴ <https://ikon.mn/n/2rj0>

⁵ <https://montsame.mn/mn/read/283085>

⁶ <https://isee.mn/n/23114>

⁷ <https://ubn.mn/p/18279>

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СУДЛАГДСАН БАЙДАЛ

Олон улсад авлигын төвшнийг бууруулах, шалтгааныг тодруулах зорилгоор олон судалгаа хийгдэж байгаа боловч энэ чиглэлийг судалж эхэлсэн цаг хугацаа нь бусад шинжлэх ухаантай харьцуулахад харьцангуй шинэхэн гэж хэлж болохоор байна. Гэсэн хэдий ч авлига болон бэлэн мөнгөний хоорондын хамаарлын талаар хийгдсэн дараах судалгааны ажлуудаас дурдаж болох юм.

Бэлэн мөнгөний хэрэглээний цаашдын хандлагыг (Khiaonarong & Humphrey, 2023) судалсан байна. Уг судалгаагаар хөгжиж буй 14 улсын эдийн засгийн нөхцөл байдалд хоёр төрлийн хэмжүүрийг сонгон судалсан байна. Төлбөр гүйцэтгэх үед бэлэн мөнгөний хэрэглээг сайн хэмждэггүй тул судлаачид нь АТМ-аас авсан бэлэн мөнгөний дүнг буюу бүх төрлийн төлбөрийн хувь хэмжээг гүйлгээнд байгаа мөнгөн тэмдэгтийн хэмжигдэхүүнтэй харьцуулахад бэлэн мөнгөний зарцуулалтыг илүү үнэн зөв, цаг алдалгүй хэмжих хэмжүүр буюу ДНБ-тэй харьцуулсан харьцаа гарна гэж үзжээ. Ингэснээр судалгааны үр дүнд одоогийн байдлаар дэлхийн хүн амын тал хувьд нь бэлэн мөнгийг төлбөр тооцоонд ашиглах хандлага буурч байна гэсэн үр дүн гарчээ.

Бэлэн мөнгөний хэрэглээ буурч байгаа нь дижитал гүйлгээний хэрэглээ өсөж байгаатай салшгүй холбоотой. Энэхүү бэлэн мөнгөний хэрэглээ буурах нь авлигад хэрхэн нөлөөлөх талаар судалгаанууд мөн адил хийгдсэн байна. Өөрөөр хэлбэл бэлэн мөнгийг халж дижитал гүйлгээний хэрэглээг нэмэгдүүлэх нь авлигыг бууруулахад ач холбогдолтой байна. Одоогийн байдлаар хийгдсэн судалгаанууд нь авлигын эсрэг үр нөлөөг дижиталчлалтай холбон тайлбарлаж байгаа ч авлигыг бууруулахад дижитал төлбөр ямар үүрэг гүйцэтгэж байгаа талаарх хийсэн судалгаа нь цөөн байна. Setor, Senyo, & Addo (2021) нар нь дижитал төлбөрийн системийн гүйлгээ нь авлигыг бууруулдаг уу? гэж асуултад хариулахын тулд хөгжиж буй орнуудыг сонгон судалгаа хийж үзжээ. Тодруулбал хөгжиж буй орнуудад авлигын асуудал ихээр хөндөгдөж байгаа энэ үед дижитал төлбөр болон авлига хоёрын хоорондын уялдаа холбоог судлах буюу 2010-2018 он хүртэл хөгжиж буй 111 орны дижитал төлбөрийн дата, Авлигын төсөөллийн индексийг (CPI) ашиглан тогтмол нөлөөллийн шинжилгээнд үндэслэн судлахад дижитал гүйлгээ нь авлигыг бууруулдаг нь батлагдсан байна.

Үүнтэй адилаар бэлэн мөнгийг бууруулах нь авлигыг бууруулж, нийгэмд эерэг үр дүн авчрах талаар нарийн аргачлалыг бий болгосон байна. (Alaeddin et al. 2019) авлигыг бууруулахад бэлэн мөнгөгүй нийгмийн гүйцэтгэх үүргийг

ойлгох зорилгоор судалгаа хийсэн байна. Уг судалгааны үр дүнд бэлэн мөнгөгүй нийгмийг бий болгож авлигатай тэмцэх нь бүх мэдээллийг бүртгэлжүүлэх замаар авлига авах боломжийг бууруулах нарийн арга юм. Энэ арга нь 2012 онд авлигыг бууруулах зорилгоор Нигерийн төв банкнаас хэрэглэсэн бөгөөд үүний дараа 2016 онд Энэтхэгт хуурамч мөнгөн дэвсгэртийн асуудлыг даван туулахад мөн адил ашиглагдаж байсан байна. Энэхүү судалгаа нь авлигыг таслан зогсооход туслах гол хүчин зүйлс бол бэлэн мөнгийг бууруулах бөгөөд энэ талаар цаашид судлах шинэ сэдвүүдийг санал болгосон байна.

Дээрхтэй төстэй үр дүнтэй судалгаа болох Харвард Кеннедигийн сургуулиас хийсэн судалгааны ажилд (Peter, Haylea, Tom and Ben, 2017) бэлэн мөнгөөр том дүнтэй худалдан авалт хийхийг хязгаарлах талаар судалсан байна. Энэхүү судалгааны ажлын зорилго нь бэлэн мөнгөний босго дүнг тогтоож бэлэн мөнгөний хэрэглээг хязгаарлах юм. Уг судалгааны үр дүнд бэлэн мөнгөний хууль бус хэрэглээг таслан зогсооход бэлэн мөнгөний босго дүнг тогтоох нь ач холбогдолтой, бэлэн мөнгөний хязгаарлалт нь татвараас зайлсхийх, зохион байгуулалттай мөнгө угаах гэмт хэрэгт гол нөлөөтэй, гэвч терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт төдийлөн шууд нөлөөлдөггүй гэх мэт олон дүгнэлт гарсан байна.

Гэсэн хэдий ч бэлэн мөнгөгүй нийгмийг бий болгоход гарч болзошгүй хүндрэл бэрхшээлийг зарим судлаачид тайлбарласан байна. Бэлэн мөнгөгүй нийгэм бол илүү хурдан, уян хатан, автоматжуулсан төлбөрийн системийг бий болгох дэлхийн иргэдийн хамтын алсын хараа юм (Hidayah, Waspada, Sari 2023). Энэхүү судалгаа нь бэлэн мөнгөгүй нийгэмд анхаарлаа хандуулж 2012-2022 оны хэвлэлд гарсан үр дүнг томьёолох зорилготой юм. Энэхүү судалгаа нь Судлагдсан байдлыг системчлэх аргыг (Systematic literature review approach)-ыг ашиглан “Scopus” мэдээллийн сангаас авсан эх сурвалжуудыг ашиглан бэлэн мөнгөгүй нийгэмд тулгарч буй нийтлэг ойлголт, туслах хүчин зүйлс, сорилтуудыг судлаачдын үзэл бодлоор тодорхойлсон болно. Энэхүү судалгааны үр дүнд бэлэн мөнгөгүй нийгмийг бүрдүүлэх нь нийгэм дэх эдийн засгийн өсөлт болон гүйлгээний хурдыг нэмэгдүүлэх шийдэл юм. Өөр нэг давуу тал нь авлига, татвар хураамж, залилан мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлж байгаа бөгөөд цахим төлбөр тооцоо нь энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоосон байна. Гэсэн хэдий ч бэлэн мөнгөгүй нийгмийг бий болгохын дутагдалтай тал нь хувийн нууцад халдах, интернэтийн системийн доголдох зэргээс үүдэлтэй асуудал байж болох тухай дурдсан байна.

Дээрх бүх судалгаанаас харахад бэлэн мөнгөний хэрэглээ нь дэлхий хүн амын тал хагаст нь буурч байгаа бөгөөд энэ нь авлигыг бууруулахад үр дүнтэй ч зарим нэг дутагдалтай талууд байж болзошгүй талаар дурджээ. Гэтэл эдгээр үр дүнг нарийвчлан буюу энэхүү хандлага нь төрийн байгууллагуудад мөн адил байгаа эсэхэд судалгаа хийж үзсэн байна. Тухайлбал, бэлэн мөнгөний хэрэглээг багасгах бодлогыг хэрэгжүүлэх замаар залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратегийг тодорхойлох зорилготой судалгааг хийсэн байна (Ridwan et al., 2022). Энэхүү судалгааны үр дүн нь орон нутгийн засаг захиргааны төлбөрийн системийн шинэчлэлтүүд нь бэлэн бус гүйлгээнд шилжсэнээр илүү найдвартай, үр дүнтэй, үр ашигтай бөгөөд бэлэн бус төлбөр тооцоо нь мөнгө угаах, хээл хахууль, үйлчилгээ, худалдан авалтын шимтгэл гэх мэт авлигаас урьдчилан сэргийлж чадна гэж үзсэн байна.

Дээрх судалгаанаас ялгаатай нь бэлэн мөнгөний хэрэглээний хязгаарлалт нь зөвхөн “жижиг” авлигыг бууруулна гэж дүгнэсэн Ayolaa.T (2013) нь Нигери Улсын хувьд бэлэн мөнгөний гүйлгээг багасгах бодлогын авлигад хэрхэн нөлөөлж буйг судалсан байна. Уг судалгаанд авлига нь Нигери улсын оршин тогтнолд заналхийлж буй нарийн төвөгтэй, нийтлэг, олон давхаргат асуудал гэж тодорхойлсон бөгөөд Нигер улсын засгийн газраас аюулыг таслан зогсоохын тулд янз бүрийн хүчин чармайлт гаргаж байна гэжээ. Авлигыг таслан зогсоох зорилгоор бэлэн мөнгөтэй холбоотой бодлогыг сүүлийн үеэс хэрэгжүүлж эхэлсэн байна. Иймээс энэхүү судалгаагаар бэлэн мөнгөний бодлогоор бууруулж болох авлигын төрлүүдийн талаарх оролцогч талуудын төсөөллийг үнэлэх; авлигыг таслан зогсоох бодлогын үр нөлөөг судлах; бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх амжилтын чухал хүчин зүйлсийг тодорхойлох зэргийг хийж гүйцэтгэсэн. Энэ нь Нигер улсын хувьд авлигад бэлэн мөнгөний бодлого хэрхэн нөлөөлж байгаа талаар мэдээлэл өгөх зорилготой байсан бөгөөд үүний тулд анхдагч болон хоёрдогч мэдээллийг авч ашигласан. Анхдагч мэдээлэлд нь банкны салбар, төрийн албан хаагчид, төрийн гүйцэтгэгч, эрдэмтэн судлаачдаас тус бүр 25 хүн оролцуулахаар зориудаар сонгож 100 санал асуулгад зохион байгуулалтгүйгээр хамрагдах байдлаар асуулга явуулах замаар анхан шатны мэдээллийг авсан. Хоёрдогч мэдээллийг судлагдсан байдлын судалгаанаас авсан. Цуглуулсан өгөгдлийг тайлбарлахдаа статистик ашиглан дүн шинжилгээ хийсэн. Үр дүнгээс үзэхэд бүх төрлийн авлигыг нэг стратеги шийдэж чадахгүй бөгөөд бэлэн мөнгийг хязгаарлах бодлого нь зөвхөн жижиг авлигыг бууруулж чадна. Мөн судалгааны үр дүнд авлигын үндсэн шалтгааныг арилгах, нийцтэй,

системчилсэн, олон талт шийдлүүдийг боловсруулах нь зайлшгүй бөгөөд аюул заналхийллийг арилгах хамгийн зөв арга юм гэж дүгнэжээ. Энэ нь хууль тогтоомжийг батлах, өөрчлөх, авлигачдад үр дүнтэй шийтгэл ногдуулах, цахим засаглал гэх мэт шинэлэг технологийн шийдлүүдийг ашиглан энгийн хүнтэй харилцах үйл явцыг дахин зохион байгуулах замаар системчилсэн өөрчлөлтийг хийх шаардлагатай бөгөөд энэ нь засаглалыг ил тод, иргэдэд ээлтэй болгох замаар хүмүүсийг чадавхжуулах үүрэг гүйцэтгэнэ гэсэн байна.

Дээрх олон улсад хийгдсэн судалгаанаас гадна Монгол Улсын авлигыг бууруулах зорилгоор шалтгаан, нөхцөл байдлыг судалсан дотоод, гадаадын болон олон улсын байгууллагаас судалгаануудыг хийсэн байна. Эдгээрээс нэн тэргүүнд Монгол Улсын Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2020-д Авлига, мөнгө угаах, зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг тэмцэхэд бэлэн мөнгөний хэрэглээг хязгаарлах шаардлагатай гэдгийг “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ”-ний тайланд онцолсон байна. Тухайлбал, бэлэн мөнгөний хэрэглээ давамгайлсан бизнесийн орчинтой улс оронд халхавч аж ахуйн нэгж байгуулан бэлэн мөнгө хэлбэртэй гэмт хэргийн орлогыг бизнесийн орлого мэтээр банк, санхүүгийн системд оруулах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Иймд бэлэн бус төлбөр тооцооны систем хөгжиж байгаатай холбоотой цаашид төсвийн байгууллагад бэлэн мөнгөөр орлого хүлээн авахыг үе шаттай бүрэн хориглох асуудлыг шийдвэрлүүлэх саналтай байна”⁸ гэсэн байна.

Мөн Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр MDS and Khanlex ХХГ-аас гүйцэтгэсэн Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний Байгууллагын Конвенцын V бүлэг (хөрөнгө буцаан олгох)-ийн хэрэгжилтийн нөхцөл байдлын үнэлгээ⁹-нд зарим улс оронд бэлэн мөнгөний гүйлгээг хязгаарлаагүй талаар дурдаад Монгол Улсын хувьд дараах төлбөр тооцоог бэлэн бусаар, зөвхөн банкаар дамжуулан хийхийг хуульчлах хэрэгтэй гэж үзсэн байна. Үүнд: 1. Төрийн байгууллагад хамаарах бүх төлбөр тооцоо, 2. Газар, үл хөдлөх эд хөрөнгө, соёлын өв, эртний эдлэл, үнэ бүхий уран зураг, валют арилжааны төлбөр


⁸ Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ... (n.d.-e). <http://nda.gov.mn/backend/files/be1glGDhnHGnJPI.pdf>

⁹ UNDP. (n.d.-e). <https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/so/b6d6f1d45cda9494c04abbb32d3b5300517f5bb3e64e378524fda98e2ca1a902.pdf>

тооцоо, 3. Бэлэн мөнгөний төлбөр тооцооны дээд хязгаарыг хуулиар тогтоож, энэ хязгаараас дээших төлбөр тооцоог банкаар хийх гэх мэт.

Азийн сангаас гаргасан Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа 2017¹⁰-нд дээд төвшний авлигын төрлүүдээс “Албан тушаал” горилох, “Бэлэн мөнгөний” хээл хахуулийн хэлбэрийг хамгийн түгээмэл байна гэж үзсэн байна (Зураг 1). Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын хуульд авлига өгсөн болон авсан хүнийг ялгалгүй гэм буруутайд тооцдог тул “Бэлэн мөнгө” өгч байгаа тал нь үүнийхээ хариуд “Албан тушаал”-д томилогдож, хамгийн их мөнгө өгсөн хүнд “Албан тушаал” олддог үзэгдэл болон ойлголт хэвийн гэж хэлэх төвшинд байгаа тухай дурджээ.

Зураг-1¹¹. Их авлигын хэлбэр 2012 болон 2018 онуудад



Дээрх судалгаанууд бэлэн мөнгөний хэрэглээний цаашдын хандлагыг судлан, бэлэн мөнгөний хэрэглээ буурч байгаа нь дижитал гүйлгээний хэрэглээ өсөж байгаатай салшгүй холбоотой гэж үзсэн байна. Энэхүү бэлэн мөнгөний хэрэглээ буурах нь авлигад хэрхэн нөлөөлөх талаар судалгаанууд мөн адил хийгдсэн байна. Өөрөөр хэлбэл бэлэн мөнгийг халж дижитал гүйлгээний хэрэглээг нэмэгдүүлэх нь авлигыг бууруулахад ач холбогдолтой байна гэсэн

¹⁰ Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг ... (n.d.-g). https://asiafoundation.org/wp-content/uploads/2018/09/speak-survey_2018_mn.pdf

¹¹ Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг ... (n.d.-g). https://asiafoundation.org/wp-content/uploads/2018/09/speak-survey_2018_mn.pdf

дүгнэлтийг гаргасан байна. Дээрх судалгаанууд нь авлигын эсрэг үр нөлөөг дижиталчлалтай холбон тайлбарлаж байгаа ч авлигыг бууруулахад дижитал төлбөр ямар үүрэгтэй талаарх хийсэн судалгаа ч мөн адил хийгдсэн байна.

Үүнтэй адилаар бэлэн мөнгийг бууруулах нь авлигыг бууруулж, нийгэмд эерэг үр дүн авчрах талаар нарийн аргачлалыг бий болгосон байна. Түүнчлэн төстэй үр дүн гарсан судалгаа болох Харвард Кеннедигийн сургуулиас хийсэн (Peter, Haylea, Tom and Ben, 2017) “Өндөр дүнтэй худалдан авалт хийхэд бэлэн мөнгөний хэрэглээг хязгаарлах- бэлэн мөнгөний босго тогтоох тохиолдлыг үнэлэх” судалгааны ажилд бэлэн мөнгөөр том дүнтэй худалдан авалт хийхийг хязгаарлах талаар судалсан байна. Энэхүү судалгаанд дараах хэд хэдэн дүгнэлтийг гаргасан байна. Үүнд: 1.Бэлэн мөнгөний хууль бус хэрэглээнд бэлэн мөнгөний босго дүнг тогтоох нь үр ашигтай гэсэн байна. 2. Бэлэн мөнгөний босго дүн нь татвараас зайлсхийх гэмт хэрэг, зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэгт нөлөөтэй болохоос терроризмыг санхүүжүүлэх болон хөнгөн гэмт хэргүүдэд нөлөөлөл багатай. 3. Бэлэн мөнгөний босго дүнг тогтооход маш бага сул талтай бөгөөд хууль ёсны эдийн засгийн үйл ажиллагаа болон хувь хүний нууцын тухай асуудал байж болох юм.4. Бэлэн мөнгөний босго нь хууль бус хэрэглээг бууруулах сонирхолтой бодлого юм.5. Бэлэн мөнгөний босго дүн тогтоох нь ижил төрлийн валют хэрэглэдэг улс, бүс нутгуудад давуу талтай, харин хэд хэдэн валют хэрэглэдэг нэг улсын хувьд сул тал болж болно. 6. Бэлэн мөнгөний босго дүнг тогтоохдоо илүү сайн нотлох баримт дээр үндэслэн тогтоох нь зөв байна. Мөн дээрх судалгааны үр дүнд суурилан дараах саналыг гаргасан байна.

- Европын холбоо нь бэлэн мөнгөний босго дүнг тогтоох шаардлагатай, хамгийн багадаа Евро бүсийн хэмжээнд,
- Бусад улс орнууд нь санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээний зорилгоор бэлэн мөнгөний босго дүнг тогтоох асуудлыг авч үзэх шаардлагатай,
- ФАТФ нь гишүүн улс орнуудын бэлэн мөнгөний босго дүнг тогтооход нь түлхэц болох шаардлагатай, нөлөөллийн дүн шинжилгээ хийх шилдэг туршлагыг хуваалцахад дэмжлэг болж ажиллах гэсэн байна.

Дээрх бүх судалгаанаас харахад бэлэн мөнгөний хэрэглээ нь дэлхий хүн амын тал хагаст нь буурч байгаа бөгөөд энэ нь авлигыг бууруулахад үр дүнтэй ч зарим нэг дутагдалтай талууд байж болзошгүй талаар мөн адил дурджээ.

Эдгээрээс ялгаатай нь бэлэн мөнгөний хэрэглээний хязгаарлалт нь зөвхөн “жижиг” авлигыг бууруулна гэж дүгнэсэн Ayoola.T (2013) нь Нигери Улсын хувьд бэлэн мөнгөний гүйлгээг багасгах бодлогын авлигад хэрхэн нөлөөлж буйг судалсан байна. Дээрх олон улсад хийгдсэн судалгаанаас гадна Монгол Улсын авлигыг бууруулах зорилгоор шалтгаан, нөхцөл байдлыг дотоод, гадаадын болон олон улсын байгууллагаас төсөл хэрэгжүүлэх замаар судалсан байна.

Гэвч энэхүү судалгаанууд нь олон улсын дата өгөгдөлд суурилан хийгдсэн бөгөөд Монгол Улсын хувьд бэлэн мөнгөний хэрэглээг хязгаарлах нь авлигыг бууруулахад нөлөөтэй эсэхэд хариулт өгсөн судалгаа хийгдээгүй байна.

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРЬЦУУЛСАН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.1 Олон Улс - Харьцуулсан шинжилгээ

Олон улсын байгууллагаас гаргадаг дата мэдээллийг харьцуулан гаргадаг *Merchant Machine*¹²-ний нийтэлсэн жагсаалтын дагуу улс орны бэлэн мөнгөний хэрэглээ болон бусад холбогдох мэдээллийг харьцуулсан байна. Уг судалгаанд 2022 оны байдлаар бэлэн мөнгөгүй нийгмийг бий болгож буй улс орнуудыг жагсаасан байна.

Улс орон	Интернэт хэрэглэгч хүн ам	Кредит карт эзэмшигч хүн ам	АТМ тоо/100,000 хүн тутам/	Бэлэн мөнгөөр хийгдсэн төлбөр	Банкаар үйлчлүүлдэггүй хүн ам
Singapore	92%	49%	54%	1%	2%
Switzerland	94%	66%	94%	2%	2%
United Kingdom	95%	65%	99%	1%	3%
Finland	92%	63%	37%	2%	0%
Hong Kong	92%	65%	52%	4%	5%
Netherlands	91%	39%	36%	4%	0%
Norway	97%	71%	32%	2%	0%
Sweden	95%	45%	28%	1%	0%
Denmark	97%	45%	43%	1%	0%
New Zealand	92%	61%	54%	2%	1%

Зураг-2. Хамгийн бага бэлэн мөнгөний хэрэглээтэй улс орнуудын жагсаалт¹³

¹² <https://merchantmachine.co.uk/most-reliant-on-cash/>

¹³ <https://merchantmachine.co.uk/the-countries-most-reliant-on-cash-in-2022/>


Мөн дээрх судалгаанд бэлэн мөнгөний хэрэглээ хамгийн ихтэйд тооцогддог улс орнуудыг 2022 оны байдлаар жагсаасан байна.

Улс орон	Интернэт хэрэглэгч хүн ам	Кредит карт хэрэглэгч хүн ам	АТМ тоо /100,000 хүн тутам/	Бэлэн мөнгөөр хийгдсэн төлбөр	Банкаар үйлчлүүл-дэггүй хүн ам
Brazil	81%	27%	165	19%	30%
South Africa	70%	9%	63	9%	31%
Bulgaria	70%	14%	91	74%	28%
Czechia	81%	81%	97	81%	81%
Greece	78%	12%	62	54%	14%
India	43%	3%	41	8%	20%
Mexico	72%	10%	96	8%	63%
Romania	78%	12%	22	9%	42%
Russia	85%	20%	112	5%	24%
Egypt	72%	3%	22	60%	67%
Colombia	70%	14%	64	11%	54%
Indonesia	54%	2%	26	15%	51%
Kazakhstan	86%	20%	52	50%	41%
Kenya	30%	6%	7	40%	44%
Morocco	84%	0%	29	74%	71%
Nigeria	36%	3%	16	23%	61%
Peru	65%	12%	124	14%	57%
Philippines	50%	3%	30	24%	65%
Thailand	78%	10%	59	15%	16%
Vietnam	70%	4%	26	28%	69%

Зураг-3. Хамгийн их бэлэн мөнгөний хэрэглээтэй улс орнуудын жагсаалт¹⁴

Дээрх дата мэдээллийг энэхүү судалгааны ажлын зорилго болох авлигыг бууруулахад бэлэн мөнгөний хэрэглээг хязгаарлах нь үр дүнтэй байдаг эсэхийг шалгаж үзэх зорилгоор дараах харьцуулсан графикийг гаргаж үзэв. Үүнд дээрх улс орнуудын 2022 оны (тухайн оны) Авлигын төсөөллийн индекс (CPI)-ийг авч үзлээ.

¹⁴ <https://merchantmachine.co.uk/the-countries-most-reliant-on-cash-in-2022/>



Зураг-4. Авлигын төсөөллийн индекс

Үүнээс харахад Абүлгийн улс орнууд буюу бэлэн мөнгөний хэрэглээ багатай улс орнуудын Авлигын төсөөллийн индекс харьцангуй өндөр үзүүлэлттэй буюу эерэг үр дүнг харуулж байна. Харин эсрэгээрээ бэлэн мөнгөний хэрэглээнд хэтэрхий хамааралтай улс орнууд буюу В бүлгийн улс орнууд нь Авлигын төсөөллийн индекс нь бага үзүүлэлттэй буюу харьцангуй муу үр дүнг харуулж байна. Монгол Улсын хувьд цахим гүйлгээний тоо болон мөнгөн дүн нь сүүлийн жилүүдэд өсөж байгаа (Хавсралт-2) боловч бэлэн мөнгөний гүйлгээний тоонд төдийлөн өөрчлөлтгүй байна. Мөн Авлигын төсөөллийн индекс нь 2022 оноос хойш өөрчлөгдөөгүй бөгөөд бэлэн мөнгөний гүйлгээний тоотой харьцуулан харахад дүгнэлт хийх боломжгүй байна (Хавсралт-1).

1.2 Монгол Улс - Харьцуулсан шинжилгээ

Монгол Улсын хувьд нийт бэлэн мөнгөний гүйлгээний тоо нь авлига, албан тушаалын гэмт хэргийн тоонд хэрхэн нөлөөлдөг талаарх судлаачийн таамаглалд үндэслэн сонгосон 15 хувьсагчтай олон хүчин зүйлийн регресс тооцож үзсэн боловч ажиглалтын утга нь хэт цөөн байснаас шалтгаалан үр дүнгүй гарсан. (Хавсралт-3)

Иймд дата өгөгдлийн боломжид үндэслэн Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2017-2022 оны хооронд авлига, албан тушаалын хэрэг, эдийн засгийн хэргийн бүртгэгдсэн тоон мэдээллийг бэлэн мөнгөний гүйлгээний тоотой хамааралтай эсэхийг шалгаж үзэв. Ингэхэд үр дүн нь нийт бүртгэгдсэн авлигын

гэмт хэргийн тоо болон бэлэн гүйлгээний тоо нь шууд эерэг хамааралтай буюу корреляцийн коэффициент нь 0,5227 гарсан байна.

Дээрх үр дүнгээс харахад бэлэн мөнгөний гүйлгээний тоо нь авлигын гэмт хэргийн тооноос шууд хамааралтай бөгөөд бэлэн мөнгөний гүйлгээний тоог бууруулан авлигын гэмт хэргийг бууруулах боломжтой байж болзошгүй харагдаж байна.

Авлигын гэмт хэргийн тоо болон Бэлэн мөнгөний гүйлгээний тооны корреляци

(аж.у=23)		
	Авлигын гэмт хэргийн тоо	Бэлэн мөнгөний гүйлгээний тоо
Авлигын гэмт хэргийн тоо	1.0000	
Бэлэн мөнгөний гүйлгээний тоо	0.5227	1.0000

ГУРАВДУГААР ХЭСЭГ. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхийг хязгаарлах бодлогын ач холбогдлыг улс орон бүр авч үзэж, өөр өөр хэлбэрээр хэрэгжүүлж байна. Зарим улс орон мөнгөн дүнгээр хязгаарлаж байхад зарим улс орнууд тухайн төлбөрийн төрлөөс нь хамааруулан хязгаарласан байна.

3.1. Азийн улс орнууд



- Ногоон өнгө - Бэлэн мөнгөний талбөр тооцоог хязгаарладаг улс орнууд,
- Хөх өнгө – Бэлэн мөнгөний талбөр тооцоог хязгаарлах бодлогогүй ч хэрэглээ багасаж байгаа улс
- Хар хөх – Бэлэн мөнгөний талбөр тооцоог огт хязгаарладаггүй улс орнууд,

Азийн улс орнууд	Бэлэн мөнгийг хязгаарлах бодлого
БНХАУ	*БНХАУ-ын түүх бол хамгийн богино хугацаанд бэлэн мөнгийг халж буй улсын жишээ болно. Учир нь 20 жилийн дотор бэлэн мөнгөнд суурилсан эдийн засгаас 86% гар утасны төлбөрт суурилсан эдийн засагт шилжсэн. БНХАУ-ын Alipay-ээс жуулчидтай холбоотой төлбөрийн бодлогод өөрчлөлт хийжээ. Үүнд жуулчид 500 ам.доллар хүртэлх зарлагыг аппликэйшн дээр бүртгэл хийлгүйгээр төлбөр төлөх боломжтой байсан бол 2024 оны 3 дугаар сард 2000 ам.доллар хүртэл болгон нэмэгдүүлсэн байна. Харин төлбөрийн апп дээрх бүртгэл хийлгэсэн тохиолдолд нэг удаад хийх гүйлгээний эрх нь 1000 ам.доллар байсныг 5000 ам.доллар болгон өсгөсөн байна. Мөн бүртгэлтэй хэрэглэгчдийн дундаж гүйлгээний хязгаар нь 10,000 ам.доллар хүртэлх байсныг 50,000 ам.доллар хүртэлх болгон өөрчилсөн байна.
Малайз	Малайзын 2017 оны МУТСТ тогтолцооны Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр авлига, залилан, хууль бусаар хилээр бэлэн мөнгө зөөвөрлөх, хар тамхи зөөвөрлөх болон зохион байгуулалттай гэмт хэрэг зэргийг өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн байна. Үүнд бэлэн мөнгө нь өргөн хэмжээнд хэрэглэгдэж байна гэж дүгнэсэн байна. Тиймээс бэлэн мөнгөний гүйлгээний хязгаарлалт хийх арга хэмжээг өндөр дүнтэй бэлэн гүйлгээнд авч хэрэгжүүлэхээр болсон. 2019 оны 1 дүгээр сараас 25,000 Малайзын рингит-ээс дээш дүнтэй бүх бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэхээр шийдвэрлэсэн. (Өмнө нь 50,000 Малайзын рингит байсан) Хэрэв харилцагч 25,000 Малайзын рингит-ээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн тохиолдолд тухайн мөнгөний зорилго болон эх үүсвэрийн талаар мэдээллийг өгөх ёстой.
Энэтхэг	200,000 Энэтхэгийн рупитэй тэнцэх болон түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг хориглодог. Энэхүү хязгаарлалтад орохгүй хэд хэдэн гүйлгээ байдаг. Үүнд: Засгийн газрын, шуудан оффис, банк болон хамтарсан банкууд нь хамаарахгүй.
Индонез	Бэлэн мөнгөний гүйлгээний дээд хязгаарыг 100,000,000 Индонезийн рупигээр тогтоосон байдаг.
Австрали	10,000 Австрали доллар болон түүнээс өндөр дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг хязгаарладаг. Энэхүү хязгаарлалтад орохгүй хэд хэдэн гүйлгээ бий. Үүнд: банкны дансанд орлого хийх болон зарлага гаргах ADI (authorisrd deposit-taking institution)-аар хянагдсан бүх бэлэн мөнгөний гүйлгээ, валют арилжааны гүйлгээ, үл хөдлөх хөрөнгөөс бусад хэрэглэгч хоорондын гүйлгээ орно.

Хүснэгт 1. Азийн улс орнуудын бэлэн мөнгөний гүйлгээг хязгаарлах бодлого

3.2. Европын улс орнууд



- Ногоон өнгө – Бэлэн мөнгөний төлбөр тооцоог хязгаарладаг улс орнууд,
- Хөх өнгө – Бэлэн мөнгөний төлбөр тооцоог хязгаарлах бодлогогүй ч хэрэглээ багасаж байгаа улс,
- Хар хөх – Бэлэн мөнгөний төлбөр тооцоог огт хязгаарладаггүй улс орнууд,

Европын улс орнууд	Бэлэн мөнгийг хязгаарлах бодлого
Бельги	Бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний төлбөрийг бэлэн мөнгөөр төлөх дээд хязгаар нь 3000 евро. Энэхүү хязгаарлалт нь хэрэглэгч хооронд төлбөр шилжүүлэхэд хамаарахгүй. Мөн Бельгийн хуулийн (Belgian law) дагуу дараах тусгай зохицуулалтууд байна. Үүнд: • Үл хөдлөх хөрөнгө олж авахтай холбоотой төлбөрийг бэлэн мөнгөөр төлөхийг хориглоно, • Хуулийн этгээд зэсийн кабел худалдаж авсан бол төлбөрийг бэлэн мөнгөөр төлөхийг хориглоно, худалдагч тал нь хэрэглэгч байсан ч мөн адил хориглоно, • Төмрийн хаягдал болон үнэт металл агуулсан эд зүйл худалдах, худалдан авахад бизнес хооронд бэлэн мөнгөөр төлөхийг хориглоно, • Хэрэв хэрэглэгч нь дээрх үнэт зүйлсийг бизнес эрхлэгчид худалдсан тохиолдолд 500 евро хүртэлх дүнг бэлэн мөнгөөр төлж болно. Тухайн бизнес эрхлэгч нь хэрэглэгч нь болохыг баталгаажуулах ёстой. Эдгээр хориг нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх гэрээний дагуу хийгдсэн төлбөр тооцоонд үйлчлэхгүй. <i>Авах арга хэмжээ: 250-225,000 еврогийн торгуультай</i>
Болгар	Хэд хэдэн төрлийн төлбөрийн дээд хэмжээ нь 10,000 лев (ойролцоогоор 5,108 евро, Болгарын төв банкны тухайн өдрийн ханшаар тооцогдоно) эсвэл түүнээс дээш бол бэлэн мөнгөөр хийхийг хориглоно. <i>Авах арга хэмжээ нь: нийт дүнгийн 25 хувь хүртэлх торгууль оногдуулна (хуулийн этгээдэд 50 хувь хүртэлх)</i>
Хорват	2023 оны 1 дүгээр сараас эхлэн Хорват улсад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулдаг хувь хүн ба бизнес эрхлэгч хувь хүн 10,000 евро болон түүнээс дээш төлбөрийг бэлэн мөнгөөр хийхийг хориглоно.
Чех	Өдөрт 270,000 чех крон (ойролцоогоор 10,509 евро) -аас дээш бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхийг хориглоно. <i>Авах арга хэмжээ: хувь хүн 500,000 чех крон, хуулийн этгээд 5,000,000 чех кроны торгуультай.</i>

Дани	Хувь хүмүүсийн хооронд бэлэн мөнгөний хязгаарлалт байхгүй. Хэрэв хуулийн этгээд бол дараах хязгаарлалтууд үйлчилнэ: • Худалдаачдын хувьд 20,000 дани крон (ойролцоогоор 2689 евро) болон түүнээс дээш дүнтэй бэлэн орлогоор төлбөр төлөхийг хориглоно. Энэ нь банк болон бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нарт хамаарахгүй. • Худалдаачдын хувьд 20,000 дани крон (ойролцоогоор 2689 евро) хүртэлх төлбөр тооцоог бэлэн мөнгөөр хийх бол зөвхөн 6 цагаас 22 цагийн хооронд (гэмт хэргийн гаралт өндөртэй бүс нутагт 20 цаг хүртэл) хийх үүрэгтэй. Энэхүү үүрэг нь тодорхой төлбөрийн хэлбэрүүдэд үйлчилдэг. Картын төлбөр гэх мэт. • 500 еврогийн дэвсгэрт болон 25т зоос ашиглахыг хориглоно. • Зоосоор төлбөр хийхдээ нэг гүйлгээнд дээд тал нь 25т зоос хэрэглэж болно. Зөвхөн зоосоор төлж болох дээд хэмжээ нь 962.50 дани крон (ойролцоогоор 129 евро). • Үйлчилгээ болон үйлчилгээтэй холбоотой бараа худалдан авахад 8000 DK (ойролцоогоор 1075 евро) ба түүнээс дээш мөнгөн дүнгээр бэлэн мөнгөөр төлөхийг хориглоно. Хэрэв худалдаачин худалдан авсан үнийн дүнгийн орлогын албан татвар, НӨАТ-ыг төлөөгүй тохиолдолд хэрэглэгч хариуцах боломжтой. Худалдан авагч нь татварын албанд (төлбөр төлснөөс хойш 14 хоногийн дотор, нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор) мэдүүлснээр энэ хариуцлагаас чөлөөлөгдөж болно.
Эстони	Бэлэн мөнгөөр төлбөр хийх нь хязгаарлалтгүй боловч мөнгөн дүнгээсээ хамаарахгүйгээр 50 т зоос болон дэвсгэртээр тооцоо хийх нь хориотой байдаг.
Финланд	Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхэд тогтоосон хязгаар байхгүй. Харин худалдаачид бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхгүй байх эрхтэй. Энэ тохиолдолд бэлэн мөнгө хүлээн авахгүй гэдгээ тодорхой тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан байх.

Франц	Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх дээд хязгаар нь: • Франц улсад оршин суугч, татвар төлөгчдөд 1000 евро, • Франц улсад оршин суугч бус хэрэглэгчдэд 15.000 евро, • Хөрөнгө худалдан авахтай холбоотой, нотариатаар баталгаажуулсан төлбөрүүдийг бэлэн мөнгөөр хийж болох дээд хэмжээ нь 3000 евро, • Хувь хүмүүс хооронд хийсэн төлбөрүүд жишээ нь автомашин худалдах зэрэг нь бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх хязгаарт хамаарахгүй. 1500 еврогоос дээших төлбөрт баталгаажуулах зорилгоор нэхэмжлэхийг заавал үйлдэх шаардлагатай. • Татвар төлөхөд бэлэн мөнгөний дээд хязгаар нь 300 евро байна. Худалдаачид бэлэн мөнгөөр тооцоо хийхийг хүлээн зөвшөөрөх үүрэгтэй. Эс бөгөөс 150 еврогийн торгуультай. Худалдаачид гэмтсэн мөнгөн дэвсгэртээр тооцоо хийхээс татгалзах эрхтэй, жишээлбэл шөнийн цагаар тооцоо хийх үед гэх мэт. Хэрэв худалдаачин тухайн дэвсгэртийг жинхэнэ эсэхэд эргэлзсэн тохиолдолд тухайн харилцагчийн талаарх мэдээлэл болох мөнгөний гарал үүслийг асуух эрхтэй. Худалдаачид 50-т зоос, мөн төлөх ёстой хэмжээнээс хэтэрсэн мөнгөн дэвсгэртээр төлбөр хийхээс татгалзах эрхтэй.
Герман	Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх дээд хязгаар байхгүй. Гэвч 10,000 еврогоос дээш бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхийг хүссэн хувь хүн бүх бичиг баримтаа үзүүлэх ёстой. Худалдаачин тэдгээр мэдээлэл буюу нэр, овог, төрсөн газар, харьяалал болон гэрийн хаяг зэргийг цуглуулан, бүртгэж, хадгалах ёстой. Алт, мөнгө, цагаан алт гэх мэт үнэт металлын нэргүй худалдан авалт хийсэн тохиолдолд 2020 оны 1 дүгээр сараас эхлэн 1,999,99 еврогийн бэлэн төлөлтийн хязгаарлалт хэрэгжүүлж эхэлсэн. Дээрх дүнгээс дээш бэлэн мөнгөөр төлсөн тохиолдолд жижиглэн худалдаачин нь харилцагчийн талаарх мэдээллийг баталгаажуулж, харилцагчаа таньж мэдэх хэрэгтэй. 2023 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой худалдааг бэлэн мөнгөөр хийхийг хориглосон.
Грек	Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх дээд хязгаар нь 500 евро байна. Үүнээс дээш дүн бол банк хоорондын шилжүүлэг, карт, чек зэргээр төлбөрийн хэрэгслээр хийгдэх ёстой. Автомашин худалдан авахад ямар нэгэн бэлэн мөнгөний дээд хязгаар гэж байхгүй. Бэлэн мөнгөөр төлбөр төлөх дээд хязгаарыг 200 евро болгохоор хуулийн төсөл хэлэлцэгдэж байна.
Унгар	Хэрэглэгчид ямар нэгэн хязгаарлалтгүйгээр бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийж болно. НӨАТ төлөгч бизнес эрхлэгч, бизнесийн нэгдэл болон хувь хүмүүсийн хувьд бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх хязгаар нь сард 1,5 сая Унгарын форинт буюу ойролцоогоор 41,695 евро байна.

Авлигы бууруулах зорилгоор бэлэн мөнгөний гүйлгээг хязгаарлах нь

Итали	2023 оны 01 дүгээр сараас бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх хязгаар нь 5000 евро байхаар тогтоосон. (Өмнө нь энэ дүн 2000 евро байсан)
Латва	Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх дээд хязгаар нь 7,200 евро байна. Мөн газар худалдах гэрээний төлбөрүүд бэлэн мөнгөөр хийх хориотой. <i>Авах арга хэмжээ: Энэхүү хоригийг зөрчвөл нийт дүнгийн 15 хувиар торгууль оногдуулна.</i>
Литва	2022 оны 11 дүгээр сараас эхлэн бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх хязгаар нь хувь хүн болон хуулийн этгээдэд 5000 евро байна.
Люксембург	Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх хязгаарлалт байхгүй. Гэвч 10,000 еврогоос дээш бэлэн мөнгөний төлбөр хийгдвэл худалдаачин нь харилцагчийн мэдээллийг баталгаажуулж авах ёстой. Уг мэдээллийг хамгийн багадаа 5 жил хадгалж, хэрэв мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй хэмээн сэжиглэвэл Люксембургийн эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.
Мальта	Зарим эд зүйл, бараа бүтээгдэхүүний төлбөрт 10,000 евро болон түүнээс дээш дүнг бэлэн мөнгөөр төлж болохгүй. Үүнд: эртний эдлэл, үл хөдлөх хөрөнгө, үнэт эдлэл, гоёл чимэглэл, сувд, үнэт чулуу, автомашин, завь, урлагийн бүтээл зэрэг орно. <i>Авах арга хэмжээ: тухайн төлбөрөөс хамгийн багадаа 40 хувиар торгууль оногдуулна.</i>
Нидерланд	Бэлэн мөнгөө төлбөр тооцоо хийх хязгаарлалт байхгүй. Гэвч 10,000 евро болон түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөөр төлбөр хийсэн үед борлуулагч нь харилцагчийг таньж мэдэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Мөн худалдагч нь төлбөрийн бүх хэсгийг эсвэл тодорхой хэсгийг бэлэн мөнгөөр авах эсэхээ өөрөө шийднэ. Сэжигтэй гүйлгээ, үйлдлийн талаар мэдээлэх чиг үүрэг нь 2000 евро болон түүнээс дээш мөнгөн дүнгээс дээш үед хэрэгжинэ. Одоогоор бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх хязгаарыг 3000 евро болгох зохицуулалт хийхээр ажиллаж байна.
Норвег	Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх эрхтэй бөгөөд хувь хүмүүс хооронд ямар нэгэн хязгаарлалт байхгүй. Гэвч хуулийн этгээдэд дараах хязгаарлалт үйлчилнэ. Үүнд: - Худалдагч 40,000 норвеги крон (ойролцоогоор 3841 евро) болон түүнээс дээш үнийн дүнтэй барааг бэлэн мөнгөөр төлөхийг зөвшөөрөхгүй. Мөн төлбөрийг хувааж хийсэн тохиолдолд мөн адил хамаарна. - Үйлчилгээ болон үйлчилгээтэй холбоотой бараа бүтээгдэхүүн худалдахад 10,000 норвег крон (ойролцоогоор 958 евро)-оор бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхгүй. Мөн үйлчилгээ үзүүлэгч нь орлогын татвар, нөат, ндш (social security contributions) төлөөгүй бол худалдан авагч нь хариуцна. - Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхэд нэгж тутамд 25-аас илүүгүй зоос авч болно.

Польш	Хувь хүмүүст бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх хязгаарлалт байхгүй. Худалдаачид хооронд бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх хязгаар нь 15,000 Польшийн злот (ойролцоогоор 3300 евро). 2024 оны 1-р сард бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх дээд хязгаарт өөрчлөлт оруулахаар төлөвлөж байсан боловч батлагдаагүй.
Португал	Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх дээд хязгаар нь 3000 евро болон түүнээс дээш байна. Португалын хуулиар дараах зохицуулалтууд байна. Үүнд: • Португал улсад хувь хүний орлогын болон аж ахуйн нэгжийн албан татвар төлөгч хүмүүсийн хувьд 1000 евро ба түүнээс дээш хэмжээний бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхийг хориглоно. • Хэрэв төлбөрийг Португалд оршин суугч бус хэрэглэгч хийсэн бол 10,000 евро ба түүнээс дээш хэмжээний бэлэн мөнгөөр төлбөр хийхийг хориглоно. • Татвар төлөхдөө зөвхөн 500 евро хүртэлх дүнг бэлэн мөнгөөр төлж болно.
Румын	Бизнес эрхлэгчид нь өдөрт зөвхөн 5000 румын лей (ойролцоогоор 1016)-аас хэтрэхгүй тохиолдолд төлөх төлбөрийг бэлнээр хийж болно. Бараа, үйлчилгээ хүргэхэд энэ хязгаар нь өдөрт 10,000 лей (ойролцоогоор 2033 евро) байна. Хэрэглэгчдийн хоорондох төлбөр, жишээлбэл бараа, үйлчилгээ худалдан авсан эсвэл түрээсийн төлбөр зэрэгт өдөрт 50,000 лей (ойролцоогоор 10,165 евро)-аас бага дүн бэлнээр хийж болно.
Словак	2023 оны 7-р сарын 1-ээс Словак дахь бүх хувь хүн болон хуулийн этгээдийн бэлэн мөнгөний төлбөрийн хязгаар нь 15,000 евро байна.
Словени	Худалдаачид зөвхөн 5000 евро хүртэлх дүнг бэлэн мөнгөөр хийх эрхтэй.
Испани	Худалдаачдад төлбөр төлөх эсвэл худалдаачдаас төлбөр хүлээн авахад 1000 евро ба түүнээс дээш хэмжээний төлбөрийг бэлэн мөнгөөр хийхгүй. Испанид оршин суугч бус татвар төлөгч хэрэглэгчийн хувьд бэлэн мөнгөний хориг нь 10,000 евро ба түүнээс дээш хэмжээний мөнгөнд хамаарна. <i>Авах арга хэмжээ: Энэ хоригийг зөрчвөл нийт дүнгийн 25 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулдаг.</i>
Швед	Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх хязгаарлалт байхгүй. Гэвч худалдаачид бэлэн мөнгө хүлээн авахаас татгалзаж болно. Энэ нь тодорхой байх хэрэгтэй бөгөөд (жишээлбэл, дэлгүүрийн урд байрлах харгалзах тэмдэг байршуулах гэх мэт). Эрүүл мэндийн үйлчилгээ нь бэлэн мөнгөний төлбөрийг үргэлж хүлээн авах ёстой.
Их британи	Хувь хүмүүст бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх хязгаарлалт байхгүй. Харин худалдаачид 10,000 еврогоос дээш дүнтэй төлбөрийг бэлнээр хүлээн авах тохиолдолд татварын албанд “Өндөр дүнтэй арилжаа”-аар бүртгүүлэх шаардлагатай. Мөн дээрх заалтад хамаарахгүй зүйлс байна.

Дэлхийн улс орнууд бэлэн мөнгөний хэрэглээг хязгаарлах бодлогыг хэрэгжүүлэх хандлагатай байгаа нь дээрх хүснэгтэн мэдээллээс харагдаж байна. Ингэхдээ технологийн дэвшлийг ашиглан бэлэн мөнгөний хэрэглээг нь хумихаас гадна бодлого журмаар зохицуулж байна. Дээрх улс орнуудын төрөөс хэрэгжүүлж буй бодлогыг тоймлон харвал дараах байдалтай байна. Үүнд:


1. **Эрх цэргийн зохицуулалт хийх байдлаар** буюу худалдаа арилжаа эрхлэгчдийн бэлэн мөнгийг хүлээн авахаас татгалзах эрхийг нь хуулийн дагуу нээж өгсөн байна.
2. **Мэдээлэх цэргийг бий болгох байдлаар** буюу худалдаа арилжаа эрхлэгчид нь харилцагчтай холбоотой бэлэн мөнгөөр хийгдсэн гүйлгээний мэдээллийг хадгалах, эрх бүхий байгууллагад мэдээлэх эрхтэй болгосон байна.
3. **Бэлэн мөнгөөр хийгдэж болох төлбөр тооцоог ангилах байдлаар** буюу худалдан авч буй бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээтэй холбоотойгоор ялгаж, зарим төрлийн бараа бүтээгдэхүүнийг бэлэн мөнгөөр худалдан авахыг хориглосон байна. Жишээ нь: үл хөдлөх хөрөнгө, үнэт металл түүнтэй адил бүтээгдэхүүний худалдааг бэлэн мөнгөөр хийхийг хориглосон байна.
4. **Хэрэглэгчээр нь ангилах байдлаар** буюу тухайн улсын оршин суугч мөн эсэх, татвар төлөгч мөн эсэх, гадаадын иргэн мөн эсэх зэргээс нь хамааруулан бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхийг хориглосон байна. Жишээ нь: Португали улсад хувь хүний орлогын болон аж ахуйн нэгжийн албан татвар төлөгч хүмүүсийн хувьд 1000 евро ба түүнээс дээш хэмжээний бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхийг хориглодог. Харин Португалид оршин суугч бус хэрэглэгч хийсэн бол 10,000 евро ба түүнээс дээш хэмжээний бэлэн мөнгөөр төлбөр хийхийг хориглодог гэх мэт.
5. **Мөнгөн дүнг тогтоох байдлаар** буюу босго мөнгөн дүнг тогтоож, уг мөнгө дүнгээс дээших төлбөрийг бэлэн мөнгөөр хийхийг хориглосон байна. Жишээ нь: Словени улсад 5000 евро хүртэлх дүнгээр, Латви улсад 7,200 евро буюу эдгээр дүнгээс дээш дүнтэй төлбөр тооцоог бэлэн мөнгөөр хийхийг хориглосон байна.

6. **Хууль эрх зүйн актаар зохицуулсан** буюу улс орон бүр өөр өөр төрлийн эрх зүйн баримт бичгээр зохицуулсан байна. Ихэнх улс орнууд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон түүнтэй ижил төрлийн хууль, журмын дагуу зохицуулсан байна.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ.


МОНГОЛ УЛСЫН БЭЛЭН МӨНГӨНИЙ ХЭРЭГЛЭЭ

Монгол Улсын банк санхүүгийн системийн том 5 банкаар дамжин хийгддэг бэлэн мөнгөөр хийсэн гүйлгээний мэдээллийг цуглуулан, бэлэн мөнгөөр гүйлгээ хийдэг харилцагч нарт ажиглалт хийж үзэв. Үүнд:



Тоон мэдээлэлд хамрагдсан харилцагчдын (давхардсан тоогоор 900 гаруй мянган харилцагч) хувьд эмэгтэй харилцагчид нь эрэгтэй харилцагчидтай харьцуулахад бэлэн мөнгөөр гүйлгээ хийх хандлагатай байна (Хүснэгт-1). Харин бэлэн мөнгөний гүйлгээ хийдэг харилцагч нарын насыг ангилж үзэхэд 50-64 насны харилцагч нар хамгийн ихээр бэлэн мөнгөний гүйлгээг хийж байна. Мөн 29 хүртэлх насны харилцагч нар бэлэн мөнгөний гүйлгээг бараг хийдэггүй байна. Энэ нь харилцагч нарын санхүүгийн боломж, амьдралын хэв маягтай холбоотой бөгөөд энэхүү харилцагчийн онцлог бүрд байх хэв маягийг арилжааны банкнууд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор гүйлгээг хяналт тавихад авч үзэх нь тохиромжтой байна (Хүснэгт-2).


Харилцагчийн боловсролоор



3.

Судалгааны дата мэдээлэл хамрагдсан нийт харилцагчдын боловсролоор нь ангилан үзэхэд бүрэн дунд боловсролтой харилцагч нар нь бэлэн мөнгөний гүйлгээг олноор нь хийдэггүй бөгөөд бусад гэсэн ангилалд бүртгэлтэй харилцагч нар нь бэлэн мөнгөний гүйлгээг ихээр хийж байна. Үүнээс харахад банкнуудын мэдээлэл цуглуулах аргаас хамааран харилцагч нар нь тодорхой мэдээлэл өгөхийг хүсдэггүй буюу бусад гэсэн ангилалд бүртгүүлдэг байж болох юм (Хүснэгт-3). Мөн дээрх ангиллын мэдээллийг зарим банкнаас гаргаж өгөх нь программ хангамжийн хувьд боломжгүй гэж мэдэгдсэн байна.

Харилцагчийн ажил эрхлэлтээр



4.

Харин харилцагч нарын ажил эрхлэлттэй холбоотойгоор дээрхтэй адилаар хувийн байгууллага, бусад, ажилгүй, тэтгэвэрт гэсэн ангиллуудад багтах харилцагч нар нь бэлэн мөнгөний гүйлгээг олноор хийж байна. Харин төрийн байгууллага болон бизнес эрхлэгч болон оюутан гэсэн ангиллын харилцагч нар нь бэлэн мөнгөний гүйлгээг харьцангуй багаар хийдэг байна. Судлаачийн таамаглалаар бизнес эрхлэгч нар нь бэлэн мөнгөний гүйлгээг харьцангуй олноор хийдэг харилцагч байж болзошгүй гэж таамагласан боловч тоон мэдээллийн үр дүн өөр үр дүнг харуулж байсан.

ТАВДУГААР ХЭСЭГ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Авлига бол дэлхийн бүх улс орны асуудал бөгөөд тэдгээр улс орнууд авлигатай тэмцэх бодлогыг ялгаатай хэрэгжүүлснээр үр дүн нь ч мөн адил ялгаатай байна. Энэ нь олон улсад хийгдсэн судалгаа болон тэдгээр судалгаанд үндэслэн авч хэрэгжүүлж буй бодлогоос харагдаж байна. Дэлхий нийтээр бэлэн мөнгөний хэрэглээ буурч, бэлэн бус гүйлгээний хэрэглээ нэмэгдсээр байгаа нь авлигыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж болох нэг төрлийн арга хэмжээ байж болох талаар дурдсан олон судалгааны ажлууд хийгдсэн байна. Мөн дэлхийн бусад улс орны энэ төрлийн эрх зүйн зохицуулалтыг судалж үзэхэд авлигын төсөөллийн индекс өндөр буюу авлигын төвшин багатай улс орнууд нь бэлэн мөнгөний хэрэглээ багатай байгаа нь харагдаж байна. Одоог хүртэл хийгдсэн судалгаанууд дээр бэлэн мөнгөний хэрэглээг багасгах нь авлигыг бууруулахад үр дүнтэй гэсэн дүгнэлтүүдийг хийсэн байна.

Монгол Улсад дээрх төрлийн нарийн судалгаа хийгдээгүй боловч зарим олон улсын байгууллагаас хийсэн тайланд авлигыг бууруулах зорилгоор бэлэн мөнгөний гүйлгээг хязгаарлах шаардлагатай талаар дурдсан байна. Нөгөөтээгүүр авлигын гэмт хэргийн сэжигтнийг баривчлах үед өндөр дүнтэй бэлэн мөнгө хадгалж байсан нь илрэх тохиолдол цөөнгүй байна.

Иймд бэлэн мөнгөний хэрэглээг хязгаарлах олон улсын туршлагаас Монгол Улсад хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд дараах байдлаар хэрэгжүүлж болох юм. Үүнд:

1. *Эрх цэргийн зохицуулалт хийх байдлаар* буюу худалдаа арилжаа эрхлэгчдийн бэлэн мөнгийг хүлээн авахаас татгалзах эрхийг нь нээж өгсөн байна. Энэ нь Монгол Улсад төдийлөн тохиромжгүй бөгөөд худалдаа эрхлэгчдийн ёс суртахуун дээр илүү тулгуурласан бөгөөд хяналтын маш сайн механизм шаардлагатай.

2. *Мэдээлэх цүргийг бий болгох байдлаар* буюу худалдаа арилжаа эрхлэгчид нь харилцагчтай холбоотой бэлэн мөнгөөр хийгдсэн гүйлгээний мэдээллийг хадгалах, эрх бүхий байгууллагад мэдээлэх эрхтэй болгосон байна. Үүнд Монгол Улсын хувьд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдийн төрлийг нэмэгдүүлэх шаардлага үүсэх бөгөөд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага тулгарна. Мөн худалдаа арилжаа эрхлэгчид нь ямар төрлийн мэдээллийг хадгалан, мэдээллийн сан үүсгэх зэргээс хамааран Хувь хүний нууцын тухай хуультай зөрчилдөх асуудал үүсэж болзошгүй.
3. *Бэлэн мөнгөөр хийгдэж болох төлбөр тооцоог ялгах байдлаар* буюу худалдан авч буй бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээтэй холбоотойгоор ангилан, зарим төрлийн бараа бүтээгдэхүүнийг бэлэн мөнгөөр худалдан авахыг хориглосон байна. Жишээ нь: үл хөдлөх хөрөнгө, үнэт металл түүнтэй адил бүтээгдэхүүний худалдааг бэлэн мөнгөөр хийхийг хориглосон байна. Үүнд Монгол Улсын одоогийн эрх зүйн байдалд хамгийн тохиромжтой шийдэл байж болохоор харагдаж байна.
4. *Хэрэглэгчээр нь ангилах байдлаар* буюу тухайн улсын оршин суугч мөн эсэх, татвар төлөгч мөн эсэх, гадаадын иргэн мөн эсэх зэргээс нь хамааруулан бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийхийг хориглосон байна. Үүнд Монгол Улс нь гадаад жуулчдыг бэлэн мөнгөөр худалдаа хийх гүйлгээний дээд хязгаарыг тогтоож өгөх байдлаар зохицуулах боломжтой.
5. *Мөнгөн дүнг тогтоох байдлаар* буюу босго мөнгөн дүнг тогтоож, уг мөнгө дүнгээс дээших төлбөрийг бэлэн мөнгөөр хийхийг хориглосон байна. Энэ тохиолдолд арилжааны банкнаас бэлэн мөнгөний хэрэглээтэй холбоотой нарийвчилсан судалгаа авч, дүн шинжилгээ хийж дээд хязгаарыг тогтоох боломжтой.
6. *Хууль эрх зүйн актаар зохицуулсан буюу* улс орон бүр өөр өөр төрлийн эрх зүйн баримт бичгээр зохицуулсан байна. Олон Улсад ихэвчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуультай ижил эрх зүйн баримт бичигт зохицуулсан байна. Монгол Улсад мөн адил Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар зохицуулах шаардлагатай.

Дээрх олон улсын туршлага дээр үндэслэн Монгол Улсын хувьд бэлэн

мөнгөний гүйлгээний хязгаарлалтыг дараах байдлаар зохицуулах саналыг гаргаж байна. Үүнд:

Хязгаарлалтын төрөл	Салбар	Тодорхойлолт
Бүрэн хязгаарлах	Үл хөдлөх хөрөнгө	Бэлэн мөнгөөр үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авахыг хориглох
	Төрийн байгууллага	Бэлэн мөнгөөр хийх бүх төрлийн гүйлгээг хориглох
	Олон улсын байгууллага	Бэлэн мөнгөөр хийх бүх төрлийн гүйлгээг хориглох
	Хандив тусламж	Хандив тусламжийн гүйлгээг бэлэн мөнгөөр хийхийг хязгаарлах
Хэсэгчлэн болон дээд хэмжээг тогтоох	Аялал жуулчлал	Гадаадын жуулчдад бэлэн мөнгөөр гүйлгээ хийх хориглох
	Банк санхүү	Харилцагчдын төрлөөр ангилан бэлэн мөнгөний гүйлгээний дээд хязгаарыг тогтоох

Мөн харилцагчдын төрлөөр ангилан бэлэн мөнгөний гүйлгээний дээд хязгаарыг тогтоохдоо арилжааны банкнуудын тоон мэдээлэлд үндэслэн харилцагчийн төрөл бүрд хийгддэг бэлэн мөнгөний дээд, доод, дундаж дүнг гарган, тухайн дүнтэй нь уялдуулах байдлаар бэлэн мөнгөний гүйлгээний босго дүнг тогтоох шаардлагатай.


Мөн арилжааны банкнуудын харилцагчаас хүлээн авдаг мэдээлэл нь үнэн зөв эсэхэд авах арга хэмжээ нь банкнууд тухайн харилцагчтай бизнесийн харилцаагаа таслах хүртэлх байдлаар зохицуулагддаг бөгөөд үүнд хуулийн дагуу авах арга хэмжээ байхгүй. Энэ нь арилжааны банканд харилцагчаас ирүүлдэг мэдээлэлд бүрэн дүүрэн итгэх боломжгүй байна.

Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг судлаачийн зүгээс санал болгож байна.


1. Монгол Улсад бэлэн мөнгөний хязгаарлалтыг энэхүү судалгааны үр дүнд дурдсан хэлбэрүүдээс сонгон хэрэгжүүлэх,
2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны дата мэдээллийг боломжит байдлаар дэлгэрэнгүй гаргаж, судалгаанд ашиглахуйц байдлаар хадгалах,
3. Арилжааны банкны дата мэдээллийн үнэн зөв мэдээлэлд шаардагдах эрх зүйн хэм хэмжээг бий болгох талаар судалгааг хийх,

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1



Хавсралт 2



Хавсралт 3

. regress FSTRfiu STRfiu CTRfiu GDPchange FI Ecocrime budgetexpense, beta

Source	SS	df	MS	Number of obs = 23	
				F(6, 16) = 14.15	
Model	3.0387e+09	6	506452258	Prob > F = 0.0000	
Residual	572539488	16	35783718	R-squared = 0.8415	
				Adj R-squared = 0.7020	
Total	3.6113e+09	22	164147865	Root MSE = 5981.9	

FSTRfiu	Coef.	Std. Err.	t	P> t	Beta
STRfiu	2.390814	5.364979	0.45	0.662	.0519555
CTRfiu	-.0289061	.0559937	-0.52	0.613	-.0768602
GDPchange	1629.289	375.7882	4.34	0.001	.4845997
FI	-2.03452	10.42216	-0.20	0.040	-.0252324
Ecocrime	-173.4207	68.21465	-2.54	0.022	-.3381688
budgetexpense	.0043743	.0020489	2.13	0.049	.3459385
_cons	20944.32	9799.479	2.95	0.009	.

. regress CTRfiu STRfiu FSTRfiu Ecocrime Theft Roberry Fraud Embezzlement corruption wildlife budgetexpense, beta

Source	SS	df	MS	Number of obs = 24	
				F(10, 13) = 11.10	
Model	2.4156e+10	10	2.4156e+09	Prob > F = 0.0001	
Residual	2.8300e+09	13	217688523	R-squared = 0.8951	
				Adj R-squared = 0.8145	
Total	2.6986e+10	23	1.1733e+09	Root MSE = 14754	

CTRfiu	Coef.	Std. Err.	t	P> t	Beta
STRfiu	7.241985	19.19736	0.38	0.712	.0575866
FSTRfiu	.1945019	.6155328	0.32	0.757	.0749348
Ecocrime	-98.54032	243.58	-0.40	0.692	-.0706196
Theft	39.13431	14.60419	2.68	0.019	1.181619
Roberry	-131.9128	96.51306	-1.37	0.195	-.5622322
Fraud	-12.97465	9.942344	-1.30	0.215	-.324976
Embezzlement	-11.88404	151.3457	-0.08	0.939	-.0190112
corruption	179.8181	50.29337	3.58	0.003	.429354
wildlife	-89.48014	91.69245	-0.98	0.347	-.1516445
budgetexpense	-.0007266	.0055481	-0.13	0.898	-.0238154
_cons	82722.04	31408.62	2.63	0.021	.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Setor, t. K., senyo, p. K., & addo, a. (2021). Do digital payment transactions reduce corruption? Evidence from developing countries. *Telematics and informatics*, 60, 101577.
2. Khiaonarong, t., & humphrey, d. (2023, march 17). Measurement and use of cash by half the world's population. *Imf*.
3. <https://www.imf.org/en/publications/wp/issues/2023/03/17/measurement-and-use-of-cash-by-half-the-worlds-population-531077>
4. Implementation of cashless policy to minimize fraud in ... (n.d.-b). https://www.researchgate.net/publication/365182536_implementation_of_cashless_policy_to_minimize_fraud_in_the_government_sector_a_systematic_review/download
5. The effect of cashless policy of government on corruption in nigeria | dr. T.j. Ayoola. (n.d.-c). <https://scholar.oauife.edu.ng/tjayoola/publications/effect-cashless-policy-government-corruption-nigeria>
6. Alaeddin, o., altounjy, r., abdullah, n., zainudin, z., & kantakji, m. H. (2019). The future of corruption in the era of cashless society. *Humanities & social sciences reviews*, 7(2), 454-458.
7. The dynamics of cashless society: a systematic review. (n.d.-c). https://www.researchgate.net/publication/369029428_the_dynamics_of_cashless_society_a_systematic_review
8. Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ... (n.d.-e). <http://nda.gov.mn/backend/files/be1glgdhnhgnjpi.pdf>
9. Undp. (n.d.-e). <https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/so/b6d6f1d45cda9494c04abbb32d3b5300517f5bb3e64e378524fda98e2ca1a902.pdf>
10. Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг ... (n.d.-g). https://asiafoundation.org/wp-content/uploads/2018/09/speak-survey_2018_mn.pdf

11. *Limiting the use of cash for big purchases. Harvard kennedy school. (n.d.).
Https://www.hks.harvard.edu/centers/mrcbg/publications/awp/awp80*
12. *https://www.europe-consommateurs.eu/en/shopping-internet/cash-payment-limitations.html -belen mungun hyazgaarladaг ulds орнууд*
13. *Susan Rose-Ackerman- The Role of the World Bank in Controlling Corruption-1997*
14. *Black-Economy-Taskforce- Final-Report-2017*
15. *Asian business council-What Would a Cashless Society Mean for Asian Consumers*
16. *McKensey Company- the-next-payments-era-future-opportunities-for-banks*



Б.БАТХУЯГ

Авлигатай тэмцэх газрын мөрдөгч, комиссар

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

An analysis of the current trends and challenges in Combating Money Laundering

Хураангуй:

Манай улсын хувьд улс, орон дамнан үйлдэгддэг мөнгө угаах гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрч, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх шаардлага бий болсон нь 2016 онд хийсэн Монгол Улсын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлан, бүртгэгдэж, шалгагдсан мөнгө угаах гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ болон гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээллүүдээс харагдаж байна. Мөнгө угаах гэмт хэргийн өнөөгийн байдалд судалгаа шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, шийдвэрлэх арга замын талаар дүгнэлт гаргахад энэхүү өгүүлэл чиглэгдсэн.

Abstract: Mongolia is increasingly facing the threat of cross-border money laundering crimes, underscoring the urgent need to strengthen national counter-measures. This urgency is supported by findings from the 2016 National Risk Assessment of Money laundering and terrorist financing, along with analyses of registered and investigated money laundering cases and intelligence gathered through operational activities. This article provides a comprehensive assessment of the current landscape of money laundering in Mongolia, identifies the key challenges confronting law enforcement and regulatory bodies and proposes policy oriented solutions grounded in research and practical insights.

Түлхүүр үг: Мөнгө угаах, гэмт хэрэг, нөхцөл байдал, хамтын ажиллагаа.

Key words: Money laundering, criminal offence, current situation, inter-agency cooperation.

Нэг. Эрх зүйн зохицуулалтын талаар

“Мөнгө угаах” хэмээх нэр томъёоны гарал үүслийн талаар олон янзын хувилбар байдгаас хамгийн их дэлгэрсэн нь 1920-д оны үед АНУ-ын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд “Согтууруулах ундааны зүйл үйлдвэрлэх тээвэрлэх, худалдан борлуулахыг хориглосон” зүйл заалтыг нэмэлт болгон оруулсан явдал тооцогдох бөгөөд 1933 оны 12 дугаар сард уг зүйл заалтыг хүчингүй болгосон ч түүхэнд энэ үйл явдал “Хуурай хууль” гэж нэрлэгдэн үлджээ.

Энэ л үеэс согтууруулах ундааны хууль бус бизнесийн талбарыг гартаа авахын төлөө Итали, Ирланд гаралтай гангстеруудын хооронд ширүүн тэмцэл өрнөжээ. Эцэст нь АНУ-ыг газар зүйн байршлаар нь 27 дүүрэгт хуваан тухайлбал, Нью-Йоркийг Сальваторе Маранзаногийн Коза нострагийн бүлэг, Чикагог Итали гаралтай Аль Капоны бүлэг, Флоридаг Мейер Лански бүлэг гэхчлэн хуваан авч согтууруулах ундаа борлуулан энэхүү хууль бус наймаанаас ихээхэн хөрөнгөжжээ.

1988 онд **Мансууруулах болон сэтгэцэд гаж нөлөө үзүүлэх бодисын хууль бус наймааны эсрэг НҮБ-ын Конвенц** болох Венийн конвенц батлагдан гарсан бөгөөд уг конвенцид анх удаа **“мөнгө угаах”** нэр томъёог албан ёсоор ашигласан төдийгүй мөнгө угаах ажиллагааг гэмт хэрэгт тооцох тухай тайлбарыг ч хийсэн байна.

Ийнхүү 1920-д оны үед АНУ-д **“мөнгө угаах”** гэдэг нэр томъёолол сонгодог хэлбэрээр анхлан гарч ирсэн бөгөөд 1988 онд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгийг хууль ёсны болгоход чиглэсэн үйл ажиллагааг үйлдлийн аргаар нь **“мөнгө угаах”** гэж олон улсад албан ёсоор нэрлэх болсон байна.

2000 онд **Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Палермогийн Конвенц** батлагдсан бөгөөд энэхүү конвенцид **“мөнгө угаах гэмт хэрэг”, “суурь гэмт хэрэг”, “хууль бус орлого”**-ын тухай нарийвчилсан тайлбар тодорхойлолтыг өгсөн.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 23 дугаар зүйлд: “Гэмт хэрэг үйлдэх замаар олсон орлогыг угаах буюу мөнгө угаах гэмт хэрэг гэдгийг Палермогийн конвенцид заасан агуулгаар тодорхойлсон байх ба харин гэмт хэрэг үйлдэх

замаар шууд буюу шууд бусаар олсон, авсан аливаа эд хөрөнгийг “гэмт хэргээс олсон орлого” гэж ойлгоно¹ хэмээн тодорхойлжээ.

Өөрөөр хэлбэл, аливаа гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус орлогыг хууль ёсны болгоход чиглэсэн үйл ажиллагааг олон улсын хэмжээнд албан ёсоор “**мөнгө угаах гэмт хэрэг**”, харин хууль бус орлого олохын тулд үйлдсэн гэмт хэргийг мөнгө угаах гэмт хэргийн “**суурь буюу үндсэн гэмт хэрэг**”-т тооцож байгаа нь илэрхий байна.

Ийнхүү олон улсын эрх зүйн салбарт “мөнгө угаах” нэр томъёог албан ёсоор хэрэглэж эхэлсэн төдийгүй мөнгө угаах болон суурь гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, ялгаатай тал болон “хууль бус орлого” хэмээх нэр томъёоны талаар ч нарийвчилсан тодорхойлолтууд өгч тайлбарлах болсноор мөнгө угаах гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх нэгдмэл ойлголтыг олон улсын эрх зүйн түвшинд бүрдүүлсэн гэж үзэх үндэстэй байна.

Манай улс 2003 онд Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенцид, 2006 онд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Палермогийн конвенцид нэгдэн орж, 2006 оны 07 дугаар сарын 8-ны өдөр **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай** бие даасан хууль батлан мөрдөж эхэлсэн нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны шинэ эхлэл болсон юм. Энэ хуулийн 3.1.1 дэх хэсэгт: “Мөнгө угаах гэж хууль бусаар олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж, түүний гарал үүслийг нуун далдалж уг эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулахыг хэлнэ” гэж тодорхойлсон ба 2013 онд мөн хуулийг шинэчлэн боловсруулсан нь өнөө хүчин төгөлдөр үйлчилж байна.

Үндэсний эрдэмтэн, судлаачдын хувьд мөнгө угаах гэдэг нь хууль бусаар олсон орлого, эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж, түүний гарал үүслийг нуун далдалж, уг хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулах өргөн хүрээтэй шат дамжлага бүхий үйл ажиллагаа гэж тодорхойлсон нь үндсэндээ олон улсын хэм хэмжээнд заасан томъёололтой агуулгын хувьд нийцэж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас улс орны эдийн засагт ихээхэн хэмжээний хохирол учирдаг, харин хор уршиг нь нийгмийн гишүүн бүрд учирч байдгаараа онцлогтой.

¹ Монгол Улсын олон улсын гэрээ. Авлигын эсрэг НҮБ-ын конвекц Уб., 2005. 8, 26 дахь тал

Хоёр:Өнөөгийн нөхцөл байдал

Нэгдсэн Үндэсний байгууллагын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас 2022 оны жилийн эцсээр гаргасан судалгаагаар жил бүр дэлхийн хэмжээнд ойролцоогоор 800-2 их наяд ам.доллар угааж байгаа нь улс орнуудын засгийн газруудын хувьд тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.

Манай улсын хувьд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “Монгол Улсын иргэн нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй”, Иргэний хуулийн 89 дүгээр зүйлд: “Эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах замаар эзэмшил үүснэ” гэж иргэний өмчлөх эрхийг баталгаажуулан хуульчилсан ч сүүлийн үед мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх нь жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна.

Мөнгө угаах гэмт хэргийг Цагдаа, Тагнуул, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс, газрууд өөрсдөө илрүүлсэн хэргийн хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа явуулан шалгаж байна.

Монгол улсын хэмжээнд 2019-2023 онд Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл “Мөнгө угаах”-д заасан нийт 162 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн хугацаагаар нь авч үзвэл 2019 онд 54, 2020 онд 27, 2021 онд 47, 2022 онд 12, 2023 онд 22² гэмт хэрэг бүртгэгджээ. Эдгээр гэмт хэргийн 14 буюу 8.6 хувийг АТГ, 148 буюу 91.4 хувийг цагдаагийн байгууллага шалгасан байна. Цагдаагийн байгууллага нийт бүртгэгдсэн хэргийг шалгаж байгаа нь дагнасан чиг үүргийн газар, хэлтэстэйгээс гадна, Эрүүгийн хууль болон Улсын ерөнхий прокурорын газраас баталсан хэргийн харьяалалтай шууд холбоо хамааралтай юм.


Авлигатай тэмцэх газраас 2023 онд бүртгэгдэж, шалгагдсан нийт гэмт хэргийн 57.2 хувь нь Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 13.3 хувь нь Хахууль авах, 7.4 хувь нь Хахууль өгөх, 1.5 хувь Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, 3.1 хувь нь Үндэслэлгүйгээр хөрөнгөжих, 2.4 хувь нь Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах, 2.5 хувь нь Мөнгө угаах гэмт хэрэг³ тус тус шалгагдсан.

Нийт учирсан хохирлын 28.2хувийг нөхөн төлүүлж, хахуулийн 8,680,730,871 төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан.

² Мөнгө угаах үйл явц, хэргийн гаралт. www.fatf-gafi.org


³ Авлигатай тэмцэх газрын гэмт хэргийн тоон мэдээлэл. Уб., 2024. 5 дахь тал

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт



Дэлхий нийтэд тархсан Ковид халдварт өвчинтэй холбоотойгоор нийт бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 онд өмнөх оноос 50.0 хувиар, 2022 онд 74.5 хувиар буурсан бол, 2021 онд 74.1 хувиар, 2023 онд 83.3 хувиар өссөн. Бүртгэгдсэн гэмт хэргийн **152** буюу 93.8 хувь нь хэрэг бүртгэлтийн хэрэг байгаа бөгөөд үүнээс 149 буюу 92.0 хувь нь хөнгөн, 13 буюу 8.0 хувь нь хүнд гэмт хэрэг, 55 буюу 34.0 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг (2019-2023 он)



Цагдаагийн байгууллагад Мөнгө угаах гэмт хэргийн улмаас 2019 онд 9, 2020 онд 10, 2021 онд 8, 2022 онд 5, 2023 онд 6 нийт 38 иргэн, 3 хуулийн этгээдэд 106.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан бөгөөд эдгээрийн:


- 2019 онд 2559820000 төгрөгийн,
- 2020 онд 99347670400 төгрөгийн,
- 2021 онд 4699966200 төгрөгийн,

- 2022 онд 72090000 төгрөгийн,
- 2023 онд 265065600 төгрөгийн хохирол учруулсан байна.

Дээрх хохирлоос 2019 онд 2558050000 төгрөгийн буюу нийт хохирлын 99.9 хувийг, 2020 онд 5890000 төгрөгийг, 2021 онд 4003061200 төгрөгийн буюу 85.2 хувийг, 2022 онд 10210000 төгрөгийн буюу 14.2 хувийг, 2023 онд 2865600 буюу 1.1 хувийн хохирлыг тус тус нөхөн төлүүлсэн юм. Өөрөөр хэлбэл, 6.5 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлтийн хувь 6.1 хувь байна.

2019 онд 1599831320 төгрөгийн, 2023 онд 4000000000 төгрөгийн буюу 5.5 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн.

Учирсан хохирол, сая төгрөг (2019-2023 он)



Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2019 онд 32, 2020 онд 9, 2021 онд 35, 2022 онд 6, 2023 онд 22 хүн буюу Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэрэгт нийт **93** хүнийг яллагдагчаар татагдан шалгагдсан бөгөөд тэдгээрийн 64 буюу 68.9 хувь нь нийслэлд, 29 буюу 31.1 хувь нь орон нутагт бүртгэгдэн шалгагдсан.


Хууль сахиулах байгууллагууд мөнгө угаах гэмт хэргийг суурь гэмт хэрэгтэй хамт мөрдөн шалгаж байгаа ч ийнхүү шалгах хугацаанд Монгол Улс эрүүгийн хэрэгт өргөн хүрээнд өршөөл үзүүлж буй нь мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд хүндрэл учруулж байна. Монгол Улсын тухайд мөнгө угаах гэмт хэргийн өндөр эрсдэлтэй байгаль орчны эсрэг гэмт хэрэг, татвараас зайлсхийх гэмт хэрэгт мөнгө угаах үйл ажиллагааг мөрдөн шалгах ажиллагаа хангалтгүй”⁴ гэж дүгнэжээ.

Эдгээр он жилүүдэд мөнгө угаах гэмт хэрэг цөөн шийдэгдсэн нь манай улсын хувьд шинэ тутамд тооцогдох мөнгө угаах гэмт хэргийн талаарх мэдлэг

⁴ Asia/Pacific Group on Money Laundering (APG). Anti-money laundering and counter-terrorist financing measures: Mongolia. Mutual Evaluation Report. September 2017. pp. 4, 8, 49, 52, 58

хууль хэрэглэгч болон хэрэгжүүлэгчдийн аль алинд нь бага, тэр дундаа тухайн гэмт хэргийг мөрдөн шалгаж, хянан шийдвэрлэх практик байхгүй байсантай холбоотой гэж үзэж байна.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн судлаачид орчин үеийн судалгааны аргын нэг “Системийн динамик загвар”⁵-ыг ашиглан мөнгө угаах гэмт хэргийн төлөвийг “Вензим” программаар регрессийн шинжилгээ хийхэд манай улсад 2040 он хүртэл мөнгө угаах гэмт хэрэг нь санхүүгийн болон эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан жил тутам 5 хувиар өсөх үр дүн гарчээ⁶.



Энэхүү судалгаагаар манай улсын 10000 хүн ам тутамд мөнгө угаах гэмт хэрэг 2010 онд 0.06, 2020 онд 0.17 тус тус байсан бол, 2040 он гэхэд 0.41 гэсэн үзүүлэлтээр өсөх бөгөөд үүнд хүн амын өсөлт, төсвийн болон санхүү, крипто зах зээлийн тэлэлт шууд нөлөөлөхөөр байна. Өөрөөр хэлбэл, мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг салбар бүрд зохион байгуулах, үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах тогтолцоо, хүний нөөцийг бэлтгэх шаардлагатай болох нь тооцоолол судалгаанаас харагдаж байна.

Гурав: Тулгамдаж буй зарим асуудал, шийдвэрлэх арга замын талаар

1. Мөнгө угаах гэмт хэргийн тухайд гэмт хэрэг үйлдэж олсон орлого гэдгийг мэдсээр байж авсан, эзэмшсэн, ашигласан, нуун далдалсан өөрчилсөн, шилжүүлсэн, захиран зарцуулсан л бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан. Гэтэл манай улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.4 дүгээр

⁵ Ж.Форестер, Систем динамик, 1980, 125 дахь тал

⁶ Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн системийн динамик загвар. 2022. Шинжлэх ухаан, технологийн их сургууль

зүйлд: “Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсэн дагуу суурь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа мөнгө угаах гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэх боломж бүрдэхээр зохицуулалттай байгаа билээ. Өөрөөр хэлбэл, суурь гэмт хэргийг нотлолгүйгээр, мөнгө угаах гэмт хэргийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг хууль бус эсэхийг тогтоолгүйгээр мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэх боломжгүй байна. Тиймээс зарим тохиолдолд мөнгө угаах гэмт хэргээр зүйлчилсэн хэргийн суурь гэмт хэргийг бүрэн дүүрэн тогтоогоогүй учир мөнгө угаасан гэж үзэх боломжгүй гэж шүүхээс үзэж хэрэг мөрдөн байцаалтад буцаах тохиолдол ч байна.

Энэ нь нэг талаараа аливаа иргэн, хуулийн этгээдийг “хилсдүүлэн гүтгэх”-ээс урьдчилан сэргийлж буй чухал зарчмуудын нэг ч нөгөө талаараа мөнгө угаах цаашлаад бусад санхүүгийн төрлийн гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэхэд хүндрэл учруулж байна.

2. Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 6.1.3-т зааснаар Банк нь Улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийгдсэн гүйлгээнд тусгайлан хяналт тавих, мөн хуулийн 3.1.5-д “Улс төрд нөлөө бүхий этгээд” гэдгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд байна гээд тэдгээр нь улс төрийн тодорхой “албан тушаал эрхэлж байсан” болон “эрхэлж байгаа хүн”, эсхүл түүнтэй “хамаарал бүхий этгээд” гэж тодорхойлсон байдаг. Гол асуудал нь:

Арилжааны банкнуудын хувьд хуульд заасны дагуу Улс төрд нөлөө бүхий этгээдийн хамаарал бүхий этгээдийг нэг бүрчлэн олж тодорхойлох эрх зүйн болон үйл ажиллагааны хувьд боломжгүй юм. Мөн тухайн этгээдтэй “хамаарал бүхий этгээд” нь насан туршдаа улс төрд нөлөө бүхий этгээд гэдгээр тусгайлан хянагдах шаардлагатай болж байна.

Улс төрд нөлөө бүхий этгээдэд хяналт тавих тухай заалтыг тодорхой болгох зорилгоор Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд шаардлагатай өөрчлөлтийг оруулах, эсвэл Монголбанкны Санхүүгийн Мэдээллийн Алба, Авлигатай тэмцэх газар хамтран “Улс төрд нөлөө бүхий этгээдийн мэдээллийн нэгдсэн сан”-г үүсгэж, мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд тус санд нэвтрэх талаар зохих арга хэмжээг авах,

3. Хүн төрөлхтөн цахим эрин үе рүү шилжсэнтэй холбогдуулан нийгмийн хөгжлийн сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг, тэдгээрийг үйлдэгчид нийгмийн хөгжлийг даган хувьсан өөрчлөгдөж, цахим орчныг ашиглан гэмт хэрэг үйлдэх нь өнөөгийн нийгэмд тулгамдаж буй асуудлуудын нэг болон хувирч байна.

Тиймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зэвсэг болгон ашиглаж болох технологийн дэвшлийн нэг нь хиймэл оюун ухааны технологийг нэвтрүүлэн үйл ажиллагаандаа ашиглах шаардлагатай хэмээн үзэж байна.

4. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны салшгүй нэг хэсэг болох хөрөнгө буцаах ажиллагааг хууль эрх зүйн түвшин явуулах нь нэн тэргүүний чухал асуудлуудын нэг болоод байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хууль бус орлогыг татан төвлөрүүлэхэд чиглэсэн Хөрөнгийн менежментийн тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд тухайн хуулийн төслийг батлуулан үйл ажиллагаанд нэвтрүүлэх шаардлага үүсэж байна.

Дүгнэлт:

Манай улс мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхдээ мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх онол, арга зүйн үндсийг олон улсын туршлагад тулгуурлан судалж, үндэсний эрх зүйн салбарт нэвтрүүлж эхэлснээс хойш багагүй цаг хугацаа өнгөрсөн нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны тулгамдсан асуудлуудыг нээн илрүүлж, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрэлхийлэх нь нэн чухал болохыг харуулж байна.

Өнөөдөр зарим улс орнуудад гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор гэмт хэрэгтэй тэмцэх уламжлалт арга барилын зэрэгцээ авлига, албан тушаалын болон мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэхэд хиймэл оюун ухааныг хослуулан ашиглаж байна. Тухайлбал, Зарим улс оронд ухаалаг хотын технологи нэвтрүүлэх, агаарын тандалт, газар зүйн өгөгдлийн шинжилгээ, биометрийн баталгаажуулалт, нүүр царай таних систем ашиглах, дулаан мэдрэгч, газар зүйн байршлыг тогтоох, мэдээлэлд суурилсан урьдчилсан таамаглах аналитик хийх зэрэгт хиймэл оюун ухаант технологийг өргөнөөр ашиглан амжилт гаргаж байгаа бөгөөд эдгээрт АНУ-ын Axon компани бүтээсэн энгэрийн камер, яриа таних болон бичиж авах болон Stoplift компанийн бүтээсэн ShotSpotter галт зэвсэг илрүүлэх программ, дижитал ул мөр илрүүлэх, харьцуулах, Канадын Magnet Forensics компанийн бүтээсэн Magnet AXIOM нэртэй дижитал мөрдөлтийн платформ зэргийг өргөнөөр ашиглаж байна.

Манай улсын хувьд мөнгө угаах гэмт хэрэг нь харьцангуй шинэ төрлийн гэмт хэрэгт тооцогдож 2000 оны эхэн үед манай улсад бохир мөнгө угаагдах эрсдэлт нөхцөл байдал үүссэн байна гэж эрдэмтэн, судлаачид дүгнэж байсан бол, бидний хийсэн сүүлийн 5 жилийн судалгаагаар мөнгө угаах гэмт хэргийн тархалт, шилжилт хөдөлгөөн зэргээс үзэхэд, мөнгө угаах гэмт хэрэг далд хэлбэртэй үйлдэгдэж байна.

Иймд авлига, албан тушаалын болон мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд эрх зүйн орчин, түүний удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, шинэ шатанд гаргах, олон улсын туршлагыг нэвтрүүлэх, шинээр томилогдсон алба хаагч нарт чиглэсэн сургалт зохион байгуулах зэрэг цогц бодлого, арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлага бий болсон байна.

Ашигласан эх сурвалж:

- Монгол Улсын олон улсын гэрээ. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц. Уб., 2005,
- Мансууруулах болон сэтгэцэд гаж нөлөө үзүүлэх бодисын хууль бус наймааны эсрэг НҮБ-ын Конвенц. 1988,
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Палермогийн Конвенц. 2000,
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль. Уб., 2006,
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль//Төрийн мэдээлэл. Уб., 2017,
- Asia/Pacific Group on Money Laundering (APG). Anti-money laundering and counter-terrorist financing measures: Mongolia. Mutual Evaluation Report. September 2017. pp. 4, 8, 49, 52, 58
- Ж.Форестер, Систем динамик, 1980,
- Авлигатай тэмцэх газрын гэмт хэргийн тоон мэдээлэл. Уб., 2024,
- Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн системийн динамик загвар. 2022. Шинжлэх ухаан, технологийн их сургууль,
- <https://police.gov.mn/as/article/3>



О.ОТГОНТУЯА

*Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны
сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хууль зүйн
доктор (Ph.D), цагдаагийн хошууч*

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬ БУСААР ХӨРӨНГӨЖИХ ГЭМТ ХЭРГИЙГ ТОДОРХОЙЛЖ БАЙСАН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

Хураангуй: Монгол Улс авлигын эсрэг конвенцод 2005 онд нэгдэн орж, соёрхон баталснаар үндэсний хууль тогтоомжийг олон улсын конвенцод нийцүүлэх Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж 2006 онд Авлигын эсрэг хуулийг баталж, өнөөг хүртэл нийгэм, эдийн засаг, эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлтэй уялдуулж 23 удаа нэмэлт өөрчлөлт оруулж олон талд авлигатай тэмцэж ирсэн.

Манай улс хууль бусаар хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцон Эрүүгийн эрх зүйн хамгаалалтыг 2012 оноос Эрүүгийн хуульд хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжид хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийг дараах үечлэлээр түүхчлэх аргаар судаллаа.

1. Эртний үеийн эх сурвалж буюу 1926 оноос өмнөх үеийн эрх зүйн зохицуулалтын уламжлал
2. Шинэ үе буюу 1926 оноос 1992 он хүртэлх үеийн эрх зүйн зохицуулалтын уламжлал
3. 1992 оноос одоог хүртэлх буюу 2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалтын уламжлал.

Abstract: Mongolia joined and ratified the Convention against Corruption in

2005, fulfilling its constitutional obligation to bring national legislation into line with international conventions. In 2006, the Anti-Corruption Law was adopted, and since then, it has been amended 23 times in line with social, economic, and legal changes and reforms, and has been fighting corruption on many fronts.

The crime of illegal enrichment in the Criminal Code of Mongolia was studied using the following historical periodization method.

1. Ancient sources or legal regulatory traditions before 1926
2. New period or legal regulatory traditions from 1926 to 1992
3. Criminal Code regulatory traditions from 1992 to the present or 2002.

Түлхүүг үгс: Эрүүгийн хууль тогтоомж, эртний эх сурвалж, шинэ үеийн хууль тогтоомж, хууль бусаар хөрөнгөжих гэмт хэрэг.

Keywords: Criminal legislation, ancient sources, modern legal frameworks, the crime of illicit enrichment.

ҮНДСЭН ХЭСЭГ:

Манай улсын эрдэмтэн, судлаачид¹ түүхэн хууль тогтоомжуудыг судлахдаа тухайн цаг үеийн нөхцөл байдал, төрийн дэглэм, хууль тогтоомжийн хөгжил зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан

- Монгол нутагт төр үүссэн цагаас хойш XIII зууны эхэн үе (Их Монгол Улс оршин тогтнож байсан);
 - XIII зууны сүүлээс Монгол оронд Үндэсний ардчилсан хувьсгал ялсан 1921 он хүртэлх үе;
 - 1921 оноос 1990-ээд оны үе;
 - Ардчилсан шинэчлэл өрнөсөн 1990 оноос хойших үе гэсэн үечлэлд ихэвчлэн хувааж үздэг ба хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийн талаар Эрүүгийн хуульд хэрхэн хуульчилж байсан талаар
1. Эртний үеийн эх сурвалж буюу 1926 оноос өмнөх үеийн эрх зүйн зохицуулалтын уламжлал
 2. Шинэ үе буюу 1926 оноос 1992 он хүртэлх үеийн эрх зүйн зохицуулалтын уламжлал

¹ Лүндээжанцан, Д. Болдбаатар, Ж. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб, 1997. 9 дэх тал.

3. 1992 оноос одоог хүртэлх буюу 2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалтын уламжлал гэсэн үечлэлийн хүрээнд судаллаа.

Эртний цөийн эх сурвалж буюу 1926 оноос өмнөх цөийн эрх зүйн зохицуулалтын уламжлал:

Монголын хууль цаазын эртний эх сурвалж болох түүхэн товчоон болох Монголыг нууц товчоо, Халх журам, Зарлигаар тогтоосон хууль зүйн бичиг зэрэг эртний бичигт хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийн талаар зохицуулж байсан байна.

Эрдэмтэн судлаач Х.Пэрлээ "... нууц товчоонд үлдсэн хууль цаазын Чингис хааны жаса хууль ба Өгөөдэй хааны үеийн хууль цаазыг сэргээн мэдэхэд сурвалж болж байсан ба²

Албан тушаалын гэмт хэрэгт холбогдож болох төрд алба хашиж буй хүмүүсийн биеэ авч явахтай холбоотой зарим заалт байна. Үүнд:

1. Түмтийн ноёд, мянгатын ноёд хийгээд зуутын ноёд он бүрийн эрх, эцэст нь хүрэлцэн ирэлцэж Чингис хааны билгийг хичээнгүйлэн сонсоод буцваас цэрэг ангиа ноёлж чадна. Хэрэв орд харшдаа саатаж, билиг сургуулийг эс сонсвоос цээл уснаа шидсэн чулуу, инж Хулснаа харвасан сум мэтээр мөр сүүдэргүй арилах болой. Ийм удирдагч болбоос зохихгүй.
2. Хэн ч атугай хэрэв өтөрхөн сагсарч олон хаадын сонгуульгүйгээр өөрийн эрх сүрд түшиглэн байж хаан суусан байвал түүнийг өчүүхэн ч хайр найргүй алж орхино.
3. Ямар нэгэн тушаалын хүн өөрийн дураар тушаалаа шилжүүлбэл цаазална.
4. Ноёдыг хаанаас өөр хүнд учир мэдүүлж болохгүй, хэрэв мэдүүлбэл дорд цаазлах.
5. Гурван хүн ам авалцан зөвшөөрсөн хэргийг хаа ч өгүүлж баймой. Тийм бус болбоос баталж болохгүй³ зэргээр хуульчилсан нь түүхэн эх сурвалжид дурджээ.

² Пэрлээ, Х. Нууц товчоонд үлдсэн хууль цаазын зарим зүйл "Монгол судлал". Уб., 1962. 3 дугаар боть. 15 дугаар дэвтэр.

³ Эзэн Богд Чингисийн их засаг. Уб., 1995. 36 дахь тал.

Доктор, профессор Ой.Дагвадоржийн бүтээлд “... Элч засгийн хуулиар далайлган хүн амаас хүнсний бүтээгдэхүүн, адуу ба тэжээл бордоо шаардахыг хориглосугай” гэсэн зарлигийг албан тушаалын эрх мэдлээ урвуулах⁴, ... нэр түшмэлээ хайрлаж, бүрэлгэх давамгайлахуйг зогсоо ...” гэснийг төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх зүйлд хамаарах талаар тэмдэглэсэн байна⁵.

Чингис хааны залгамжлагчдын дотроос Хубилай хааны төр, төр хууль цааз түүхэнд чухал байр суурь эзэлдэг⁶ ба Чин гүрний үед “Чжи Юань Син-гэ” хуулийг батлах хүртэл Хятад Улсын хууль цаазыг баримтлан мөрдөж байсныг Юань-иш буюу Их Юань Улсын сударт дурдсан ба тус судрын Удирдлагын тогтолцоо гэсэн 3 дугаар хэсэгт “Олиггүй муу хүнийг албанд томилуулах санал оруулбал шийтгэл хүлээнэ. Хахууль авах, өөртөө хөшөө дурсгал босгуулах, гуйлт гаргахыг хориглоно”⁷ гэж заасан нь албан тушаалаа урвуулан ашиглаж хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийн агуулгыг тогтоосон, улс орноо хамгаалсан ач холбогдол бүхий үйл явц байсан гэж дүгнэж болохоор байна.

Юань ши сударт 20 хэсэгтэй Юань Улсын хууль тогтоомжийн агуулгыг тодорхойлон Шүүх ажиллагаа гэсэн 13 дугаар хэсэгт “оршин суугчид шүүхийн бүхий л ажил хэргийг шүүхэд хандах эрхтэй. Тэд эн тэргүүнд орон нутгийн зохих эрх баригчдад хандвал зохих бөгөөд тэндхийн түшмэл албатууд хээл хахуульд өртсөнөөс бусад тохиолдолд шууд дээд шатны эрх баригчдад хандаж үл болно. Улмаар муж хязгаарын удирдлага, тэндээсээ тамгын газарт, эцэст нь эзэн хаанд уг хэрэг шилжин шийдэгдэж болно”⁸ гэж төрийн үйл ажиллагааны өнөөгийн мерит зарчмыг эрхлэн явуулах анхдагч үзлийг тогтоосон байна.

ХҮИХ зууны эхэн үеийн Монголын төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох “Халх журам”-ыг 1709-1795 оны хооронд халхын хаад, ноёд, төр, шашны томоохон зүтгэлтнүүд бүгд 20 гаруй удаа янз бүрийн газар цуглаж хэлэлцэн тогтоосон⁹ эрхийн акт юм. Уг хууль нь Манжид эзлэгдсэнээс хойш 18 жилийн дараа гарсан учир Монгол орон, Манж гүрний төрийн бодлого, хүний хөгжил,

⁴ Дагвадорж, Ой. Төрийн сүлд өршөө XII-XIV зууны Монголын хаадын зарлигсын товчоон. I боть. Уб., 2011. 116 дахь тал.

⁵ Дагвадорж, Ой. Төрийн сүлд өршөө XII-XIV зууны Монголын хаадын зарлигсын товчоон. II боть. Уб., 2011. 227 дахь тал.

⁶ Адьяабазар, Д. Монгол Улсад залилан мэхлэх гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийн тулгамдсан асуудал. Нэг сэдэвт бүтээл. Уб., 2004. 18 дахь тал.

⁷ Рязановский, В.А. Монголчуудын хууль, цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм Их засаг хууль. Уб., 2000. 119 дэх тал.

⁸ Рязановский, В.А. Монголчуудын хууль, цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм Их засаг хууль. Уб., 2000. 126 дахь тал.

⁹ Жалан-Аажав С. Халх журам. Уб., 1995. 7 дахь тал.

Монгол улсын эррхийн хууль тогтоомжид хууль бусаар хөрөнгөжиж гэмт хэргийг тодорхойлж байсан тэрхэн уламжлал

эрх зүйн зохицуулалт зэргийн түүхэн нөхцөл байдалд нийцүүлэн тогтоосон. Уг хуулиар хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийн талаар тодорхойлжээ. Үүнд, элч унаагаар хазайх, алагчлах мэт явсан байвал шилдэг сайн хоёр хониор торгоно /Энэ өнөөгийн ойлголтоор албан ажлаар машинаар яваа хүн хувийн гэргээ бүтээх, өөрт нь ая тал засдаг айлуудаар орсон хүнийг торгох асуудал юм/, өр зарга шүүсэн ноёд гоёчилон хэргийг шударга бусаар шийдвэл нэг тэмээ тэргүүлэн таван бодоор торгоно, ноёдын гэр нэгжээд юм гарах ахул хадаг, цагаан морь ноёнд барь гэсэн зохицуулалттай байжээ.

Улаан хацарт 1820-1913 он хүртэл хугацаа буюу 93 жилийн дотор Шавийн яаманд шүүхийн журмаар таслан шийдвэрлэсэн эрүү, иргэн, захиргааны шинж чанартай хэргүүдийн бүртгэл буюу эмхэтгэл бөгөөд Халх журам хуулийг хэрхэн хэрэгжиж байгааг харуулсан хууль юм. Улаан хацартад:

1. Улаанаар албанд яваад зам муруйж төрлийн хүнд очиж явсан хаалгач Жамбыг тушаалаас байлгаж буюу огцруулж шүдлэн болон хязаалан насны есөн үхэр адуугаар нэгэн есөн анзуу буюу торгуулиар ял торгож шийтгэх
2. Сангай аймгийн дуганд хунгад нүүж мэдүүлэг гаргуулж авсан ба зарлигаар буюу дур мэдэн отог дор цай татварласан мөн аймгийн гэсгүй Наваанрэгзэн, Жүрмээ нарыг цаг тушаалаас огцруулж таван малаар торгож шийтгэнэ албан тушаалтны хууль бус үйлдэлд гэм асууж байсан байна.

Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйн бичигт албан хэргээр харьяат ард, уул газрын идэх юм ба баяр наадам ба зовлонгийн учир өгсөн бэлэг зэрэг бага сага ёсны юм авч болох ба бэлэг сэлтэд ял шийтгэхгүй бөгөөд хахуулаас ялгаатай байдлыг энэ цаг үед тогтоосон түүхэн уламжлалтай байна.

Шинэ ца буюу 1926 оноос 1992 он хүртэлх цөийн эрх зүйн зохицуулалтын уламжлал:

1926 оны Шүүх цаазын бичиг: 1926 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Нэгдүгээр дэвтрийг, 1926 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Улсын III дугаар хурлаар баталж¹⁰ Монгол Улс Үндсэн хуульт байгуулалд шилжсэнээр эрүүгийн эрх зүйн суурь бүрэлдсэн гэж дүгнэж болно.

¹⁰ Адьяабазар, Д. Монгол Улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжилт. I дэвтэр. Уб., 1998. 7 дахь тал.

Энэ хуулийн тусгай ангийн 21 дүгээр бүлэгт албан тушаалын гэмт хэргийг тусад нь зүйлчилсэн нь ба нэг удаадаа донгодох, 25-1200 хүртэл төгрөгөөр торгох, 14 өдрөөс 10 жил хүртэл хугацаагаар гянданд хорих ялыг оногдуулдаг байсан нь уг заалтын гол онцлог юм. Тухайлбал, 147 дугаар зүйлд Аливаа албаны хүн эрх тушаалдаа эрдэж албан яамны зэрэг газрын хэрэг явдал дор саатал, боогдол болгох ба ард олны амгалан тайван байдлыг сахих хууль дүрмийг зөрчих ба бусдын эрх чөлөө ба эд хөрөнгө дор халдах, ашгийг хичээж цааз хуулийг зөрчих, аливаа хүнийг айлган сүрдүүлж дарлах аваас 1 сараас 2 жил хүртэл гянданд хорих буюу 25-1200 төгрөг хүртэл торговол зохино, 149 дүгээр зүйлд тус хуулийн 147 дугаар зүйлд заасан гэмт явдлыг үйлдэхдээ хүчин буюу зэвсэг хэрэглэх зэргээр зовоож дарласан зүйл буй аваас 1-3 жил хүртэл гянданд хорино, 150 дугаар зүйлд Албан тушаалтан хэргийг тушаалын эрх хэмжээний ёсоор үл гүйцэтгэвээс 14 өдрөөс 6 сар хүртэл гянданд хорих буюу 25-300 хүртэл төгрөгөөр торгоно. Хэрвээ онц хүндэтгэх учир буй аваас 1-3 жил хүртэл гянданд хоривоос зохино, 154 дүгээр зүйлд Албан тушаалтан аливаа задруулж үл зохих зүйлийг бусад дор задруулбаас 1 жил хүртэл гянданд хорино, 155 дугаар зүйлд Аливаа албан хаагчид ашгийг хичээж ямагт худалдаа арилжааны зэрэг албан тушаалтан дор үл нийцэх ажил явдал үйлдвээс 3 сар хүртэл гяндан хорих буюу 150 төгрөг хүртэл торговол зохино.

1929 оны Шүүх цаазын бичиг: 1926 оны Шүүх цаазын бичгээс гэмт хэрэг, ялын тухай асуудлын онолын үндэслэлийг илүү боловсронгуй болгох, нийгэмд аюултай гэмт явдлын төрөл, хэлбэрийг аль болох бүрэн тусгах зорилгоор өөрчлөлтийг оруулж 1929 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр 30 бүлэг, 237 зүйлтэй баталсан¹¹.

Нийгмийн хөгжлийн зүй тогтлын дагуу гарсан өөрчлөлттэй холбоотойгоор 1929 оны Шүүх цаазын бичигт хэд хэдэн удаа төрийн үйл ажиллагааны ёс зүйг нэмэгдүүлж, хариуцлага тооцохтой холбоотой өөрчлөлт оруулж эрх зүйн актыг баталсан. Тухайлбал, 1932 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Засгийн газрын хэрэг эрхлэх товчооноос Монгол Ард Улсын оньсон хүчний тээврийн ажилчдыг бүртгэх ба мөн ажиллах шинэ хүчин бэлтгэх хийгээд оньсон хүчний тээврийн хариуцлагын тухай тогтоол, 1932 оны 02 дугаар сарын 16-ны өдөр Харилцаа холбоонд санаатай саад хийх явдалтай тэмцэх тухай тогтоол, 1934 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Төр шашныг тусгаарласан тухай хууль дүрэм зөрчих гэж өөрчлөн найруулах тухай тогтоол.

¹¹ Содовсүрэн, Б. БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. Уб., 1971.

Шүүх цаазын бичгийн тусгай ангийн 20 дугаар бүлэгт Албан тушаалын гэмт хэргийг зүйлчилж хөрөнгө хураах, 25-1200 төгрөг хүртэл торгох, 100 хоног хүртэл хорихгүйгээр албадан ажил хийлгэх, 1 сараас 10 жил хүртэл хорих, онц хүндэтгэх учир шалтгаан байвал буудан алах ялыг оноож албан тушаалын гэмт хэргийн нийгмийн хор аюул ялгамжтай тусгасан гэж дүгнэж болохоор байна. Тухайлбал:

156 дугаар зүйлд Аливаа албан тушаалтан албаны буюу ард олноор байгуулсан газраас тусгай тушаасан ёсоор аливаа хэрэг явдлыг гүйцэтгэж буй этгээд өөрийн эрхлэн хадгалснаас зохих мөнгө, зоосын зэрэг аливаа үнэ бүхий зүйлүүд буюу хөрөнгө хогшлыг хувь дор ангилах зэргээр сүйтгэвээс 6 сараас 3 жил хүртэл хоримой, 157 дугаар зүйлд 156 дугаар зүйлд заасан албан тушаалтны зэрэг хүмүүс онц үнэ бүхий чухал зүйлийг тийнхүү ашиглах зэргээр сүйтгэвээс 2 жилээс доош бус хорьж хөрөнгийг албан хурааваас зохимуй.

1934 оны Шүүх цаазын бичиг: Шүүх цаазын ерөнхий ангийг 1934 оны 05 дугаар сарын 24-ний өдөр, тусгай ангийг 1934 оны 10 дугаар сарын 08-ны өдөр 15 бүлэг, 174 зүйлтэйгээр ял шийтгэлийн зорилго, гэмт хэргийн бүрэлдэхүүний тухай үндсэн заалтыг тогтоосноороо 1929 оны Шүүх цаазын бичиг ялгаатайгаар баталсан байна.

Тус хуулийн 3 дугаар бүлгийн 94 дүгээр зүйлд Албан тушаалтнаас гагцхүү өөрийнхөө албан тушаалын байдлыг ашиглан далимдуулж хууль бус явдлуудыг үйлдэх, хэрэв түүний улсаас алба ба үйлдвэрийн газрын зүй зохистой бөгөөд журамтай ажлыг зөрчих буюу эд хөрөнгийн хохирол сүйтгэлийг учруулах эсхүл олон нийтийн журам байдал, хэн нэгэн ард иргэний эрх ашгийг зөрчих эсвээс хэрэв энэ ялуудыг ашгийг хичээж үйлдсэн ба албан тушаалын эрх буюу албан тушаалын байдлыг хортойгоор урвуулан хэрэглэсэн бол 6 сараас эхлэн 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино, 95 дугаар зүйлд Албан тушаалтнаас уул тушаалын эрх ба тусгайлан олгосон эрхээ, эрх хэмжээнээсээ илтэд хэтрүүлсэн бөгөөд тийнхүү хэтрүүлэхдээ энэхүү шүүх цаазын бичгийн 64 дүгээр зүйлд заасан байдал бүхий зүйлүүд байсан бол 6 сараас 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино, 100 дугаар зүйлд Албан тушаалтнаас ашгийг хичээж албаны баримт бүхий бичгүүдэд худал хуурмаг бүхий зүйлийг зориуд оруулан тэмдэглэсэн ба хуурамчаар зохион үйлдсэн хийгээд түүнчлэн бусдад шийтгэн олгох буюу худал хуурмаг зүйлийг данс

дэвтэрт бичсэн бол 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино, Албан тушаалын гэмт хэрэгт хөрөнгө хураах ялыг нэмэгдэл хэлбэрээр оноож байсан бөгөөд 6 сар хүртэл албадан ажил хийлгэх, 300 хүртэл төгрөгөөр торгох, 6 сараас 5 ил хүртэл хугацаагаар хорих, улсын эдийн засгийг хортой санаагаар ашигласан, үрэгдүүлсэн тохиолдолд ялын дээд хэмжээ буудан алах ялыг оноож байхаар тусгажээ.

Албан тушаалтан хээл хахууль авах гэмт хэргийг тусгай зүйл болгон хуульчилж байсан бол уг хуульд албан тушаалын гэмт хэрэгт багтаан зүйлчилжээ. Мөн шинээр албан тушаалтан хуурамчаар бичиг баримт үйлдэхийг гэмт хэрэгт тооцон ял оногдуулахаар заажээ.

Тус хуулиар анх удаа албан тушаалтан гэдгийг тодорхойлсон бөгөөд уг этгээдэд улсын албан үйлдвэрийн газруудад байнга буюу түр албан тушаалыг явуулж буй бөгөөд түүнчлэн аж ахуй ба захирах тушаал хийгээд үйлдвэрчний буюу улсын зорилго бодлогуудыг биелүүлэх явдалд хууль буюу уул дагаж явах дүрмээр даалгагдсан эрх үүргийг биелүүлэх, ийм олон нийтийн байгууллагад байнга буюу түр албан тушаалыг явуулж байгаа хэн нэгэн хүнийг ойлгох ба албан тушаалаа урвуулах, хэтрүүлэхийн ялгааг гаргаж ангилан тусгаснаараа өмнөх хуулиудаас давуу талтай боловч урвуулах, хэтрүүлэх гэх ойлголтыг тодорхойлон тусгаагүй юм.

1942 оны Эрүүгийн хууль: 1942 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр анх удаа Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн хууль нэртэйгээр 16 бүлэг, 219 зүйлтэйгээр¹² албан тушаалын гэмт хэрэгт ялын дээд хэмжээ болох буудан алах ялыг оноохоор заасан нь тухайн нийгмийн үед энэхүү гэмт хэрэг нийгмийн хор аюул ихтэй гэж үзсэн хэвээр байсны илрэл юм. Мөн өмнөх хуулиудад заасан ялуудыг хэвээр оноож байсны сацуу шинээр олон нийтийн өмнө буруушаах, удирдах тушаалыг эрхлэх эрх хасах ял оноож байжээ.

1961 оны Эрүүгийн хууль: 1961 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр баталж Албан тушаалтан гэх ойлголтыг улс олон нийтийн байгууллага, үйлдвэр аж ахуйн газруудад байнга буюу түр албан тушаал эрхэлж тэдгээр байгууллагад захирамжлах, зохион байгуулах буюу захиргаа аж ахуйн тодорхой албан үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүсийг ойлгохоор өөрчлөн найруулж, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулж байсан буудан алах ялыг хасаж албан тушаалтанд

¹² Адьяабазар, Д. Монгол Улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжилт. I дэвтэр. УБ., 1998. 102 дахь тал.

Монгол улсын эрүүгийн хууль тогтоолжид хууль бусаар хөрөнгөжиж гэмт хэргийг тодорхойлж байсан тэрхэн уламжлал

оноож байсан олон нийтийн өмнө буруушаах, тодорхой албан тушаал гүйцэтгэх эрх хасах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, хорих ял хэвээр хадгалагдаж иржээ.

1986 оны Эрүүгийн хууль: 1986 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 13 бүлэг, 301 зүйлтэйгээр шинэчлэн найруулсан ба тус хуулиар төрийн албан тушаалтад Засгийн төлөөлөгчид, Захирамжлан зохион байгуулах, захиргааны үүрэг гүйцэтгэх байгаа албан тушаалтан, Шууд утгаараа албан тушаалтанд хамаарах хүмүүс, Тусгайлан олгосон бүрэн эрхийн дагуу дээрх үүргийг гүйцэлтэж байгаа хүмүүсийг хамааруулж, албан тушаалын гэмт хэргийн бүрэлдэхүүний анх удаа тогтоож өгсөн. Үүнд, хэргийг тусгай субъект, албан тушаалтан үйлдэнэ, албан тушаалынхаа байдлыг ашиглах буюу албаны тодорхой үүргээ зөрчих замаар үйлдэнэ, төрийн аппаратын хэвийн үйл ажиллагаанд бага бус гэм хор учруулсан байна.

Тус хуульд албан тушаалтны үйл ажиллагаа нь албаны эрх ашигт харшилсан тохиолдолд албан тушаалын гэмт хэрэг болох ба энэ нь даалгагдсан ажил, үйлсийн эрх ашигт заавал хор хохирол учруулсан байх ба албаны нэр хүнд, нөлөөг ашиглаж үйлдсэн бол албан тушаалын гэмт хэрэгт тооцож болохгүй гэж хуульчилсан нь гэмт хэргийн бүрэлдэхүүний онолыг үндсийг тухайлан тодорхойлсон гэж дүгнэж болохоор байна

1992 оноос одоог хүртэлх буюу 2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалтын уламжлал:

2002 оны Эрүүгийн хууль: 31 бүлэг, 301 зүйлтэйгээр 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр баталсан албан тушаалын гэмт хэрэгт торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах ялыг олон нөхцөлтэйгөөр тогтоож өгсөн.

ДҮГНЭЛТ:

1. Монголын анхны төрт улс Хүннү гүрнээс эхлээд Чингис хааны нэгтгэн захирсан Монголын нэгдсэн төр улс болон түүний залгамжлагчдын үед мөрдөж байсан Их засаг, Их Юань гүрний нэвтэрхий хууль, Юань улсын хууль зүйлийн бичиг, Арван буянт номын цагаан түүх, Юань улсын хууль зүйлийн бичиг, Алтан хааны цааз бичиг, Монгол Ойрадын их цааз, Зарлигаар тогтоосон гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг, Халх журам, Хууль зүйлийн бичиг зэрэг хуулиудыг судлан үзэхэд албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцсээр иржээ.
2. 1934 оны Шүүх цаазын бичигт Албан тушаалтан хээл хахууль авах гэмт хэргийг тусгай зүйл болгон хуульчилж, анх удаа албан тушаалтан гэдгийг тодорхойлсон бөгөөд уг этгээдэд улсын албан үйлдвэрийн газруудад байнга буюу түр албан тушаалыг явуулж буй бөгөөд түүнчлэн аж ахуй ба захирах тушаал хийгээд үйлдвэрчний буюу улсын зорилго бодлогуудыг биелүүлэх явдалд хууль буюу уул дагаж явах дүрмээр даалгагдсан эрх үүргийг биелүүлэх, ийм олон нийтийн байгууллагад байнга буюу түр албан тушаалыг явуулж байгаа хэн нэгэн хүнийг ойлгох ба албан тушаалаа урвуулах, хэтрүүлэхийн ялгааг гаргаж ангилан тусгаснаараа өмнөх хуулиудаас давуу талтай боловч урвуулах, хэтрүүлэх гэх ойлголтыг тодорхойлон тусгаагүй байна.
3. 1942 оны Эрүүгийн хуульд албан тушаалын гэмт хэрэгт ялын дээд хэмжээ болох буудан алах ялыг оноохоор заасан нь тухайн нийгмийн үед энэхүү гэмт хэрэг нийгмийн хор аюул ихтэй гэж үзэж байжээ.
4. 1986 оны Эрүүгийн хуулиар төрийн албан тушаалтан, албан тушаалын гэмт хэргийг тодорхойлж албан тушаалтны үйл ажиллагаа нь албаны эрх ашигт харшилсан тохиолдолд албан тушаалын гэмт хэрэг болохоор өөрчлөн найруулсан нь нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээн дэх өөрчлөлттэй холбоотой юм.
5. Ялын төрлийн хувьд тухайн үеийн нийгэм, эдийн засаг, өөрчлөлт, үзэл санааны байдлаас хамаарч тухайн гэмт хэрэгт албан тушаалын гэмт хэрэг гэж үзэх, үзэхгүйгээс шалтгаалан нэмэгдэж, хасагдаж ирсэн. Ялын төрөл, хэмжээний хувьд 1929 оноос 1961 он хүртэл чангарч байсан нь ялын дээд хэмжээ буудан алах ялыг оноож байснаар илэрнэ. 1961 оны

Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжид хууль бусаар хөрөнгөжиж гэмт хэргийг тодорхойлж байсан тэрхэн уламжлал

Эрүүгийн хуулиар хасагдан хуульчлагдсан ба тусгайлан хууль бусаар хөрөнгөжих гэмт хэрэг хэмээн хуульчилж ирсэн практик 2012 он хүртэл байхгүй, авлига, албан тушаалын гэмт хэрэгт хамруулан үздэг байжээ гэж дүгнэж болохоор байна.

САНАЛ:

1. Хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийн хууль зүйн шинжлэх ухааны салбар судлагдахуун бүрээр түүхэн эх сурвалжид тулгуурлан судлан нэгдмэл ойлголт, салбар хоорондын уялдааг тодорхойлох, хууль тогтоомжид хэрэгжилтийн бодит үнэлгээ хийх;
2. Дотоодын эдийн засаг, нийгэмд төдийгүй Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлдөг хууль зүйн хариуцлагыг түүхэн эх сурвалжид дүгнэлт гарган, зарим хариуцлагын төрөл, хэмжээг нэмэгдүүлэх.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ:

Хууль тогтоомж:

А/ Хууль

Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002.

Б/ Бусад акт

Монгол Улсын Эрүүгийн хууль 1986. Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг №217.

Ном, сурах бичиг, гарын авлага:

1. Пэрлээ, Х. Нууц товчоонд үлдсэн хууль цаазын зарим зүйл “Монгол судлал”. Уб., 1962. 3 дугаар боть. 15 дугаар дэвтэр.
2. Содовсүрэн, Б. БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. Уб., 1971.
3. Жалан-Аажав С. Халх журам. Уб., 1995.
4. Эзэн Богд Чингисийн их засаг. Уб., 1995.
5. Лүндээжанцан, Д. Болдбаатар, Ж. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1997.

6. Адьяабазар, Д. Монгол Улсын 1921 оноос хойших Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжилт. I дэвтэр. Уб., 1998.
7. Рязановский, В.А. Монголчуудын хууль, цаазны дурсгал бичгүүдийн түүхэн тойм Их засаг хууль. Уб., 2000.
8. Дагвадорж, Ой. Төрийн сүлд өршөө XII-XIV зууны Монголын хаадын зарлигсын товчоон. 1 боть. Уб., 2011.
9. Адьяабазар, Д. Монгол Улсад залилан мэхлэх гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийн тулгамдсан асуудал. Нэг сэдэвт бүтээл. Уб., 2004.

Цахим эх сурвалж:

www.legalinfo.mn